



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

(ХУУЛЬ, ТОГТООЛ, ЗАРЛИГ,
ШНЙДВЭР, НИЙТЛЭЛ—ХУУЛИЙН
ТАЙЛБАР)

Монгол Улсын Их Хурлын Тамгын газар

№

1994 оны 5 сар

№ 5 (24)

ГАРЧИГ

I. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- | | |
|--|-----|
| 1. Статистикийн тухай | 325 |
| 2. Эрүүгийн байдал шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 335 |
| 3. Эрүүгийн хуулийн зарим зүйл, даалглыг дүрмийн бэлгэдлээр зохиох тухай | 393 |
| 4. Эрүүгийн хуульд зарим нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 394 |

II. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЫН ТОГТООЛ

- | | |
|--|-----|
| 3. Статистикийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим зүйл хэмжээний тухай № 22 | 395 |
| 6. Хуульд өөрчлөлт оруулан боловсруулах, чууламдөр хэлээдүх тухай № 23 | 396 |
| 7. Аймгаар дунгийн тухай № 24 | 397 |
| 8. Эрүүгийн байдал шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хэрэгжүүлэх зарим зүйл хэмжээний тухай № 25 | 398 |
| 9. Зөвлөмж, мэдээлэлтэй холбогдуулах ажил зарим арга хэмжээний тухай № 27 | 399 |
| 10. Улс төрийн зөвшилцөлийн дагуу ажил арга хэмжээний тухай № 28 | 400 |

III. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХНИЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- | | |
|---|-----|
| 11. Зарим шүүгчийг албан тушаалаас чөлөөлөх тухай № 38 | 401 |
| 12. Г. Алсандоржийг Төрийн соёрхол хүртээх зөвлөлийн одлогч дарга, тус зөвлөлийн салбарын даргаар батлах тухай № 46 | 401 |

- | | |
|---|-----|
| 13. Ш. Сүрэнжавыг Төрийн соёрлоо хүртээх зөвлөлийн гишүүнээр батлах тухай № 47 | 402 |
| 14. Лувсандоржийн Мундагбаятарыг элчин сайдын үүрэгт эвлэлд чөлөөлөх тухай № 49 | 402 |
| 15. Хасбаярын Бэлхбатыг элчин сайдаар томилох тухай № 50 | 403 |

IV. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- | | |
|---|-----|
| 16. Хууль зүйн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, давтан сургах, хууль зүйн шинжлэх ухааныг хөгжүүлэх зарим арга хэмжээний тухай № 46 | 404 |
| 17. Журал батлах тухай № 49 | 408 |
| 18. Задуучууд, биеийн тамир, спортын бэйгуулагын тухай № 50 | 414 |

V. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХ

- | | |
|--|-----|
| 19. Монгол Улсын иргэний эрүү мэндийн дэвтгэлийн хуулийн 7 дугаар зүйлийн зарим заалтыг тайлбарлах тухай № 31 | 416 |
| 20. Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуулийн үйлдвэрчний эвлэлүүдийг бүртгэхтэй холбогдсон зарим заалтыг тайлбарлах тухай № 36 | 417 |

VI. НИЙТЭЭЛ, ТАГЛБАР ЗӨВЛӨМЖ

- | | |
|---|-----|
| 21. Монгол улсын статистинийн тухай хуулийн агуулга, онцлог | 420 |
|---|-----|

МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ

1994 оны 3 дугаар
сарын 17-ны өдөр

Ухаалагчид
хот

СТАТИСТИКИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын статистикийн мэдээллийн нэгдсэн тогтолцоо, үйл ажиллагааны зарчим, статистикийн байгууллага, түүнчлэн Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, Монгол Улсын хуулийн этгээд болох аж ахуйн нэгж, байгууллага (энэ хуульд цаашид «статистикийн мэдээлэгч» гэх) -ийн статистикийн мэдээллийн талаар эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхойлж, эдийн засаг, нийгмийн амьдралын бодит байдлыг статистикийн аргаар судлан төр, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг статистикийн мэдээллээр хангах явцад үүсэх харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Статистикийн тухай хууль тогтоомж

Статистикийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон хууль тогтоомжийн холбогдох бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Статистикийн үйл ажиллагаа, түүний зарчим

1. Статистикийн мэдээлэгчээс статистикийн бүртгэл хөтлөх, статистикийн мэдээлэл өгөх, төвлөрүүлэн дамжуулах, нэгтгэн боловсруулах, тооллого, судалгаа явуулах, дүгнэлт гаргах, хэвлэн нийтлэх мэдээллийн үнэн байдлыг хангах, мэдээллийн сан байгуулах, хадгалахыг статистикийн үйл ажиллагаанд хамааруулна.

2. Статистикийн үйл ажиллагаанд дэрвэх зарчим баримтлана:

- 1) шинжлэх ухааны үндэслэл бүхий нэгдсэн арга зүйтэй байх
- 2) статистикийн мэдээлэл нь анхдагч бүртгэлд үндэслэсэн байх
- 3) мэдээлэл шуурхай, үнэн бодитой байх;
- 4) мэдээллийн нууцыг хадгалгах;
- 5) статистикийн үзүүлэлт, арга зүй нь олон улсын статистикийн стандарт, арга зүйтэй нийцсэн байх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Статистикийн мэдээллийн тогтолцоо

4 дүгээр зүйл. Албан ёсны статистикийн мэдээлэл, түүний хэлбэр

1. Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрт зэдсэн болон статистикийн төв байгууллагаас тогтоосон журмын дагуу гаргасан мэдээ, тайлан, тооллого, судалгааны дүнг албан ёсны статистикийн мэдээлэл гэнэ.

2. Албан ёсны статистикийн мэдээлэл төвлөрсөн болон төвлөрсөн бус хэлбэртэй байна.

3. Сум, дүүрэг, баг, хороо, аж ахуйн нэгж, байгууллагаас сум, дүүрэг, аймаг, нийслэлийн статистикийн албадлаар дамжуулан статистикийн төв байгууллагад нэгтгэсэн мэдээ тайлан, тооллого, судалгааны дүнг статистикийн төвлөрсөн мэдээлэл гэнэ. Аж ахуйн нэгж, байгууллагаас нам, тусгай газраар дамжуулан статистикийн төв байгууллагад нэгтгэсэн мэдээллийг статистикийн төвлөрсөн мэдээлэлд хамааруулна.

4. Яам, тусгай газар, аж ахуйн нэгж, байгууллагаас статистикийн төв байгууллагын зөвшөөрсөн үзүүлэлт, аргачлалаар гаргасан мэдээллийг статистикийн төвлөрсөн бус мэдээлэл гэнэ. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргаас нутаг дэвсгэрийнхээ удирдлагын үйл ажиллагаанд тэрэглэх зорилгоор бие даан авч байгаа мэдээллийг статистикийн төвлөрсөн бус мэдээлэлд хамааруулна.

5 дугаар зүйл. Албан ёсны статистикийн мэдээллийн үзүүлэлт, түүнийг гаргах

1. Албан ёсны статистикийн мэдээлэлд дарлахь үндсэн үзүүлэлт хамаарна:

- 1) макро эдийн засгийн статистикийн үзүүлэлт;
- 2) дотоодын нийт бүтээгдэхүүн;

- С) инфляцийн түвшин;
- В) хөрөнгө оруулалт;
- Г) хуримтлал;
- Д) төлбөрийн тэнцэл;
- Е) ажилгүйдэл;
- Ж) мөнгө, зээл;
- З) улс, орон нутгийн төсвийн орлого, зарлага;
- 2) хүн ам, ивэгнийн статистикийн үзүүлэлт;
- 3) хүн амын тоо, нас, хүйс, төрөлт, нас баралт, нөхөр
сэлт;
- б) эдийн засгийн идэвхтэй хүн ам, ажиллагаад;
- в) өрх, хүн амын орлого, зарлага, хэрэглээ;
- г) хүн амын амьжиргааны үзүүлэлт;
- д) хүн амын боловсролын түвшин;
- е) хүн амын эрүүл мэндийн байдал;
- ж) орон сууцны хангамж;
- з) тэтгэвэр, тэтгэмж;
- 3) үйлдвэрлэл, шинжлэх ухаан, соёлын статистикийн
үзүүлэлт:
- а) малын тоо;
- б) хөдөө аж ахуйн гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл;
- в) аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт;
- г) аж үйлдвэрийн гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл;
- д) барилга угсралт, их засварын ажлын хэмжээ;
- е) тээврийн салбарын тээсэн ачаа, зорчигч, ачаа эргэлт,
зорчигч, эргэлт;
- ж) холбооны үйлчилгээний орлого;
- з) экспорт, импортын гол нэр төрөл, хэмжээ;
- и) мэргэжлийн урлагийн байгууллагуудын урам бүтээл,
ажиллагаад;
- г) музей, кино, номын слагийн тоо, тэдгээрийн сан хөмрөг;
- д) сонин, сэтгүүлийн тоо;
- м) эрдэм шинжилгээний ажлын үр дүн, үйлдвэрлэлд
рөнгөрсөн шинэ технологи;
- 4) шүүхийн статистикийн үзүүлэлт:
- а) эрүүгийн хэргийн тоо, төрөл;
- б) шүүхээр шийтгүүлэгчдийн тоо, нас, хүйсний ялгаа;
- в) гэмт хэргийн улмаас учирсан хохирол;
- Г) дамнуурсан аж ахуйн нэгж;
- Д) шүүхийн журмаар гэр бүл цуцлаулсан, хүүхдийн тэт-
гэлэг тогтоолгосон байдал;

- е) захиргааны болон иргэний хэргийн үзүүлэлт;
- б) хүрээлэн байгаа орчны статистикийн үзүүлэлт;
- а) газрын хөрсний хамгаалалт, эвдрэл;
- б) ус ашиглалт, бохирдолт, нэвэрлэгээ, хангалт;
- в) агаарын бохирдол;
- г) ойн хамгаалалт, нөхөн сэргээлт;
- д) ан амьтны тоо, агнуур, дархан цаамтай амьтан.

2. Албан ёсны статистикийн мэдээллийн дэлгэрэнгүй үзүүлэлтийн жагсаалт, гаргах хугацааг Засгийн газар тогтооно.

3. Мөнгөний холбогдолтой статистикийн мэдээллийг Монголбанк, санхүүгийн холбогдолтой статистикийн мэдээллийг Сангийн нэм, гаалийн холбогдолтой статистикийн мэдээллийг Улсын Гаалийн газар, шүүхийн статистикийн мэдээллийг Шүүхийн Тамгын газар болон холбогдох бусад байгууллага тус тус эрхлэн гаргана.

6 дугаар зүйл. Тооллого, судалгаа явуулах

1. Засгийн газар, мэд, тэжээвэр амьтад, хашаа, худгийн тооллогыг жил бүр, аж ахуйн нэгжийн тооллогыг 3 жил, хүн ам, орон сууцны болон үндэсний баялгийн тооллого, судалгааг 10 жил тутам тус тус хийж, салбар хоорондын эдийн засгийн уялдааг холбооны тэнцлийг 5 жил тутам гаргана.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас өөр хугацаанд тооллого, судалгаа явуулах зайлшгүй шаардлага гарвал Засгийн газар Улсын Их Хуралтай энэ талаар зөвшилцөн хугацааг нө тухай бүр тогтооно.

3. Төрийн байгууллагыг албан ёсны статистикийн төвлөрсөн мэдээллээр хангах, статистик ажиглалт, тооллого, тусчар судалгаа явуулах чигээлийг Засгийн газар жил бүрийн 12 дугаар сард батална.

7 дугаар зүйл. Албан ёсны бус статистикийн мэдээлэл, үйл ажиллагаа

1. Энэ хуулийн 4 дүгээр зүйлд зааснаас бусад статистикийн мэдээллийг албан ёсны бус статистикийн мэдээлэл гэнэ.

2. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллага гэрээ, хэлцлийн үндсэн дээр бусад этгээдээс статистикийн мэдээлэл авч албан ёсны бус статистикийн үйл ажиллагаа эрхэлж болно.

3. Энэ зүйлийн 2 дэх хэсэгт заасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хийсэн судалгааныхаа дүнг ивйтэд мэдээлэх бол хэрэглэсэн аргачлалыг хамт мэдээлнэ.

4. Албан ёсны бус статистикийн мэдээлэл авч буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь статистикийн мэдээлэгчийн мэдээллийн нууцыг хадгалах үүрэгтэй.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Статистикийн мэдээлэгчийн эрх, үүрэг

8 дугаар зүйл. Статистикийн мэдээлэгчийн үүрэг

Статистикийн мэдээлэгч нь дараахь үүрэг хүлээнэ:

1) статистикийн мэдээ, тайлан, судалгаа гаргахад шаардагдах анхдагч бүртгэл хөтлөх;

2) статистикийн мэдээ, тайлан, судалгаа, батлагдсан буюу зохиоорөөгдсөн үзүүлэлт, аргачлалын дагуу, тогтоосон хугацаанд үнэн зөв гаргаж өгөх;

3) улсын тооллогод хамрагдах;

4) аж ахуйн нэгж, байгууллага нь зохих журмын дагуу регистрийн дугаар авах;

5) албан ёсны статистикийн мэдээллийг холбогдох байгууллагад өөрийн зардааар хүргэх.

9 дүгээр зүйл. Статистикийн мэдээлэгчийн эрх

Статистикийн мэдээлэгч нь дараахь эрх эдэвнэ:

1) мэдээ, тайлан, судалгааны үзүүлэлт, аргачлалыг боловсронгуй болгох талаар статистикийн байгууллагад санал оруулах;

2) энэ хуульд зааснаас бусад тохиолдолд статистикийн төв байгууллагаас батлаагүй буюу зөвшөөрөөгүй үзүүлэлт, аргачлалаар мэдээ, тайлан, судалгаа гаргаж өгөхөөс татгалзах;

3) өөрийн мэдээллийн нууцыг задруулахгүй байхыг зохих этгээдээс шаардах;

4) статистикийн байгууллагаас гаргасан нийтлэг судалгааны дүн, мэдээлэлтэй танилцах.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Монгол Улсын статистикийн байгууллагын тогтолцоо, бүрэн эрх

10 дугаар зүйл. Статистикийн байгууллагын тогтолцоо

1. Монгол Улсын статистикийн байгууллагын тогтолцоо нь статистикийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэх төрийн захир-

гааны төв байгууллага (яашид статистикийн төв байгууллага гэх), аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын тамгын газрын статистикийн хэлтэс (ажилтан)-ээс бүрдэнэ.

2. Яам, тусгай газар чиг үүргийнхээ дагуу статистикийн үйл ажиллагаа эрхэлнэ.

11 дүгээр зүйл. Статистикийн төв байгууллага, түүний бүрэн эрх

1. Статистикийн төв байгууллага нь статистикийн үйл ажиллагааны нэгдсэн бодлогыг боловсруулж хэрэгжүүлнэ.

2. Статистикийн төв байгууллагыг Засгийн газраас томилсон дарга толгойлно.

3. Статистикийн төв байгууллагын дарга үйл ажиллагаагаа Засгийн газарт хөрөнцөн тайлаглана.

4. Статистикийн төв байгууллага нь дэргэдээ тооцволдох төв, мэдээлэл арилжааны нэгжтэй байж болно.

5. Статистикийн төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) албан ёсны статистикийн үйл ажиллагааг мэргэжлийн талаас төвлөрүүдэн удирдах, боловсролгүй болгох;

2) албан ёсны статистикийн мэдээллийн үзүүдэлт, аргачлал, шаарвар батлах буюу хэмжөөрх, судалгаа, тооллогын баримт салтийг боловсруулах;

3) хүн ам, нийгэм, эдийн засгийн үйл ажиллагаатай холбогдолтой улсын тооллого, нэг удаагийн бүртгэл, түүвэр бодон тусгайлсан нэг бүрэн судалгааг явуулах удирдаж, чиглэл өгч, биеэлдэд нь хяналт тавих;

4) статистикийн үзүүдэлт аргачлалыг олон улсын ангидад, аргачлал, стандартад нийцүүлэх;

5) иргэд аж ахуйн нэгж, байгууллагыг статистикийн мэдээлэл, судалгааны дүнгээр хангах;

6) Монгол Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газрыг тэдгээрийн даалгаврын дагуу статистикийн мэдээллээр үнэ төлбөргүй хангах;

7) статистикийн мэргэжлийн боловсон хүчнийг давтан сургах, мэргэжлийг нь дээшлүүлэх;

8) Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн талаар мэдээлэл, тоо баримтыг гаргах;

9) улсын хэмжээгээр явуулах тооллого, Монгол Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газрын даалгавраар хийх шийтийг хамарсан статистикийн судалгааны ажилд шаардаг-

дах ажилтныг холбогдох байгууллагатай тохиролцон татан оролцуулах;

10) аж ахуйн нэгж, байгууллагын регистрийн сан байгуулах;

11) статистикийн мэдээллийг хяалтн илгээх, мэдээллийн сан байгуулах, хадгалах;

12) орон нутагт статистикийн үйл ажиллагаа явуулахад эргэчилсэн туслалцаа үзүүлэх, статистикийн мэдээллийн сан байгуулахад туслэх;

13) гадаад улс, олон улсын статистикийн болон эдийн засгийн байгууллагатай Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээний дагуу хамтран ажиллах.

12 дугаар зүйл. Улсын статистикийн байцаагч, түүний бүрэн эрх

1. Статистикийн ажилтанд түүний мэргэжлийн ур чадвар, ажлын дадлага, туршлагыг харгалзан статистикийн төв байгууллагын дарга улсын статистикийн байцаагчийн эрх олгоно.

2. Статистикийн төв байгууллагад Улсын статистикийн ерөнхий болон ахлах байцаагч, аймаг, нийслэлд улсын статистикийн ахлах байцаагч, байцаагч, сум, дүүрэгт улсын статистикийн байцаагч тус тус ажиллаж болно.

3. Улсын статистикийн байцаагч нь албан ёсны статистикийн мэдээллийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.

4. Улсын статистикийн байцаагч дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) статистикийн тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих;

2) статистикийн мэдээллийн хамралт, үнэн зөв, шуурхай байдлыг шалгах;

3) энэ хуульд зааснаас бусад тохиолдолд статистикийн төв байгууллагын батлаагүй буюу зөвшөөрөөгүй статистикийн мэдээ, тайланг аж ахуйн нэгж, байгууллагаас албадан гаргуулах, давхардуулан авах, өгөх ажиллагааг зогсоох;

4) албан ёсны статистикийн мэдээ, тайлангийн баримт бичиг үйлдэх, анхан шатны бүртгэл хөглөх, мэдээ, тайланг үнэн зөв гаргаж мэдээлэх журмын талаар зөвлөмж өгөх;

5) хяналт, шалгалтын ажилд зайлшгүй шаардагдэх баримт сэлт, тайлбар, лавлагааг холбогдох албан тушаалтнаар гаргуулан авах;

б) шалгалтын дүнг мэдээлэх, өлөрсөн зөрчил, дутагдлыг арилгах талаар холбогдох албан тушаалтанд шаардлага тавих;

7) статистикийн тухай хууль тогтоомж зорцсон гэм буруутай этгээдэд зохих хууль тогтоомжийн дагуу захиргааны хариуцлага хүлээлгэх.

5. Статистикийн байцаагчаас эрх хэмжээнийхээ хүрээнд өгсөн үүрэг, тавьсан шаардлагыг холбогдох албан тушаалтанд иргэд, аж ахуйн нэгж, байгууллага зэвсгэл биелүүлэх үүрэгтэй.

13 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын статистикийн мэдээллийн талаарх бүрэн эрх

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга статистикийн үйл ажиллагааг тухайн нутаг дэвсгэртээ хариуцан гүйцэтгэж, статистикийн мэдээллийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) нутаг дэвсгэртээ байгаа статистикийн мэдээлэгчдээс статистикийн мэдээллийг хугацаанд нь гаргуулан авч илгээх, судалгаа, дүгнэлт хийж шингэлэх, албан ёсны статистикийн төвлөрсөн мэдээллийг хугацаанд нь зохих дээд шатны байгууллагад өгөх;

2) статистикийн төв байгууллагаас өгсөн чиглэл удирдамжийн дагуу статистикийн тооллого, түүнэр судалгааг зохион байгуулж явуулах;

3) засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийнхээ удирдлагын үйл ажиллагаанд хэрэглэх зорилгоор, албан ёсны статистикийн бусад мэдээлэлтэй давхардууламгүйгээр статистикийн мэдээллийг бий болгох;

4) нутаг дэвсгэрийн статистикийн мэдээллийн сан байгуулах.

14 дүгээр зүйл. Баг, хорооны Засаг даргын статистикийн мэдээллийн талаарх бүрэн эрх

Баг, хорооны Засаг дарга статистикийн үйл ажиллагааг тухайн нутаг дэвсгэртээ хариуцан гүйцэтгэж статистикийн мэдээллийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) хүн ам, өрхийн бүртгэл хөтлөх;

2) хүн амын амьжиргааны түвшингийн судалгаа хийх;

3) мал, тэжээвэр амьтад, эд хөрөнгийн тооллого, бүртгэл явуулах;

4) үйлдвэрлэл, үйлчилгээний талаар мэдээ, судалгаа авах, гаргах;

5) зохих ангилэлийн дагуу явуулах статистикийн ажиглалт, тооллого, түүвэр судалгааг зохион байгуулж явуулах;

6) албан ёсны статистикийн мэдээллийг тогтоосон хугацаанд зохих дээд шатны Засаг даргад өгөх.

15 дугаар зүйл. Яам, тусгай газрын статистикийн мэдээллийн талаарх бүрэн эрх

Яам, тусгай газар статистикийн мэдээллийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ;

1) албан ёсны статистикийн төвлөрсөн мэдээллийг тогтоосон хугацаанд гаргаж өгөх;

2) статистикийн төв байгууллагаас холбогдох статистикийн мэдээллийг авч ашиглах;

3) салбарын удирдлагын үйл ажиллагаанд хэрэглэх зорилгоор албан ёсны статистикийн төвлөрсөн бус мэдээлэл авах, мэдээллийн санг бий болгох;

4) улсын хэмжээнд тухайн мэдээллээр давхардал бий болгохгүй байх зорилгоор статистикийн төвлөрсөн бус мэдээлэл авах талаар статистикийн төв байгууллагаас зөвшөөрөл авах.

ТАВДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

16 дугаар зүйл. Статистикийн мэдээллийг хууль бусээр ашиглах, мэдээллийн нууцыг хадгалах

1. Холбогдох этгээдээс эзэмшиж буй эрхээ хэтрүүлэн хуулийн ашиг хонжоо олох зорилгоор статистикийн мэдээллийг ашиглахыг хориглоно.

2. Хэрэглэгчдээс албан ёсны статистикийн мэдээлэл, судалгааны дүнг дур мэдэн өөрчлөх, засварлахыг хориглоно.

3. Боловсруулалт нь албан ёсоор мэдээлэх хэмжээнд хүрээгүй байгаа, мөн үндэсний эрх ашигтай холбоотой гэж зохих эрх бүхий байгууллагаас нууцалсан, эсхүл иргэд, ажлуын нэгж, байгууллагын нууцад хамаарах мэдээллийн нууцыг задруулах, нийгэд мэдээлэхийг хориглоно.

17 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

1. Статистикийн тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол зохих журмын дагуу захиргааны хариуцлага хүлээлгэнэ.

2. Улсын статистикийн байцаагчаас иргэд, албан тушвалтанд ногдуулсан захиргааны шийтгэлийн талаар гарсан гомдлыг шүүхийн журмаар шийдвэрлэнэ.

Монгол Улсын Их Хурлын
дэргэ

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ

1994 оны 3 дугаар
сарын 28-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн да-
раархь зүйл, хэсэг, заалтад дор дурдсан нэмэлт, өөрчлөлт
оруулсугай:

1) 1 дүгээр зүйл:

«1-р зүйл. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны журам
Монгол Улсын нутаг дэвсгэр дээр Эрүүгийн байцаан шийт-
гэх ажиллагааг энэ хуульд заасан журмын дагуу явуулна.»

2) 4 дүгээр зүйл:

«1-р зүйл. Гэмт хэргийг илрүүлэх үүрэг

Гэмт хэргийн шинж тэмдэг илэрсэн тухайд прокурор, мөр-
дөн байцаагч, хэрэг бүртгэх байгууллага өөр өөрсдийн эрх
хэмжээний дотор гэмт хэрэг гарсан байдал, гэмт хэрэг үйлд-
сэн этгээдийг олж тогтоох талаар хуульд заасан шарадлага-
тай арга хэмжээ авах үүрэгтэй.»

3) 6 дугаар зүйл:

«6-р зүйл. Эрүүгийн хэрэгт байцаан шийтгэх
ажиллагаа явуулж болохгүй тохиолдлууд

Дор дурдсан тохиолдолд эрүүгийн хэрэг үүсгэхгүй бөгөөд
хэрэг үүсгэсэн бол хэрэг бүртгэгч, мөрдөн Сайцаагч, проку-
рор, шүүх хэргийг хэрэгсэхгүй болгоно:

1) гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй;

2) ашиг хэлэлцэх хугацаа дууссан;

3) үйлдсэн гэмт хэрэгт өл шогдуулах явдлыг өршөөл
үзүүлэх тухай хуулиар хэрэгсэхгүй болгосон;

4) дохиогчийн гомдлосор үүсэх хэрэгт гомдол гараагүй
буюу дохиогч нь далаагдагчтай эвлэрсэн, (Энэ хуулийн 29
дүгээр зүйл ба 2, 3 дахь хэсэгт заасан тохиолдол үүнд ха-
маарахгүй);

5) хэрэгт холбогдогч нас барсан (нас барсан хүнийг цагаатгах, эсхүл бусад хүмүүст холбогдох нөхцөл байдал шинээр илэрснээс уг хэргийг сэргээн хэлэлцэх явдал үүнд хамаарахгүй);

6) тухайн хэргийн талвар шүүхээс урьд гаргасан таслан шийдвэрлэх тогтоол, магадлал, хэргийг хэрэгсэхгүй болгосон эрх бүхий байгууллагын тогтоол хүчинтэй байгаа.

Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасан тохиолдолд шүүх цагаатгах таслан шийдвэрлэх тогтоол, 3-д заасан тохиолдолд таслан шийдвэрлэх шийтгэх тогтоол гаргаж шийтгэгдсэн этгээдийг ялаас чөлөөлнө.

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, 3-д заасан үндэслэлээр хэрэг хэрэгсэхгүй болгосныг яллагдагч, түүний өмгөөлөгч, 5 дахь хэсэгт заасан үндэслэлээр хэрэг хэрэгсэхгүй болгосныг яллагдагчийн өмгөөлөгч, төрөл садны хүмүүс эс зөвшөөрвөл гомдлоо шүүхэд гаргана. Энэ тохиолдолд шүүх байцаан шийтгэх ажылаагаат ердийн журмаар явуулж яллагдагчийн гэм буруутай эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

4) 12 дугаар зүйл:

«12-р зүйл. Хүний халданшгүй эрхийг хангах

Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжиж, баривчилж, хорьж, мөрдөн мөшгөж, эрх чөлөөг нь хязгаарлаж үл болно.

Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, нэр төрийг нь доромжилж, хүнлэг бус, хэргийн хандаж болохгүй.»

5) 13 дугаар зүйл:

«13-р зүйл. Иргэний хувийн болон гэр бүл, захидал харилцааны нууц орон байрны халданшгүй байдлыг хамгаалах

—Иргэний хувийн болон гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халданшгүй байдлыг хуулиар хамгаалиа.

Иргэний орон байрыг нэгжих, хувийн хадгаламж, захидал харилцаа, бусад бичиг баримт болон эд хөрөнгөнд үзлэг хийх, битүүмжлэх, хураан авах явдлыг зөвхөн хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулна.»

6) 15 дугаар зүйл:

«15-р зүйл. Хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх

Монгол Улсад хун бүр үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил,

дабан тушаал, шатны шүүгчээ, үзэл бодол, боловсролоор ял-
ганарлахгүйгээр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.

7) 16 дугаар зүйл:

«16-р зүйл. Эрүүгийн хэрэг хяналцах шүүх бүрэлдэхүүн.

Энэ хуулийн 16^д дүгээр зүйлд заасан хэргийг шүүгч хяна-
саар, бусад хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр янхан
шатны журмаар хянан шийдвэрлэнэ.

Давж ялалдах шатны журмаар хэргийг 3 шүүгч хянан
шийдвэрлэнэ.

Улсын дээд шүүх нийт шүүгчийн олонхийн бүрэлдэхүүн-
тэйгээр хяналтын шатны журмаар хэргийг хянан шийдвэр-
лэнэ»

8) 16^д дүгээр зүйл:

«16-р зүйл. Шүүгч дангаар хянан шийдвэрлэх гэмт
хэргүүд

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 76 дугаар зүйл, 77 ду-
гаар зүйлийн 1 дэх хэсэг, 79, 79^д, 93—101 дүгээр зүйл, 103
дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 104—107 дугаар зүйл, 108
дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 109 дүгээр зүйлийн 1, 2 дахь
хэсэг, 110 дугаар зүйл, 111 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг,
112 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 115, 115 дугаар зүйл, 117 ду-
гаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 118—120 дугаар зүйл, 121 дү-
гээр зүйлийн 1 дэх хэсэг, 123 дугаар зүйлийн 1, 2 дахь хэ-
сэг, 124 зүйгээр зүйлийн 1 дэх хэсэг, 126 дугаар зүйлийн 1 дэх
хэсэг, 127 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 129 дүгээр зүйл, 130
дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 131—133 дугаар зүйл, 134 дү-
гээр зүйлийн 1 дэх хэсэг, 135 дугаар зүйл, 137 дугаар зүй-
лийн 1 дэх хэсэг, 138, 142, 144 дүгээр зүйл, 145^д дугаар зүй-
лийн 1 дэх хэсэг, 145, 147 дугаар зүйл, 148 дугаар зүйлийн
1 дэх хэсэг, 149, 151^д, 152^д, 163—168, 169^д, 170 дугаар зүйл,
171 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 171^д дүгээр зүйл, 172^д дүгээр
зүйлийн 1 дэх хэсэг, 174 дүгээр зүйл, 175^д дүгээр зүйлийн 1
дэх хэсэг, 176^д, 178—180, 182, 184, 186, 187, 188, 190,
191, 191, 196 дугаар зүйл, 211 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг,
212 дугаар зүйл, 213 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 216, 224,
225, 226, 228, 230—234, 236—238 дугаар зүйл, 239 дүгээр
зүйлийн 1, 2 дахь хэсэг, 240, 242, 243 дугаар зүйл, 244 дүгээр
зүйлийн 1 дэх хэсэг, 245 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 248
дугаар зүйл, 249 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 250—252,
255—259 дүгээр зүйл, 262 дугаар зүйлийн 1 дэх хэсэг,
261—263, 265 дугаар зүйл, 267 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

270 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 271 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 272 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 273 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 275 дугаар зүйл, 276 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 277 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 278 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 279 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 281 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 282 дугаар зүйлийн 1, 2, 3, 4 дэх хэсэг, 283 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 284 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 285 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 287 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 288 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 289 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 290 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 292 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 293 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 301 дүгээр зүйлд заасан гэмт хэргийг шүүгч дансаар шийдвэрлэнэ.

Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг эхдрээ төвөгтэйн улмаас хамтын зөрчмөөр хянан шийдвэрлэх шаардлагатай гэж шүүгч үзвэл уг асуудлыг шүүгчийн саналыг үндэслэн тухайн шүүхийн Ерөнхий шүүгчийн захирамжаар шийдвэрлэнэ.

9) 16² дугаар зүйл:

«16²-р зүйл. Эрүүгийн хэргийг хамтран хянан шийдвэрлэхэд иргэдийн төлөөлөгч оролцуулах

Шүүх анхан шатны журмаар эрүүгийн онц хүнд гэмт хэргийг хамтран хянан шийдвэрлэхэд 3, хүнд гэмт хэргийг хамтран хянан шийдвэрлэхэд 2, бусад гэмт хэргийг хамтран хянан шийдвэрлэхэд 1 иргэдийн төлөөлөгчийг оролцуулна.»

10) 17 дугаар зүйл:

«17-р зүйл. Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдах

Эрүүгийн хэргийг шийдвэрлэхдээ шүүгч хараат бус байж гагцхүү хуульд захирагдана.»

11) 17¹ дүгээр зүйл:

«17¹-р зүйл. Гэм буруугийд тооцох

Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно.

Эрүүгийн хэрэгт хамраалтай бүхий л нотлох баримтыг шалгасан боловч яллагдагчийн гэм буруутай эсэхэд эргэлзээ төрөөл түүнийг яллагдагчид ашигтайгаар, шийдвэрлэнэ. Түүнчлэн эрүүгийн болон эрүүгийн байдсан шийтгэх хуулийг тайлбарлах, хэрэглэхэд гарах эргэлзээг яллагдагчид ашигтайгаар шийдвэрлэнэ.»

12) 19 дүгээр зүйл:

«19-р зүйл. Шүүх хуралдааныг нээлттэй явуулах

Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хамгаалахаас бусад тохиолдолд бүх шатны шүүхийн шүүх хуралдааныг нээлттэй явуулна. Хэрэв шүүх хуралдааныг хаалттай явуулсан бол шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийг нийтэд уншиж сонсоно.»

13) 20 дугаар зүйл:

«20-р зүйл. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг өмгөөлүүлэх эрхээр хангах

Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх, хууль зүйн бусад туслалцаа авах эрхтэй.

Хэрэг бүртгэх байгууллага, мөрдөн байцаагч, прокурор-шүүх нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг өмгөөлүүлэх бололцоогоор хангах, түүний хувийн болон эд хөрөнгийн эрхийг хамгаалах талаар хуульд заасан арга хэмжээ авах үүрэгтэй.

Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн өмгөөлүүлэх эрхийг зөрчсөн нь шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болно.»

14) 20¹ дүгээр зүйл:

«20¹-р зүйл. Шүүх хуралдааны мэтгэлзэх зарчим

Эрүүгийн хэргийг анхан шатны болон давж заалдах шатны журмаар хянан хэлэлцэх шүүх хуралдаан мэтгэлзэх зарчмын үндсэн дээр явагдана.

Хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцэхэд яллах болон өмгөөлөх ажиллагааг тус тусад нь явуулна.

Яллагч, шүүгдэгч, түүний өмгөөлөгч, түүнчлэн хохирогч, иргэний нэхэмжлэгч, хариуцагч, тэдний төлөөлөгч шүүх хуралдаанд оролцож хэргийг үнэн зөвөөр шийдвэрлэхэд ач холбогдолтой бүхий л асуудлаар нотлох баримт гаргах, түүнийг шинжлэн судлахад оролцох, хүсэлт гаргах, үг хэлэх ажил эрхтэй байна.»

15) 21 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:

«Шүүх, прокурор, мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгч нь сэжигтэн яллагдагч, шүүгдэгчийг өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх,

хүч хэрэглэхийг хориглоно. Түүндэн иллагдагчийг гэр бүлийн гишүүд, эцэг, эх, үр хүүхдээс нь түүний эсрэг мэдүүрэг өгөхийг шаардаж болохгүй.»

16) 26 дугаар зүйл:

«26-р зүйл. Дээд шатны шүүхээс доод шатны шүүхийг шийдвэрийг хянан шийдвэрлэх.

Аймаг, нийслэлийн шүүх нь сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн хэргийг давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэнэ.

Улсын Дээд шүүх нь аймаг, нийслэлийн шүүхээс хянан шийдвэрлэсэн хэргийг давж заалдах болон хяналтын шатны журмаар хянан шийдвэрлэнэ.»

17) 34 дүгээр зүйл:

«34-р зүйл. Энэ хуульд заасан нэр томъёоны тайлбар

Энэ хуульд заасан нэр томъёонууд нь хэрэн тусгайлан заасан зүйлгүй бол доорхи утгыг хадгална:

1) «шүүх»—Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүх;

2) «анхан шатны шүүх»—эрүүгийн хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх шүүх;

3) «давж заалдах шатны шүүх»—эрүүгийн хэргийг давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэх шүүх;

4) «хяналтын шатны шүүх»—Улсын дээд шүүх;

5) «шүүгч»—бүх шатны шүүхийн ерөнхий шүүгч, шүүгч;

6) «прокурор»—Улсын ерөнхий прокурор, түүний харьяа прокурорууд;

7) «мөрдөн байцаах албаны дарга»—мөрдөн байцаах байгууллагын газар, хэлтэс, тасгийн дарга, тэдгээрийн орлогчид;

8) «мөрдөн байцаагч»—мөрдөн байцаах байгууллагын мөрдөн байцаагч;

9) «хэрэг бүртгэгч»—хуулиар хэлэг бүртгэх эрх олгогдсон албан тушаалтан;

10) «гэр бүлийн гишүүд»—сэжигтэй, ястагаарч, шүүгдэгчтэй нэг гэрт амьдарч байгаа эхнэр, эмхэр, төрсөн болон үрчилж авсан хүүхэд, төрөл садим хүмүүс;

11) «үр хүүхэд»—төрсөн болон үрчилж авсан хүүхэд, эхнээ, жигч, гуч;

12) «хууль ёсны төлөөлөгч»—иллагдагч буюу дохиогчийн төрсөн болон үрчилж авсан эцэг, эх, эсрэн хамгаалагч, хэр-

галзан дэмжигч, иллагдагч, хохирогчийг харгалзан дэмжинэ байдаг байгууллагын төлөөлөгч;

13) «сөрөл садан» — төрсөн болон үрчилж авсан эцэг, эх, төрсөн букоу үрчилж авсан хүүхэд, эх, эгц, дүү, өвөг эцэг, эмэг эх, хадам эцэг, эх, ач, дээ;

14) «таслан шийдвэрлэх тогтоол» — шүүгчийн гэм буруутай эсэх, түүнд ял шийтгэл оногдуулах эсэх талаар гаргасан шүүхийн шийдвэр;

15) «саягдал» — давж эвэлдэх шатны журмаар хэргийг хянаад гаргасан шүүхийн шийдвэр;

16) «тогтоол» — Улсын дээд шүүхээс анхан шатны болон давж эвэлдэх шатны шүүхийн шийдвэрлэсэн хэргийг хянаад гаргасан шийдвэр, мөрдөн байцаах, хэрэг бүртгэх ажиллагааны талаар мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгч, прокуророос гаргасан яллах дүгнэлтээс бусад шийдвэр;

17) «шүүгчийн захирамж» — эрүүгийн хэргийг шийдвэрлэх асуудалтай холбогдуулаж гаргасан таслан шийдвэрлэх тогтоолоос бусад шүүсч дангаараа гаргасан бүх шийдвэр;

18) «прокурорын дүгнэлт» — прокуророос шүүх хурал дээр зуульд дурдсан тохиолдлуудад гаргасан санал;

19) «сөөний цаг» — орон нутгийн цагаар 22 цагаас дараа өдрийн 06 цаг хүртэл;

18) 35 дүгээр зүйл;

«35-р зүйл, Аймаг, нийслэлийн шүүх, сум болон сум дундын, дүүргийн шүүхээс харьяалан анхан шатны журмаар хянан шийдвэрлэх хэргүүд

Эрүүгийн хуульд заасан онц хунд гэмт хэргийг аймаг, нийслэлийн шүүх, бусад хэргийг сум болон сум дундын, дүүргийн шүүх анхан шатны журмаар хянан шийдвэрлэнэ.»

19) 41 дүгээр зүйл;

«41-р зүйл, Эрүүгийн хэргийг харьяаллын дагуу шилжүүлэх

Хэрэг тухайн шүүхэд харьяалагдахгүй байвал шүүгчийн захирамжаар харьяалах шүүхэд шилжүүлнэ.

Уг хэрэг өдл эрх бүхий өөр шүүхэд харьяалагдах нь шүүх хуралдаан дээр мэдэгдсэн бөгөөд хэргийн байдлыг бүрэн бодитойгоор тогтооход нөлөөлөхөөргүй байвал шүүх хуралдааны ажиллагаанд үргэлжлүүлэн явуулна. Харин уг хэрэгдээд букоу доод шатны шүүхэд харьяалагдахаар байвал харьяалах шүүхэд заавал шилжүүлнэ.»

20) 42 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

«Хэргийг нэг шүүхээс нөгөөд шилжүүлэх асуудлаар маргаан гарвал аймаг, нийслэлийн шүүхийн харьяалалтай хэргийн хувьд Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн захирамжаар, сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн харьяалалтай хэргийн хувьд аймаг, нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгчийн захирамжаар шийдвэрлэнэ. Аймаг, нийслэлийн Ерөнхий шүүгчийн захирамжийн талаар маргаан гарвал Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч эцэслэн шийдвэрлэнэ.»

21) 44 дүгээр зүйлийн 3, 4, 5 дахь хэсэг:

«Яллагдагчийн эрх: ямар хэрэгт яллагдаж байгаагаа мэдэх, өөрийгөө өмгөөлөх, энэ хуулийн 45 дугаар зүйлд заасан үеэс эхлэн өмгөөлөгч авах, сонстосон ялын талаар санал хэлэх, баримт сэлт гаргаж өгөх, нотлох баримтыг шалгуулах хүсэлт гаргах, өөрийн эсрэг болон зөрүүтэй мэдүүдэг өгч байгаа этгээдтэй нүүрэлдэх, мөрдөн байцаалт дуусмагч хэргийн материалтай танилцаж түүнээс төр, байгууллага, хувь хүний нууцад үл хамаарах нотлох баримтыг өөрийн зардалаар хувилах, хуулбарлан авах, анхан шатны болон давж заалдах шатны шүүх хуралдаанд оролцох, шүүгч, прокурор, мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, хэлмэрч, шинжээчийг татгалзах, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн ажиллагаанд гомдол гаргах, эх хэлээрээ ярих, хэлмэрч авах, өмгөөлөгчтэйгээ ганцаарчлан уулзах, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн зөвшөөрснөөр хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд оролцох, шүүх хуралдаан дээр эцсийн үг хэлэх, шүүхийн шийдвэрийг давж заалдах, давж заалдсан гомдол, эсэргүүцэлтэй танилцах түүнд тайлбар өгөх.

Яллагдагч өөрийнхөө эсрэг мэдүүдэг өгөх, түүнчлэн өөрийн гэм буруутгүйг болон хэргийн бусад байдалыг нотлох үүрэг хүлээхгүй.

Яллагдагчийн үүрэг: хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхээс дууссан цагт хуралдан ирэх, биед үзлэг хийх, шинжилгээ хийхээр хэн хэлбэр авах, эмнэлгийн байгууллагад шилжүүлэх тухай хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорын тогтоол болон байцаан шийтгэх ажиллагааны явцад эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан бусад шийдвэрийг биелүүлэхэд саад хийхгүй байх, хэргийг бүртгэх, мөрдөн байцаах болон шүүх хуралдааны журмыг сахих.»

22) 45 дугаар зүйл:

«45-р зүйл. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд өмгөөлөгч оролцох

Гэмт хэрэг үйлдсэн ивдэлд сөрдөгдөж албадан саатуулагдсан буюу байцаагдах үеэс эхлэн хэрэгт өмгөөлөгч оролцох эрхтэй.

Хэргийнхээ талаар харилцан эсрэг сонирхолтой хэд хэдэн яллагдагчдыг нэг өмгөөлөгч өмгөөлж болохгүй.

Шүүгч, прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч эрүүгийн хэрэгт өмгөөлөгчөөр оролцож болохгүй.»

23) 46 дугаар зүйл:

«46-р зүйл: Өмгөөлөгчийг сонгон авах

Сэжигтэн, яллагдагч өөрөө өмгөөлөгчөө сонгон авна. Сэжигтэн, яллагдагчийн зөвшөөрснөөр буюу хүссэнээр түүний төрөл садны хүмүүс, хууль ёсны төлөөлөгч нь өмгөөлөгчийг сонгон авч болно.

Хэрээ сэжигтэн, яллагдагч өмгөөлөгчөө сонгон аваагүй бол түүний хүсэлтээр уг хэрэгт өмгөөлөгч оролцох боломжийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор буюу шүүх хлигах бөгөөд өмгөөлөгчөө сонгоход нь тодорхой хүний нэр зэмж тулгаж болохгүй.

Сэжигтэн, яллагдагчийн сонгож авсан өмгөөлөгч уг хэрэгт оролцох боломжгүй болсон, түүнчлэн өмгөөлөгчөөсөө татгалдсан бол сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч өөр өмгөөлөгч сонгон авна.»

24) 49 дүгээр зүйл:

«49-р зүйл. Өмгөөлөгчийн үүрэг, эрх

Өмгөөлөгч нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг цагаатгах буюу түүний хариуцлагыг хөнгөрүүлэх байдлыг тодорхой болгох зорилгоор хуульд заасан бүх арга хэмжээг авах бөгөөд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид шаардагдах хуульгүйн туслаанаа үзүүлэх үүрэгтэй.

Хэрэгт оролцох талаар тохиролцсон буюу томилогдсон үеэс өмгөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр өөрийн үүрэгээ татгалзах эрхгүй.

Өмгөөлөгч хэрэгт оролцох үеэс эхлэн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчтэй ганцарчлан уулзах, тэдгээрийг байцаахад байлцах, дуулиг тавих, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн зөвшөөрснөөр гэрч, хохирогч, шинжээчийг байцаахад байлцаж

тэдгээрт асуулт тавих, сэжигтэн, илалдагч буюу омгөөлөгчийн хүсэлтээр хийгдэж байгаа хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд байцааж тухайн ажиллагаанд оролцож байгаа гэрч, шинжээч болон бусад этгээдэд аль ч үед асуулт тавих, өөрийнхөө байлцсан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааг протоколд бүрэн зөв бичсэн эсэх тухай саналаа бичгээр гаргах, өөрсдийнх нь зөвшөөрснөөр байгууллага, хувь хүнээс тайлбар, тодорхойлолт гаргуулж авах, хэрэгт ач холбогдол бүхий баримт бичиг хуулбарлах, дууны болон дүрс бичлэг хийх замаар баримт сэлт гаргаж өгөх, хүсэлт гаргах, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт дууснагч хэргийн бүх материалтай танилцаж, тэр, байгууллага хувь хүний нууцад үл хамраах нотлох баримтыг өөрийн зардлаар хувилах, хуулбарлан авах, анхны шатны болон давж заалдах шатны шүүх хуралдааны ажиллагаанд оролцох, шүүгч, прокурор, мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгч, иргэдийн төлөөлөгч, тээмэрч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг тагалаах, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн ажиллагаа, шийдвэрт гомдол гаргах, шинжээчийн дүгнэлт гаргуулах хүсэлт тавих эрхтэй.»

25) 49¹ дүгээр зүйл:

«49¹-р зүйл, Иргэдийн төлөөлөгчдийн эрх, үүрэг

Иргэдийн төлөөлөгч хэргийн бүх материалтай танилцах, түүнээс хэрэгсээтэй зүйлийг тэмдэглэж авах, шүүхийн байцаалтад оролцож, шүүгдэгч, хохирогч, гэрч, шинжээчид асуулт тавих, нэмэлт нотлох баримтыг судлах талаар хүсэлт тавих, шүүх хуралдааны протоколтой танилцах, түүнд засвар оруулах хүсэлт гаргах, шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрвөл давж заалдах гомдол гаргах эрхтэй.

Иргэдийн төлөөлөгч өөрийн дотоод итгэл, эрхийн үзэмэрыг үндэслэн шүүх хуралдаан дээр шинжлэн судалсан бүх нотлох баримтыг үнэлж, хэргийн бүх байдлыг тал бүрээс нь нягт нямбай, бүрэн гүйцэл, бодит байдлаар нь судалж үзэсний үндсэн дээр шүүгдэгч гэм буруутай эсэх талаар дүгнэлтээ бичгээр өгөх үүрэгтэй. Иргэдийн төлөөлөгч эрүүд мөндийн болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар дүгнэлтээ бичгээр гаргах боломжгүй бол энэ талаар шүүх хуралдааны протоколд тэмдэглүүлж дүгнэлтээ амаар гаргаж болно.»

26) 49^д дугаар зүйл:

«49^д-р зүйл, Шүүх хуралдаанд оролцох иргэдийн төлөөлөгчийг томилгох

Шүүх хуралдаанд тухайн шүүхийн харьяалах нутаг дэвсгэрээс сонгогдсон иргэдийн төлөөлөгчийг оролцуулна.

Шүүх хуралдаанд оролцох иргэдийн төлөөлөгчийг элэ хуулийн 57 дугаар зүйлийн заалтыг удирдлага болгон тухайн шүүх хуралдаан даргалагч томилно.»

27) 50 дугаар зүйл:

«50-р зүйл, Сэжигтэн, түүний эрх

Дор дурдсан этгээдийг сэжигтнээр тооцож, үндэслэл бүхий тогтоол гаргана:

1) уг этгээдийг гэмт хэрэг үйлдэж байх үед буюу үйлдсэн дор нь барьсан;

2) үзсэн хүн буюу хохирогч гэмт хэрэг үйлдсэн этгээдийг шууд заасан;

3) уг этгээдийн бие, хувиас, орон байранд нь гэмт хэргийн үл мөр тодорхой илэрч олдсон;

4) уг этгээд хэргээ илчлэн ирсэн;

5) гэмт хэргийг сэрдэгдэх үндэс бүхий бусад баримт байгаа бол,

Тухайн ямар хэрэгт сэрдэгдэж байгааг сэжигтэнд тэр даруй, түүний тэр бүлийнхэн буюу өмгөөлөгчид нь 48 цагийн дотор илгэдэнэ.

Сэжигтэн нь ямар хэрэгт сэрдэгдэж байгаагаа мэдэх, энэ хуулийн 45 дугаар зүйлд заасан үзэс өмгөөлөгч авах, баримт салт гаргаж өгөх, нотлох баримт шалгуулах хүсэлт гаргах, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, хэлмэрч, шинжээчийг талгалзах, эх хэлээрээ ярих, хэлмэрч авах, өмгөөлөгчтэйгээ галшаарчлан уулзах, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн зөвшөөрснөөр байцалын шийтгэх ажиглагаанд оролцох, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорын үйл ажиглаган, шийдвэрт гомдол гаргах эрхтэй.

Хэрэг бүртгэлт буюу мөрдөн байцаалтын нөхцөлд гэмт хэргийг сэрдэх үндэстгүй болсон бол хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч буюу прокуророос энэ тухай уг этгээдэд бичгээр мэдэгдэнэ.

Сэжигтэн өөрийн эсрэг мэдүүдэг өгөх, түүнчлэн гэмт хэргийг холбогдолгүйг болон хэргийн бусад аливаа байдлыг нотлох үүрэг дүлээхгүй.»

28) 51 дүгээр зүйл:

«51-р зүйл, Хохирогч

Гэмт хэргийн улмаас нэр төр, алдар хүнд, санаа сэтгэл, бие махбодь, эд хөрөнгийн талаар хохирол хүлээсэн этгээдийг хохирогч гэнэ. Иргэнийг хохирогчоор тогтоохдоо хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шүүх тогтоол, шүүгч захирамж гаргана.

Хохирогч болон түүний төлөөлөгч өмгөөлөгч авах (энэ заалт нь өмгөөлөгч төлөөлөгчөөр оролцож байгаа тохиолдолд хамаарахгүй), баримт сэлт гаргаж өгөх, нотлох баримт шалгуулах хүсэлт гаргах, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт дууссан үеэс эхлэн хэргийн материалтай танилцах, шүүх хуралдааны ажиллагаанд оролцох, асуулт тавих, шүүгч, прокурор, мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, хэлмэрч, шинжээчийг татгалзах, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн үйл ажиллагаа, шийдвэрт гомдол гаргах, эх хэлээрээ ярих, хэлмэрч авах, шүүхийн шийдвэрийг давж заалдах, шүүхийн шийдвэрийг давж заалдсан гомдол, эсэргүүцэлтэй танилцаж тайлбар гаргах эрхтэй.

Өмгөөлөгч нь хохирогчоос итгэмжлэлээр олгогдсон эрхийг эдэлнэ.

Гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан бол энэ зүйлд заасан эрхийг түүний ойрын төрөл садны хүмүүс эдэлнэ.»

29) 55 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

«Хэлмэрч санаатайгаар буруу хэлмэрчилбэл түүнд Эрүүгийн хуулийн 205 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.»

30) 57 дугаар зүйл:

«57-р зүйл, Эрүүгийн хэрэг хэлэлцэхэд шүүгч оролцож болохгүй үндэслэл

Эрүүгийн хэргийг хэлэлцэхэд шүүгч оролцож болохгүй үндэслэл:

1) хэрэв шүүгч нь гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, эсхүд тэдгээрийн хууль ёсны төлөөлөгчөөр оролцож байгаа бол;

2) хэрэв шүүгч нь хохирогч, иргэний нэхэмжлэгч; иргэний хариуцагчийн буюу тэдний төлөөлөгчдийн төрөл садан, эсхүд яллагдагчийн буюу түүний хууль ёсны төлөөлөгчийн төрөл садан, түүнчлэн ялагч, өмгөөлөгч, мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгчийн төрөл садан байвал;

3) хэрэв шүүгч өөрөө шууд буюу шууд бусаар э.э хэрэгт хунийн сонирхолтой байна гэж үзэх бусад үндэслэл байгаа бол.

Эрүүгийн хэрэг хэлэлцэж байгаа шүүх бүрэлдэхүүнд хоорондоо төрөл садны холбоотой шүүгч оролцож болохгүй. Анхан шатны шүүх бүрэлдэхүүнд орсон шүүгчийг төрөл садны хүмүүс уг хэргийг давж заалдах болон хяналтын журмаар хянан хэлэлцэх шүүх бүрэлдэхүүнд орж болохгүй.»

31) 58 дугаар зүйл:

«58-р зүйл. Хэрэг хэлэлцэхэд шүүгч дахин оролцож болохгүй үндэслэл

Эрүүгийн хэргийг анхан шатны журмаар хянан хэлэлцэхэд оролцсон шүүгч уг хэргийг давж заалдах болон хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан хэлэлцэх, түүнчлэн түүний оролцоотойгоор хэргийг хэрэгсэхгүй болгохоор гарсан таслан шийдвэрлэх тогтоол, магадлалыг хүчингүй болгосон бол анхан шатны журмаар дахин хэрэг хэлэлцэхэд оролцож болохгүй.

Давж заалдах шатны шүүхэд хэрэг хянан хэлэлцэхэд оролцсон шүүгч уг хэргийг анхан шатны буюу хяналтын журмаар хянан хэлэлцэх, түүнчлэн түүний оролцоотойгоор гарсан магадлалыг хүчингүй болгосон бол давж заалдах шатны шүүхээр уг хэргийг дахин хянан хэлэлцэхэд оролцож болохгүй.

Хяналтын шатны журмаар хэрэг хэлэлцэхэд оролцсон шүүгч уг хэргийг анхан шатны ба давж заалдах шатны шүүхээр хянан хэлэлцэх, түүнчлэн түүний оролцоотойгоор гарсан тогтоолыг хүчингүй болгосон бол хяналтын шатны шүүхээр уг хэргийг дахин хянан хэлэлцэхэд оролцож болохгүй.»

32) 60 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

«Хэргийг даингаар шийдвэрлэж байгаа шүүгчийг татгалзсан нь энэ хуулийн 57, 58 дугаар зүйлд заасан үндэслэлтэй байвал шүүгч хэрэг хэлэлцэх ажиллагааг хойшдуулж уг асуудлыг тухайн шүүхийн Ерөнхий шүүгчид тавьцуулна. Ерөнхий шүүгч уг асуудлыг хянаж шүүгчийг татгалзсан нь үндэслэлтэй байвал өөр шүүгчийг шүүх хуралдаан даргалуулахаар томилно. Энэ талаар гарсан Ерөнхий шүүгчийн шийдвэрт давж заалдаж болохгүй.»

33) 62¹ дүгээр зүйл:

«62¹-р зүйл, Иргэдийн төлөөлөгчийг татгалзах

Энэ хуулийн 57 дугаар зүйлд дурдсан үндэслэл байвал иргэдийн төлөөлөгч хэргийг шүүх хуралдаанаар хинан хэлэлцэхэд оролцож болохгүй бөгөөд өөрөө татгалзах үүрэгтэй. Мөн энэ үндэслэлээр иргэдийн төлөөлөгчийг ялагч, шүүгдэгч, өмгөөлөгч, хохирогч татгалзаж болно.

Иргэдийн төлөөлөгчийг татгалзсан тухай асуудлыг шүүх шийдвэрлэнэ.

Татгалзан гарсан иргэдийн төлөөлөгчийн оронд шүүх хуралдаанд оролцох иргэдийн төлөөлөгчийг энэ хуулийн 49 дугаар зүйлд заасан журмын дагуу томилно.»

34) 67 дугаар зүйл:

«67-р зүйл, Нотлох баримт

Гэмт хэргийн нөхцөл, байдлын талаар хуульд заасан үндэслэл, журмын дагуу олж авсан баримт сэлт, мэдээллийг эрүүгийн хэргийн нотлох баримт гэнэ.

Эрүүгийн хэргийн нотлох баримт нь гэрч, хохирогч, сэжигтэн, яллагдагчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт, мэдүүлэг, эд мөрийн баримт, гэрэл зураг, кино, дүрс, дууны бичлэг, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүх хуралдааны протокол, бусад бичиг баримтаар тогтоогдоно.

Эрүүгийн хэргийн талаар хуульд заасан үндэслэл, нөхцөл, журмын дагуу явуулсан гүйцэтгэх ажлын шугамаар авагдсан баримт сэлтийг нотлох баримтын хэмжээнд үнэлж болно.

Нотлох баримт цуглуулах, бэхжүүдэх талаар хуульд заасан журмыг баримтлаагүй буюу зөрчсөн бол эдгээр нь нотлох чадвараа алдах бөгөөд шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй.

Нэргүй захидал болон мэдээлэл нь нотлох баримт бодохгүй.»

35) 68 дугаар зүйл:

«68-р зүйл, Нотлох баримтыг цуглуулах, гаргаж өгөх

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор энэ хуулиар тогтоосон журмаар сэжигтэн, яллагдагч, гэрч, хохирогч, шинжээчийг байцаах, нүүрэлдүүлж байцаах, таньж олуулах, нэгжих, үлэлэг хийх, туршилт хийх, бичиг баримт, эд зүйлийг хураан авах, хэрьцуулан шинжлэхээр хэв хэлбэр авах, шин-

жилгээ хийх, түүнчлэн энэ хуульд заасан мөрдөн байцаалтын бусад ажиллагааг явуулж нотлох баримтыг цуглуулна.

Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, өмгөөлөгч, ялагч, түүнчлэн хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний төлөөлөгч болон иргэн, байгууллага баримт сэлт гарган өгч болно.

Нотлох баримтыг цуглуулахдаа иргэний амь нас, эрүүл мэндэд аюультай, эсвэл тэдний нэр төрийг гутаасан ажиллагаа явуулах, эрүү шүүлт тулгах, хүнлэг бус хэргийг хандах, нэр төрийг нь доромжлох, хүч хэрэглэх, айлган сүрдүүлэх, мэдүүлэг, тайлабар, дүгнэлт гаргуулахаар тулган шаардах, хуурч мэхлэх зэрэг хууль бус арга хэрэглэж болохгүй.»

36) 68¹ дүгээр зүйл:

«68¹-р зүйл. Нотлох баримтыг бэхжүүлэх

Эрүүгийн хэрэгт цугларсан баримт сэлт, эд зүйлийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны болон шүүх хуралдааны протоколд тэмдэглэж бэхжүүлнэ.

Протокол үйлдэх үүргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх хуралдааны ивцэд шүүх хуралдааны нарийн бичгийн дарга хүлээнэ.

Нотлох баримтыг бэхжүүлэхдээ протокол үйлдэхийн зэрэгцээ мэдээллийг тусгасан дүрс болон ярианы бичлэг, кино зураг, гэрэл зураг, төлөвлөгөө, ул мөрнөөс хэв, хээ буулгаж авах зэрэг бусад аргыг хэрэглэж болно.»

37) 69 дүгээр зүйл:

«69-р зүйл. Нотлох баримтыг үнэлэх

Шүүх, прокурор, мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгч нь хууль болон эрдийн үхамсрыг удирдлага болгож хэргийн бүх байдлыг гад бүрээс нь нягт нямбай, бүрэн гүйцэд, бодит байдлаар нь хянаж үзэхийг үндсэн дээр нотлох баримтыг өөрийнхөө дотоод итгэлээр үнэлнэ.

Шүүх, прокурор, мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгчид урьлаас хөдөлбөргүй үнэн гэж тогтоогдсон ямар ч нотлох баримт байж болохгүй.

Нотлох баримт тухайн хэрэгт хамааралтай, ач холбогдолтой, хайгалттай, үнэн зөв, эргэлзээгүй, хуульд заасан журам, арга хэрэгслээр цугларсан эсэх талаас нь үнэлэлт өгнө.»

Хуулийн хүчин төгөлдөр болсон таслан шийдвэрлэх тогтоол, шийдвэрээр нэгэнт тогтоогдсон үйл баримтыг дахин

ноглох шаардлагатай. Энэ заалт шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэргийг сэргээн шалгахад хамаарахгүй.

38) 71 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт:

«3) сэжигтэн, яллагдагчийн гэр бүлийн гишүүд, үр хүүхдийг өөрсдийнх нь зөвшөөрөлгүйгээр.»

39) 72 дугаар зүйл:

«72-р зүйл. Гэрчийн үүрэг

Гэрч нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн дуудсанаар ирж, хэргийн талаар өөрийн мэдэх зүйлийг үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй.

Гэрч нь дуудсан цагт хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бол хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн шийдвэрээр түүнийг цагдаагийн байгууллага албадан ирүүлнэ.

Гэрч хуудал мэдүүлэг өгсөн, мэдүүлэг өгөхөөс татгалзсан буюу зайлсхийсэн бол түүнд Эрүүгийн хуулийн 205, 206 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.

Сэжигтэн, яллагдагчийн гэр бүлийн гишүүд, эцэг, эх, үр хүүхдийг зөвхөн өөрсдийнх нь зөвшөөрснөөр байцааж болно. Энэ тохиолдолд тэд гэрчийн эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

Энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасан журам нь өөрийн гэр бүлийн гишүүд, эцэг, эх, үр хүүхдийн гэм буруутай үйлдлийн улмаас хохирсон хохирогчийг дуудах, ирүүлэх, байцаахад нэгэн адил хамаарна.»

40) 74 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:

«Сэжигтнээс мэдүүлэг өгөхийг шаардах, түүнд эрүү шүүлт тулгах, хүчлэг бус, хэргийн хандах, нэр төрийг нь доромжлохыг хориглоно.»

41) 75 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

«Яллагдагчаас мэдүүлэг өгөхийг шаардах, түүнд эрүү шүүлт тулгах, хүчлэг бус, хэргийн хандах, нэр төрийг нь доромжлохыг хориглоно.»

42) 77 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт:

«1) гадны нөлөөллөөр буюу сэжигтэй байдлаар нас нөгцсөн бол түүний шалтгаан, түүнчлэн бие махбодид учирсан гэмтлийн шинж байдлыг тогтоох.»

43) 84 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт:

«4) гэмт үйлдлийн замаар олсон орлого болон тэдгээртэй

адилтан үзэх бусад эд зүйлийг хууль ёсны эзэмшигчид нь эгүүлэн олгох бөгөөд хэрэв эзнийг тогтоох боломжгүй бол шүүхийн шийдвэрээр улсын орлого болгоно. Эд зүйлийн эзэмшлийн талаар мөргөөн гарвал иргэний журмаар шийдвэрлэнэ. Энэ хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2, 3, 5-д дурдсан үндэслэлээр хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокуророос хэргийг хэрэгсэхгүй болгосон бол гэмт үйлдлийн ямаар олсон орлого болон тэдгээртэй адилтан үзэх бусад эд зүйлийн тухай асуудлыг шүүх шийдвэрлэнэ;»

44) 87 дугаар зүйл:

«87-р зүйл. Таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэх

Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч нь мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлж болох буюу эрүүгийн хэргийн бодит байдлыг тогтооход саад учруулж болох, эсхүл гэмт хэрэг үйлдэж болох үндэслэлтэй бол тэдгээрт дараахь таслан сэргийлэх арга хэмжээний аль нэгийг хэрэглэж болно: оршин суугаа газраасаа гадагш явж болохгүй тухай баталгаа авах, батлан даалтад өгөх, хөрөнгө барьцаалах, цагдан хорих.

Таслан сэргийлэх арга хэмжээ хэрэглэх талгар хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх тогтоол, шүүгч зөхирамж гаргана.

Таслан сэргийлэх арга хэмжээ болгож цэргийн албан хаагчийг хянан харгалзуулахаар түүний алба хааж байгаа цэргийн анги, нэгтгэл, байгууллагын удирдлагад шилжүүлж болно.

Таслан сэргийлэх арга хэмжээ авах шаардлагагүй бол дуудсан цагт ирэх, оршин суугаа газраа өөрчилсөн тухайд мэдэгдэж байх үүрэг яллагдагчид хүлээлгэж гарын үсэг авна.»

45) 88 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

«Харин мөрдөн байцаалт явуулах шаардлагагүй хэргийн хэрэг бүртгэлийн хугацааг энэ хуулийн 123 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан журмын дагуу сунгасан бол мөн хугацаагаар сэжигтэнд авсан таслан сэргийлэх арга хэмжээг сунгаж болно.»

46) 91 дүгээр зүйл:

«91-р зүйл. Гадагш явж болохгүй тухай баталгаа авах Сэжигтэн, яллагдагчаас байнга буюу түр оршин сууж байгаа газраасаа хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор,

шүүхийн зөвшөөрөлгүйгээр гаданг илалгүй тухай баталгааг бичгээр гаргуулж авна.

Хэрэн сэжигтэн, яллагдагч энэ арга хэмжээг зөрчөөл таслан сэргийлэх арга хэмжээг чангаруулж болох бөгөөд энэ тухай баталгаа авах үед түүнд урьдчилан мэдэгдэнэ.

47) 92 дугаар зүйл:

«92-р зүйл. Батлан даалт

Батлан даалт гэдэг нь байнга оршин суух хаягтай, тодорхой ажил, хөдөлмөр эрхэлдэг, хөрөнгийн эх үүсвэртэй, батлан даагчийн үүргийг бүрэн хүлээх чадвартай, насанд хүрсэн иргэнээс сэжигтэн, яллагдагчийг төлөн томоотой байгаах, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн дуудсан пагт ирүүлж байхыг хариуцаж, бичгээр үүрэг авахыг хэлнэ. Батлан даагч нь хоёроос доошгүй байна.

Чухам ямар хэргийн учир таслан шийдвэрлэх арга хэмжээ авагдсан, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч нь мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлсхийвэл хүлээлтэх хариуцаагчийн тухай батлан даагчид мэдэгдэнэ. Хэрэн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлвал батлан даагчийг шүүгчийн захирамжаар энэ хуулийн 315 дугаар зүйлд заасан журмаар 500-гаас 25000 хүртэл төгрөгөөр торгож сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг эрэн сурвалжлахад гарсан бүх зардалыг нөхөн төлүүлдэг.

48) 94 дүгээр зүйл:

«94-р зүйл. Цагдан хорих

Они хүнд, хүнд, хүндэтгэр гэмт хэрэг үйлдсэн, эсхүл удаа дараа ил шийтгэгдэж байсан буюу они аюултай гэмт хэрэгтэн, түүнчлэн мөрдөн байцаалтын хугацаанд дахин гэмт хэрэг үйлдэх буюу оргон зайлсхийж болох хангалттай үндэслэл байвал уг этгээлд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг энэ хуулийн 12 дүгээр зүйлийн шаардлагын дагуу хэрэгдэж болно.

Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлийн аль нэг нь байвал жирэмсэн эмэгтэйчүүдийг эмнэлгийн байгууллагын эмнэлгын дор цагдан хорьж болно.

Хөнгөн гэмт хэрэг үйлдсэн буюу хүнд бичтэй этгээд, хөхүүг хүүхэдтэй эмэгтэйчүүдийн хувьд энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэл байхгүй бол цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэхийг хориглоно.

49) 95 дугаар зүйл:

-95 дугаар зүйл. Хорьж мөрдөх хугацаа

Яллагдагчийг хорьж мөрдөх хугацааг 2 сараас хэтрүүлж болохгүй. Гагцхүү хуна, онц хуна тэмт хэрэг үйлдсэн яллагдагчийг хэргийн төлөгтэй байдлыг харгалзан цаашид хорьж мөрдөх зайлшгүй шаардлагатай гэж үзвэл сум, сум дундын болон дүүргийн прокурор 1 сар хүртэл, аймаг, нийслэлийн болон дагнасан прокурор 2 сар хүртэл, Улсын ерөнхий прокурорын туслах 3 сар хүртэл, Улсын ерөнхий прокурорын орлогч 2 сар хүртэл хугацаагаар нэмж сунгаж болно. Сунгасан хугацанд мөрдөн байцаалт дууссангүй бөгөөд цаашид зайлшгүй шаардлагатай тохиолдолд хорьж мөрдөх хугацааг Улсын ерөнхий прокурор 26 сар хүртэл хугацаагаар нэмж сунгана.

Мөрдөн байцаагч хорьж мөрдөх хугацааг сунгах тухай үндэслэл бүхий тогтоол гаргаж, хугацаа дуусахаас 10 хоногийн өмнө зохих прокурорт явуулна.

Шүүхээс нэмж мөрдөн байцаалтахаар буцаасан хэргийн яллагдагчийг цаашид хорьж мөрдсөн хугацааг энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаанд оруулж тооцно.

Шүүхээс хэргийн хянан шийдвэрлэх шатанд яллагдагчийг хорьж мөрдөх хугацаа дуусвал тухайн шүүхийн ерөнхий шүүгч хэргийг хянан шийдвэрлэхэд шаардагдах хугацаагаар захирамж гарган сунгаж болно.»

50) 97 дугаар зүйл:

-97-р зүйл. Барьцаа

Мөрдөн байцаагч, прокурор, шүүхээс дуудсан цагт саадгүй ирж байхыг яллагдагч өөрөө баталж, эсхүл яллагдагчийг тийнхүү ирүүлж байх үүргийг бусад хүн, байгууллага хүлээж, уг таслан сэргийлэх арга хэмжээ авч байгаа байгууллагын дансанд шилжүүлсэн бэлэн мөнгө буюу бусад үнэ бүхий зүйлийг барьцаа гэнэ.

Барьцаа авсан тухай протокол үйлдэж, хуулбарыг барьцаа өгөгчид гардуулна.

Барьцааны хэмжээг таслан сэргийлэх арга хэмжээ авч байгаа байгууллага барьцаа өгөгчтэй харилцан тохиролцооны үндсэн дээр хэргийн байдалд тохируулан тогтооно.

Яллагдагч нь мөрдөн байцаагч, прокурор, шүүхээс дуудахад хүндэтгэн үлэх шалтгаангүйгээр ирэхгүй зайлсхийвэл барьцаанд өгсөн зүйлийг шүүгчийн захирамжаар энэ хуу-

лийн 315 дугаар зүйлд заасан журмаар улсын орлого болгоно.»

51) 98¹ дүгээр зүйл:

«98¹-р зүйл, Албан үүргээ биелүүлэхийг түр түдгэлзүүлэх

Гэмт хэргийн бодит байдлыг тогтооход албан тушаалаа ашиглан саад учруулж болзошгүй тохиолдолд яллагдагчийг эрхэлж байгаа албан үүргээ биелүүлэхийг түр хугацаагаар түдгэлзүүлэхээр мөрдөн байцаагч үндэслэл бүхий тогтоол гаргаж прокурор батална. Уг тогтоолыг биелүүлэхээр эрх бүхий байгууллагад явуулна.

Энэ арга хэмжээг цааш хэрэглэх шаардлагагүй бол албан үүргээ биелүүлэхийг түр түдгэлзүүлсэн явдлыг мөрдөн байцаагчийн тогтоолоор хүчингүй болгоно.»

52) 106 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

«Хэрэв зөвшөөрөхгүй бол энэ асуудлыг шүүх зуралдаанд оролцсон ялагч, өмгөөлөгч, иргэдийн төлөөлөгчийг байлцуулан шийдвэрлэнэ.»

53) 113 дугаар зүйл:

«113-р зүйл, Эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэл

Эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэл:

1) иргэний өргөдөл, гомдол;

2) аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны мэдээлэл;

3) хэвлэлд нийтлэгдсэн мэдээлэл;

4) хэргээ илчлэн ирэх;

5) хэрэг бүртгэх байгууллага, мөрдөн байцаагч, прокуророос гэмт хэргийн шинж тэмдгийг шууд өөрсдөө илрүүлэх.

Гэмт хэрэг үйлдэгдсэн гэх хангалттай баримт, үндэслэл байвал эрүүгийн хэрэг үүсгэж болно.

Нэр, хаяггүй мэдээлэл нь дангаараа эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэл болохгүй бөгөөд түүнийг урьдчилсан шалгаж гэмт хэрэг гарсан гэх хангалттай баримт, үндэслэл тогтоогдовол энэ зүйлийн 1 дэх хэсгийн 5-д заасан албан тушаалтан эрүүгийн хэрэг үүсгэх асуудлыг тус тусын харьяалами дагуу шийдвэрлэнэ.»

54) 116 дугаар зүйл:

«116-р зүйл, Гэмт хэргийн тухай гомдол, мэдээллийг заавал хянаж үзэх

Гэмт хэрэг үйлдсэн буюу гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж

байгаа тухай гомдол, мэдээллийг прокурор, мөрдөн байцаагч, хэрэг бүртгэх байгууллага хүлээн авах үүрэгтэй. Гомдол, мэдээллийг прокурор, мөрдөн байцаагч нь хэрэг бүртгэх байгууллагад харьяаллын дагуу нэн даруй шилжүүлэх бөгөөд хэрэг бүртгэх байгууллага хүлээн авсан гомдол, мэдээллийг шалгаж 5 хоногийн дотор, онцгой тохиолдолд 14 хоногоос хэтрүүлээгүйгээр дор дурдсан шийдвэрийн аль нэгийг гаргаж энэ тухай гомдол, мэдээлэл гаргагчид мэдэгдэнэ:

- 1) эрүүгийн хэрэг үүсгэх;
- 2) эрүүгийн хэрэг үүсгэхийг татгалзах.

Гомдол, мэдээллийг шалгах явцад гэмт хэрэг үйлдэж байгаа болон үйлдсэн тухай үндэслэлтэй сэжиг байгаа тохиолдолд хэрэг бүртгэх эрх бүхий албан тушаалтан хэрэг бүртгэлт явуулах эсэхийг шийдвэрлэхийн тулд дараахь хойшлуулшгүй ажиллагаа явуулж болно:

- 1) хүний нэр хангийг тодруулах зорилгоор бичиг баримтыг үзэж шалгах;
- 2) хүний бие, тээврийн хэрэгсэл, ачаа тээшид үзэлэг хийх
- 3) иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын эд зүйл, хөрөнгө, мөнгө агуулсан байр, савыг битүүмжлэх;
- 4) хэрэгт ач холбогдол бүхий тээврийн хэрэгсэл, эд зүйл, мөнгийг түр хугацаагаар хурааж авах;
- 5) шүүх эмнэлэг, криминалистикийн болон бусад шинжилгээнд зориулж дээж, хурууны хээ, ул мөрний хэв авах;
- 6) иргэн, албан тушаалтнаас тайлбар гаргуулах;
- 7) тодорхой нутаг дэвсгэр, орон байранд нэвтрэн орох, гарахад хяналт тогтоох;
- 8) гэмт хэргийг таслан зогсоох, гэмт этгээдийг мөрдөх үед байгууллага, иргэдийн орон байранд орох;
- 9) сөгтууруулах ундаа, мансууруулах, хордуулах бодис хэрэглэсэн эсэхийг шалгах.

Энэ зүйлийн 2 дахь хэсгийн 2, 3, 4, 5-д заасан ажиллагааг тагихуу энэ хуульд заасан журмын дагуу явуулна.»

55) 118 дугаар зүйл:

«118-р зүйл, Эрүүгийн хэрэг үүсгэхийг татгалзах

Хэрэн гомдол буюу мэдээ элд эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэл байхгүй, түүнчлэн хэрэгт байцаан шийтгэх ажиллагаа явуулж болохгүй Сайдал илэрвэл хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах тухай үндэслэл Сүхий тогтоол гаргаж, гомдол, мэдээлэл гаргасан иргэн, байгууллагад энэ тухай мэдэгдэнэ.

Хэрэн хүлээн авсан гомдол, мэдээлэлд захиргааны буюу сахилгын мөрдлийн талаар дурдсан байвал хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор уг асуудлыг захиргааны буюу сахилгын журмаар шийдвэрлүүлэхээр материалыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд илгээжүүлнэ.

Эрүүгийн хэрэг үүсгэхийг татгалзсан тохиолдолд гомдол, мэдээлэл гаргагч нь зохих прокурорт давж заалдах эрхтэй.»

56) 120 дугаар зүйл:

«120-р зүйл. Эрүүгийн хэрэг үүсгэх ажиллагааг хуульд нийцэж байгаа эсэхэд тавих хяналт

Эрүүгийн хэрэг үүсгэх ажиллагааг хуульд нийцэж байгаа эсэхэд прокурор хяналт тавина.

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч хууль зүйн үндэслэл, баримтуугээр хэрэг үүсгэсэн байвал прокурор өөрийн тогтоолоор хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн тогтоолыг хүчингүй болгох буюу хэрэг түүнд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа хийгдсэн байвал хэргийг хэрэгсэхгүй болгоно.

Хэрэн хэрэг үүсгэхийг үндэсгүйгээр татгалзсан байвал прокурор өөрийн тогтоолоор мөрдөн байцаагч буюу хэрэг бүртгэгчийн тогтоолыг хүчингүй болгож хэрэг үүсгэнэ.»

57) 121 дүгээр зүйл:

«121-р зүйл. Хэрэг бүртгэх байгууллага

Хэрэг бүртгэх байгууллага нь:

1) цагаалагийн байгууллага;

2) улсын аюулгүй байдлыг хангах байгууллага — Эрүүгийн хуулийн 60—66, 67, 68, 70—74, 79—84, 291 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн талаар;

3) цэргийн хэрэг бүртгэх алба—цэргийн албан хаагч, цэргийн алба хаах үүрэг бүхий хүмүүс түр сургууль хийж байх үедээ үйлдсэн бүх гэмт хэргийн талаар, түүнчлэн цэргийн анги, байгууллагын ажилчин, албан хаагчдаас үүрэгт ажлаа биелүүлэхтэй холбогдуулаж үйлдсэн буюу цэргийн анги, байгууллагын байрлаж байгаа газарт гарсан гэмт хэргийн талаар;

4) хорих ял эзлүүлэх байгууллагын дарга, гүйцэтгэх ажилтан—ялсны үйлдсэн, түүнчлэн тус байгууллагын ажилтнуудаас үүрэгт ажлаа биелүүлэхтэй холбогдуулаж үйлдсэн гэмт хэрэг болон хорих ял эзлүүлэх байгууллагын байрлаж байгаа газар гарсан гэмт хэргийн талаар;

5) хэл хамгаалаг байгууллага—Эрүүгийн хуулийн 79, 79¹ дүгээр зүйлд заасан гэмт хэргийн талаар;

6) галийн байгууллагын хэрэг бүртгэх эрх бүхий албан тушаалтан—галийн хууль тогтоомж зөрчсөн гэмт хэргийн талаар;

7) улсын татварын байгууллагын хэрэг бүртгэх эрх бүхий албан тушаалтан-татварын хууль тогтоомж зөрчсөн гэмт хэргийн талаар.

Нэгдэлтийн байгууллага Эрүүгийн хуулийн 60, 61, 70—72, 251 дүгээр зүйлд зааснаас бусад өөрсдөн илрүүлсэн эрүүгийн хэрэгт харьяалаа хяргагдахгүйгээр хэрэг бүртгэлт оруулна.»

58) 122 дугаар зүйл:

«122-р зүйл. Хэрэг бүртгэх байгууллагын үүрэг

Хэрэг бүртгэх байгууллага нь гэмт хэрэг болон түүнийг үйлдсэн этгээдийг олж илрүүлэхийн тулд энэ хуульд заасан бүхий арга хэмжээг авах үүрэгтэй.

Гэмт хэрэг, түүнийг үйлдсэн этгээдийг олж илрүүлэх зорилгоор хийж гүйцэтгэх ажлыг өөрсөн энэ хуулийн 121 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, 4-т заасан хэрэг бүртгэх байгууллага гүйцэтгэх эрхтэй.

Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан гүйцэтгэх ажлыг хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулах бөгөөд түүнд прокурор хуульд заасан журмын дагуу хяналт тавина.

59) 123 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

«Хэрэг бүртгэх байгууллага эрүүгийн хэрэг үүсгэсэн тухай нэг даруй прокурорт мэдэгдэнэ. Хэрэг бүртгэх байгууллага мөрдөн байцаалтын хойшлуулсныг ажлалагаар 14 хоногийн дотор гүйцэтгэж, хэргийг прокурорт шилжүүлнэ. Мөрдөн байцаалт дауулахгүйгээр шүүхэд шууд шилжүүлэх хэргийн хугацаат хяналт тавьж байсан прокурор 14 хүртэл хоногдоо сулгах эрхтэй. Хэрэг бүртгэх байгууллага нь мөрдөн байцаалтад шилжүүлсэн хэрэгт мөрдөн байцаагчийн даалгавраар хэрэгт ач холбогдол бүхий төхөөл байдлыг тогтоож тавьж зайлшгүй шаардлагатай байсан шийтгэх ажлалагаар үргэлжлүүдэн хийх үүрэгтэй. Гүйцэтгэсэн ажлынхаа дүнг тухай бүр мөрдөн байцаагчид мэдэгдэж байна.»

60) 124 дүгээр зүйл:

«124-р зүйл. Хэрэг бүртгэж дуусгах

Эрүүгийн хэрэг бүртгэх ажиллагаа нь хэргийг прокурорт шилжүүлэх тухай тогтоол гаргаснаар дуусна.

Мөрдөн байцаалт явуулахгүйгээр шүүхэд шууд шилжүүлэх хэргийн хувьд хэрэг бүртгэгч энэ хуулийн 200, 201, 204, 205-р зүйлд заасан ажиллагааг гүйцэтгэнэ.»

61) 124¹ дүгээр зүйл:

«124¹-р зүйл. Хэрэг бүртгэлтээс шилжиж ирсэн хэргийн талаар прокуророос гаргах шийдвэр

Хэрэг бүртгэх байгууллагаас шилжүүлсэн хэргийг прокурор хянаж дор дурдсан шийдвэрийн аль нэгийг гаргана:

- 1) хэргийг мөрдөн байцаалтад шилжүүлэх;
- 2) хэргийг шүүхэд шилжүүлэх;
- 3) эрүүгийн хэрэг үүсгэсэн тогтоолыг хүчингүй болгож хэргийг хэрэгсэхгүй болгох;
- 4) нэмэлт ажиллагаа хийлгүүлэхээр хэрэг бүртгэх байгууллагад буцаах.

Энэ хуулийн 126 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан хэргийг прокурор хянаж, түүнийг шүүхэд шилжүүлэх нотолгоо хангалттай бүрдсэн гэж үзвэл уг этгээдийг яллагдагчаар татах тухай тогтоол үйлдэж, хэргийг шүүхэд шилжүүлнэ.

62) 125 дугаар зүйл:

«125-р зүйл. Мөрдөн байцаалт явуулах байгууллага

Эрүүгийн хэрэгт мөрдөн байцаах байгууллагын мөрдөн байцаагч мөрдөн байцаалт явуулна.»

63) 126 дугаар зүйл:

«126-р зүйл. Мөрдөн байцаалт явуулах хэргүүд

Эрүүгийн хуулийн 98, 99, 100 дугаар зүйл, 103 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 104, 105 дугаар зүйл, 106 дугаар зүйлийн 1, 2, дахь хэсэг, 107, 115, 116 дугаар зүйл, 117 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 118, 119, 120 дугаар зүйл, 121 дүгээр зүйлийн 1 дүгээр хэсэг, 149, 178, 188, 228, 234 дүгээр зүйл, 239 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 247, 261, 262 дугаар зүйл, 267 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 270 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 271 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 272 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 273 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 274 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 275 дугаар зүйл, 276 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 277 дугаар зүйлийн 1, 2, 4 дахь хэсэг, 278 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 287 дугаар зүйлийн

1, 2 дахь хэсэгт зааснаас бусад хэрэгт мөрдөн байцаалт явуулна.

Мөрдөн байцаалт явуулахаар авсан хөнгөн буюу хүндэтгэр гэмт хэргийн бүрэлдэхүүнийг хэрэг бүртгэлтийн шатанд хангалттай нотолж тогтоосон бөгөөд уг хэргийг шүүхэд шилжүүлэх боломжтой гэж прокурор үзсэн тохиолдолд мөрдөн байцаалт явуулахгүй байж болно.

Онц хүнд, хүнд гэмт хэрэг болон насанд хүрээгүй хүмүүс, түүнчлэн эрхтэн дутуу буюу сэтгэл мэдрэлийн өвчний учир өөрийн эрхийг хамгаалж чадахгүй болсон хүмүүсийн үйлдсэн бүх хэрэгт мөрдөн байцаалт заавал явуулна.»

64) 127^д дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:

«Мөрдөн байцаах албаны дарга мөрдөн байцаалтын тодорхой ажиллагаа гүйцэтгүүлэхээр заалт өгөх, хэргийг нэг мөрдөн байцаагчаас нөгөөд шилжүүлэх, хэрэг мөрдөх ажиллагааг хэд хэдэн мөрдөн байцаагчид даалгах, түүнчлэн мөрдөн байцаалтын ажиллагаанд оролцох, мөрдөн байцаагчийн эрх хэмжээг эдэлж, өөрөө мөрдөн байцаалт явуулах эрхтэй.»

65) 128 дугаар зүйл:

«128-р зүйл. Мөрдөн байцаалтыг эхлэх.

Мөрдөн байцаах ажиллагааг гагцхүү эрүүгийн хэрэг үүсгэсний дараа энэ хуульд дурдсан журмаар явуулна.

Мөрдөн байцаагч эрүүгийн хэрэгт мөрдөн байцаалтыг нэг даруй эхлэх үүрэгтэй бөгөөд мөрдөн байцаалт явуулах тухай тогтоол үйлдэнэ. Эрүүгийн хэрэг үүсгэх ба мөрдөн байцаалт явуулах ажиллагаа нэгэн зэрэг хийгдэж байгаа бол энэ тухай нэг тогтоол гаргана. Мөрдөн байцаагч эдгээр тогтоолын хуулбарыг прокурорт нэн даруй явуулна.

Хэрэв хэрэг нь ээдрээ, түнэгтэй байвал мөрдөн байцаах албаны дарга мөрдөн байцаалт явуулахыг хэд хэдэн мөрдөн байцаагчид даалгаж болох бөгөөд энэ тохиолдолд мөрдөн байцаагчдын нэг нь хэрэгт мөрдөн байцаалт явуулахаар хүлээн авч, бусад мөрдөн байцаагчдын ажиллагааг удирдана. Харин сэжигтэн, яллагдагч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагчид мөрдөн байцаагчийг татгалзах тухай эрхийг тайлбарлаж өгөхдөө мөрдөн байцаагчдын бүх бүрэлдэхүүнийг зарлана.»

66) 130 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

«Тухайн хэрэг нь олон сэжигтэн, яллагдагчтай буюу олон үйлдэлтэй, эсхүл ааслагдсан газарт шалгалт хийх шаардла-

гатай, түүнчлэн шүүх—ниглан бодох бүртгэлийн болон бусад нарийн төвөгтэй шинжилгээ хийх, дахин шинжилгээ явуулах зэрэг зайлшгүй шаардлагатай тохиолдолд мөрдөн байцаалт явуулах хугацааг цаашид сум, сум дуудын болон дүүргийн прокурор 2 сар хүртэл, аймаг, нийслэлийн болон дагивсан прокурор 3 сар хүртэл, Улсын ерөнхий прокурорын туслах 2 сар хүртэл, Улсын ерөнхий прокурорын орлогч 4 сар хүртэл нэмж сунгана, Сунгасан хугацаанд мөрдөн байцаалт дуусаагүй бол хэргийн хугацааг цаашид сунгах асуудлыг Улсын ерөнхий прокурор шийдвэрлэнэ.»

67) 137 дүгээр зүйл:

«137-р зүйл. Сэжигтэнг албадан саатуулах.

Сэжигтэнг хэрэг бүртгэх байгууллага, мөрдөн байцаагч, прокурор дөр дурдсан үндэслэлийн аль нэг нь байвал албадан саатуулах эрхтэй.

1) уг этгээд өргөн зугатахыг завдсан;

2) байнга суух орон байргүй;

3) хэн болох нь тогтоогдохгүй байгаа буюу они хүнд, хүнд гэмт хэрэг үйлдэгдсэн гэх үндэслэл байвал.

Хэрэг бүртгэх байгууллага, мөрдөн байцаагч албадан саатуулах тухай үндэслэлийг дурдсан протокол үйлдэж, 24 цагийн дотор прокурорыг мэдэгдэх үүрэгтэй.

Прокурор албадан саатуулсан тухай мэдээ авснаас хойш 48 цагийн дотор албадан саатуулагдаж байгаа этгээдийг цагдан хорих зөвшөөрөл өгөх буюу суллах үүрэгтэй.

Албадан саатуулах хугацааг протокол үйлдсэн үеэс эхэлж тоолно.»

68) 168 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

«Хураан авах буюу нэгжлэг хийхэд хөндлөнгийн гэрч, эд зүйл буюу бичиг баримтаа хураалсаж байгаа, нэгжлэг хийлгэж байгаа этгээд буюу түүний гэр бүлийн насанд хүрсэн гишүүн, эсхүл өмгөөлөгчийг заавал байлгуулна.»

69) 173 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

«Битүүмжилсэн хөрөнгийг мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгчийн тогтоолоор уг хөрөнгийг эзэмшигч, эсхүл түүний гэр бүлийн насанд хүрсэн гишүүн болон бусад итгэлтэй хүмүүст хадгалуулахаар өгч, хөрөнгийг бүрэн бүтэн байлгах хариуцлагыг тайлбарлан өгч энэ тухай гарын үсэг авна. Шаардлагатай тохиолдолд битүүмжилсэн хөрөнгийг түр хураан авч болно. Битүүмжилсэн хөрөнгийг дээр дурдсан хүмүүст ха-

риуцуулах боломцоогүй бол түүнийг хадгалах, бүрэн бүтэн байлгах асуудлыг хэрэг бүртгэли, мөрдөн байцаалт явуулж байгаа байгууллага харагчид.»

70) 157 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

«Протоколын хуулбарыг эд зүйл, бичиг баримтаа хуралдгасан, нэгжүүдсэн буюу хэрэгтөө бичүү ажлуулсан этгээд буюу түүний гэр бүлийн насанд хүрсэн гишүүд, эсхүл өнгөөдөгчид нь гардуулан өгч гарын үсэг авна.»

71) 192 дугаар зүйл:

«192-р зүйл, Мөрдөн байцаалтыг түдгэлзүүлэх үндэслэл, хугацаа

Мөрдөн байцаалтыг дор дурдсан үндэслэлээр түдгэлзүүлнэ:

1) гэмт хэрэг үйлдсэн этгээд тогтоогдоогүй, эсхүл байгаа газар нь мэдэгдэхгүй байгаа;

2) сэжигтэн, яллагдагч өргөн зайлсан;

3) сэжигтэн, яллагдагч сэтгэл мэдрэлийн буюу өөр хүнд өнний улмаас хүрэлцэн ирж чадахгүй болох нь эмсэлгийн байгууллагын дүгнэлтээр батлагдсан;

4) зайлшгүй шаардлагатай гэрч, хохирогч байхгүй тохнолдолд.

Мөрдөн байцаагч, мөрдөн байцаалтыг түдгэлзүүлэх тухай тогтоол гарганы, Хэрэг хоёр буюу хэд хэдэн сэжигтэн, яллагдагч хэрэгт татагдсан бөгөөд мөрдөн байцаалтыг түдгэлзүүлэх үндэслэл нь бүх сэжигтэн, яллагдагчид хамарахгүй байла мөрдөн байцаагч зарим сэжигтэн, яллагдагчид холбогдох хэргийг тусгаарлан түдгэлзүүлэх эрхтэй.

Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2-г заасан тохнолдолд мөрдөн байцаалтыг уг хэргийг мөрдөх хугацаа дуусмагц түдгэлзүүлнэ. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 3-г заасан тохнолдолд мөрдөн байцаалтын хугацаа дуусахын өмнө түдгэлзүүлж болно. Сэжигтэн сэтгэл мэдрэлийн өвчтэй болох нь хэрэг бүртгэлийн шатанд тогтоогдовол хэргийг түдгэлзүүлэх тухай асуудлыг мөрдөн байцаалтад шилжүүлсний дараа шийдвэрлэнэ.

Мөрдөн байцаалтыг түдгэлзүүлэхийн өмнө мөрдөн байцаагч сэжигтэн, яллагдагчийн байхгүйд гүйцэтгэж болох мөрдөн байцаалтын бүх ажылагааг явуулах, гэмт хэрэг үйлдсэн болон өргөн зайлсан этгээдийг олж илрүүлэх бүх иргэ хэмжээг авах үүрэгтэй.

Түдгэлзүүлсэн хэргийг Эрүүгийн хуулиар тогтоосон хөөн хэлэлцэх хугацаа дуусмагц хэрэгсэхгүй болгоно.»

72) 193 дугаар зүйл:

«193-р зүйл, Сэжигтэн, яллагдагчийг эрэн сурвалжлах

Сэжигтэн, яллагдагч оргон зайлсан байвал хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч эрэн сурвалжлах шаардлагатай арга хэмжээг авна. Мөрдөн байцаагч эрэн сурвалжлах ажлыг гүйцэтгүүлэхээр цагдаагийн байгууллагад даалгах эрхтэй бөгөөд энэ тухай тогтоол гаргана.

Эрэн сурвалжлах явдлыг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын үед буюу хэргийг түдгэлзүүлэхийн хамт зарлана. Энэ хуулийн 87, 94 дүгээр зүйлд заасан үндэслэл байвал мөрдөн байцаагч эрэн сурвалжлаж байгаа этгээдийг прокурорын зөвшөөрөлтэйгээр цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч болно.»

73) 194 дүгээр зүйл:

«194-р зүйл, Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олж тогтоох арга хэмжээ

Энэ хуулийн 192 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасан тохиолдолд хэргийг түдгэлзүүлсний дараа мөрдөн байцаах байгууллага өөөрөө буюу цагдаагийн болон хэрэг бүртгэх бусад байгууллагатай хамтран гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олж тогтоох арга хэмжээ авах үүрэгтэй.»

74) 195 дугаар зүйл:

«195-р зүйл, Мөрдөн байцаалтыг сэргээн явуулах.

Мөрдөн байцаалтыг түдгэлзүүлэх үндэслэл арилсан буюу мөрдөн байцаах ажиллагааг нэмж хийх шаардлагатай байвал мөрдөн байцаагч, прокурорын тогтоолоор мөрдөн байцаалтыг сэргээн явуулна.»

75) 196 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

«Энэ хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, 3, 5, 6-д заасан тохиолдолд эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгоно.»

76) 197 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

«Хэрэн яллагдагчаар татагдсан буюу бусад этгээдийн хувьд захиргааны болон сахилгын арга хэмжээ ногдуулах баримт тогтоогдвол прокурор, мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгч эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгож, шаардлагатай материалыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд шилжүүлнэ.»

77) 202 дугаар зүйлийн I дэх хэсэг:

«Мөрдөн байцаагч мөрдөн байцаалт дуусмагц мөрдөн байцаалтын бүх материалыг үдэж дугаарлан, яллагдагчид өгч, өөрөө буюу өмгөөлөгчийн туслаалцаатай танилцах бололцоо олгох үүрэгтэй. Мөрдөн байцаалтын явцад кино, дүрс дууны бичлэг хийсэн бол тэдгээртэй танилцах бололцоог яллагдагч, түүний өмгөөлөгчид нэгэн адил олгоно.»

78) 208 дугаар зүйл:

«208-р зүйл. Хэргийг прокурорт шилжүүлэх

Мөрдөн байцаагч нь яллагдагч, хохирогч, өмгөөлөгч, иргэний нэхэмжлэгч, иргэний харуцагч, тэдний төлөөлөгчид хэргийн материалыг танилцуулсны дараа хэргийг прокурорт нэн даруй шилжүүлдэг.»

79) 209 дүгээр зүйл:

«209-р зүйл. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд тавих прокурорын хяналт

Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хууль хэрхэн хэрэгжиж байгаад Улсын ерөнхий прокурор, түүний харьяа прокурорууд Үндсэн хууль, Прокурорын байгууллагын тухай хууль, энэ хуудлын заалтыг удирдлага болгон хяналт тавина.

Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих чиг үүргийн дагуу дор дурдсан ажиллагаанд хяналт тавина:

1) гэмт хэргийн үйл баримтыг шалгаж тогтоох, гэмт этгээдийг илрүүлэх талаар хийж байгаа хэрэг бүртгэх ажиллагаа хуудлын дагуу явагдаж байгаа эсэх;

2) мөрдөн байцаах ажиллагаа Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдаж байгаа эсэх;

3) мөрдөн байцаах ажиллагаанд Эрүүгийн хуулийг зөв хэрэглэж байгаа эсэх;

4) хэрэг бүртгэх, мөрдөн байцаах Сайгууллагаас хүний эрх, эрх чөлөө, хувийн бие гэр бүл, сахиаал харилцааны нууц, орон байр, өмчийн халлашгүй байдлыг хязгаарлах талаар ивуулж буй ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдаж байгаа эсэх;

5) бусдыг нэгжих, албадан саатуулах, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлах ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдаж байгаа эсэх.

Прокурор энэ зүйлд залсан хяналтыг дор дурдсан үндсэн бүрэн эрхийг хэрэгжүүлэх зэмлэр гүйцэтгэнэ:

1) хэргийн тухай гомдол, мэдээллийг хүлээн авах, бүртгэх, шалган шийдвэрлэх ажиллагчийг хялги шалгах;

2) эрүүгийн хэрэг үүсгэх ажиллагаанд хяналт тавих;

3) хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явц, үр дүнг хянахын тулд хэргийн баримт материал, бусад мэдээг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллага, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчдад танилцах;

4) хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хуулийн заалтыг хангуулах, хуулийг хэрэглэх талаар болон төдөрхөй ажиллагааг гүйцэтгүүлэхээр хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчид заалт өгөх;

5) хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад хүний эрх, эрх чөлөө, хувийн ба гэр бүл, эдийн харилцааны нууц, орон байр, өмчийн халданггүй байдлыг хяндсан ажиллагаа явуулах зайлшгүй шаардлага гарвал зөвшөөрөл өгөх асуудлыг хялги шийдвэрлэх;

6) хэрэг бүртгэх, мөрдөн байцаах зарим ажиллагааг явуулахад оролцох;

7) хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн хууль бус үндэслэлгүй шийдвэрийг өөрчлөх буюу хүчингүй болгох;

8) мөрдөн байцаалт явуулах шаардлагатай гэж үзвэл эрүүгийн хэргийг хэрэг бүртгэлтээс мөрдөн байцаалтад шилжүүлэх;

9) хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад хуулийг ноцтой зөрчсөн буюу уг хэрэгт хүний сонирхолтой, эсвэл хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааг зохих ёсоор гүйцэтгэж чадахгүй байвал хэргийг бодитойгоор мөрдүүлэхийн тулд тухайн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчаар хэргийг илалд мөрдүүлэхийг зогсоох, өөр хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчид шилжүүлэх;

10) хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны үр дүнг үндэслэл хэргийг мөрдөн байцаалтад болон шүүхэд шилжүүлэх, эсхүл нэмэлт ажиллагаа хийгэхээр буцаах;

11) хуульд залсан үндэслэл журмын дагуу эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах буюу хэргийг хэрэгсэхгүй болгох;

12) хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаа, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн үйл ажиллагаа, шийдвэрийн талаар прокурорын байгууллагад гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх;

13) хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын болон хяналтын ажилд шаардлагатай мэдээ, судалгаа, баримт бичгийг аль ч байгууллага, албан тушаалтнаас үнэ төлбөргүй гаргуулан авах, газар зэрэг нь танилцах, мэргэжлийн дүгнэлт, магадлагаа гаргуулах;

14) албан тушаалтан, иргэнээс тайлбар, мэдүүлэг гаргуулах, хуульд заасан тогнололд албадан ирүүлэх арга хэмжээ авах;

15) хуулийг биелүүлэх, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар эрх бүхий байгууллага, албан тушаалтанд санал тавих буюу гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгахыг шаардах;

16) хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэвийн ажиллагааг хангах, уул ажиллагаанд илэрсэн нийтлэг зөрчлийг арилгуулах талаар хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагын захиргаанд шаардлага тавих;

17) хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажлыг шалгах;

18) хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагын захиргаанаас хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны талаар гаргасан тушаал, шийдвэр хуульд нийцэж байгаа эсэхийг хянах, хууль зөрчсөн тушаал, шийдвэрт эсэргүүцэл бичих;

19) баривчлах, албадан саатуулах, цагдаа хорих байранд ямар ч цагт саалгүй нэвтрэн орох, хоригдож байгаа хүмүүстэй биечлэн уулзах, хууль зүйн үндэслэлгүйгээр хоригдож байгаа этгээдийг нэн даруй суллах;

20) хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажлын байдлыг судалж дүгнэлт гаргахыг тулд төдөрхөй хэргүүдийг татаж хянах.

Энэ хуулийн 374 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1, 3-т заасан нөхцөл байдал илэрсэн, эсхүл хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих ацанд хохирогч, гэрч, сэжигтэн, ялагдагчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт эргэлзээтэй, мөрдөн байцаалтын төдөрхөй ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдаагүй гэж үзвэл прокурор, гэрч, хохирогч, сэжигтэн, ялагдагчийг биечлэн байцаах, шинжээчийг дахин томилж, дүгнэлт гаргуулах, үзлэг, нэгжлэг, туршилатыг давтан хийх зэргээр мөрдөн шалгах ажиллагаа явуулж болно.»

80) 210 дугаар зүйл:

«210-р зүйл. Прокурорын шийлвэрийг заавал биелүүлэх

Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт та-

них бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ хуульд заасан үндэслэл, журмын дагуу гаргасан прокурорын шийдвэрийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллага, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч биелүүлэх үүрэгтэй.

Прокурорын шийдвэрийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч давж заалдсан ивдэл нь энэ хуулийн 127 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд түүнийг биелүүлэх ивдлыг зогсоохгүй.»

81) 211 дүгээр зүйл:

«211-р зүйл. Мөрдөн байцаалт явуулсан хэргийн талаар прокуророос шийдвэрлэвэл зохих асуудлууд

Мөрдөн байцаагчаас шилжүүлсэн хэргийн талаар прокурор дор дурдсан асуудлыг хянах үүрэгтэй:

- 1) гэмт хэргийн бүрэлдэхүүн байгаа эсэх;
- 2) хэргийг хэрэгсэхгүй болгох үндэслэл хэрэгт байгаа эсэх;
- 3) мөрдөн байцаалтыг бүрэн, бодитой явуулсан эсэх;
- 4) сонгосон ял нь хэрэгт байгаа нотолгоонд үндэслэгдсэн эсэх;
- 5) яллагдагчид сонгосон ял нь мөрдөн байцаалтаар тогтоосон бүх гэмт хэргийг хамарч чадсан эсэх;
- 6) гэмт хэрэг үйлдсэн бүх этгээдийг яллагдагчаар татсан эсэх;
- 7) эрүүгийн хуулийн зүйл, хэсгийг зөв хэрэглэсэн эсэх;
- 8) таслан сэргийлэх арга хэмжээг зөв хэрэглэсэн эсэх;
- 9) иргэний нэхэмжлэлийг хангах талаар арга хэмжээ авсан эсэх;
- 10) гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг тодруулж чадсан эсэх, түүнийг арилгах талаар арга хэмжээ авсан эсэх.

82) 212 дугаар зүйл:

«212-р зүйл. Мөрдөн байцаалт явуулсан хэргийн талаар прокуророос гаргах шийдвэр

Мөрдөн байцаалт явуулсан хэргийг прокурор 14 хоногөөс хүтрүүлэхгүй хянаж үзээд дор дурдсан шийдвэрийн аль нэгийг гаргана:

- 1) хэргийг шүүхэд шилжүүлэх;
- 2) хэрэгт нэмэлт ажлалаагаа хийлгэхээр буцаах;
- 3) энэ хуулийн 127-р зүйлийн дагуу хэргийг хэрэгсэхгүй болгох.

Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасан тохиолдолд прокурор ялаах дүгнэлт үйлдэнэ.

83) 213 дугаар зүйл:

«213-р зүйл. Прокурор яллах дүгнэлт үйлдэх үед ялыг өөрчлөх

Яллах дүгнэлт үйлдэх үед прокурор урьд сонгосон ялын зарим хэсгийг хасах, түүнчлэн хөнгөн ялтай хуулийг хэрэглэх эрхтэй.

Хэрэв ялыг хүндрүүлэх буюу жинхэнэ бодит байдлаар нь урьд сонгосон ялаас онцгой ялгаатай болгож өөрчлөх шаардлагатай бол прокурор шинээр ял сонгуулахаар хэргийг мөрдөн байцаагчид буцаана.»

84) 214 дүгээр зүйл:

«214-р зүйл. Прокурор таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх

Прокурор таслан сэргийлэх арга хэмжээг хүчингүй болгох буюу өөрчлөх, хэрэв урьд таслан сэргийлэх арга хэмжээг аваагүй бол шинээр авах эрхтэй.»

85) 215 дугаар зүйл:

«215-р зүйл. Прокурор хэргийг шүүхэд шилжүүлэх

Прокурор яллах дүгнэлт үйлдэж, хэргийг харьяаллын дагуу шүүхэд шилжүүлж, энэ тухай яллагдагчид мэдэгдэнэ.

Хэргийг шүүхэд шилжүүлсний дараа хэргийн талаар гарсан хүсэлт, гомдлыг шүүхэд шууд явуулна.»

86) 215¹ дүгээр зүйл:

«215¹-р зүйл. Яллах дүгнэлт

Яллах дүгнэлт нь тэмдэглэх, тогтоох хэсэг хавсралтаас бүрдэнэ.

Тэмдэглэх хэсэгт яллагдагчийн оног, нэр, түүний үйлдсэн хэргийн товч агуулга, арга, хугацаа, сэдэлт, санаа, зорилго, учруулсан хохирол, зайлшгүй шаардлагатай зарим нотолгоо зэрэг байдлыг дурдана.

Тогтоох хэсэгт яллагдагчийн үйлдсэн хэрэг нь тус улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн ямар зүйл, хэсэгт тохирох, яллагдагчийг шүүхэд шилжүүлэх тухай санал, шүүхийн харьяалал, яллах дүгнэлт үйлдсэн хүний албан тушаал, зэрэгдэнэ, нэр, үйлдсэн хугацааг бичнэ.

Яллах дүгнэлтийн хавсралтад дор дурдсан зүйлийг заана:

1) таслан сэргийлэх арга хэмжээг авагдсан эсэх, түүний хугацаа;

2) эд мөрийн баримт, битүүмжилсэн хөрөнгийн талаархи тодорхойлолт;

3) иргэний нэхэмжлэл, түүнийг хангах талаар авсан аргыг хэмжээ.»

87) 219 дүгээр зүйл:

«219-р зүйл. Яллагдагчийг шүүхэд шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх

Прокуророос шилжүүлсэн хэргийг шүүгч хянаж үзээд захирамж гаргаж, дор дурдсан шийдвэрийн аль нэгийг гаргана:

- 1) яллагдагчийг шүүхэд шилжүүлэх;
- 2) нэмэлт мөрдөн байцаалт хийлгэхээр хэргийг буцаах;
- 3) хэргийг түдгэлзүүлэх;
- 4) хэргийг харьяалах шүүхэд нь шилжүүлэх.

88) 221 дүгээр зүйл:

«221-р зүйл. Яллагдагчийг шүүхэд шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх хугацаа

Яллагдагчийг шүүхэд шилжүүлэх тухай асуудлыг уг хэргийг шүүх хүлээн авсан өдрөөс эхлэн шүүгч 15 хоногоос хэтрүүлэхгүйгээр шийдвэрлэнэ. Энэ хугацаанд яллагдагчийг шүүхэд шилжүүлэх боломжгүй бол тухайн шүүхийн Ерөнхий шүүгчийн захирамжаар хугацааг сунгаж болно.»

89) 222 дугаар зүйл:

«222-р зүйл. Яллагдагчийг шүүхэд шилжүүлэхэд шийдвэрлэвэл зохих асуудлууд

Яллагдагчийг шүүхэд шилжүүлэхдээ шүүгч нь яллагдагч нэг бүрийн талаар дор дурдсан асуудлыг шийдвэрлэж, захирамж гаргана.

1) Яллагдагчид авсан таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх эсэх;

2) шүүх хуралдааныг хаана, хэзээ хийх;

3) мөрдөн байцаалтын шатанд өмгөөлөгч авалгүй шүүдэгчийн өмгөөлүүлэх эрхийг хангах;

4) шүүх хуралдаанд ялагч өмгөөлөгч, гэрч, шинжээч, хохирогч, түүний өмгөөлөгч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдгээрийн төлөөлөгч, хэлмэрчийг дуудлах, оролцуулах;

5) энэ хуулийн 19 дүгээр зүйлд дурдсан тохиолдолд хэргийг хаалттай шүүх хуралдаанаар хэлэлцэх;

6) шүүх хуралдаанд оролцох иргэдийн төлөөлөгчийг томилгох;

7) иргэний нэхэмжлэл болон хөрөнгө хураах ялыг хангах арга хэмжээ.»

90) 223 дугаар зүйл:

«223-р зүйл. Яллагдагчийг шүүхэд шилжүүлэх үед гаргасан хүсэлтийг хянаж хэлэлцэх

Яллагдагчийг шүүхэд шилжүүлэх үед шүүгч нь нэмэлт баримт шаардах, таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх, иргэний нэхэмжлэл хангах арга хэмжээг авал талаар ялаагч, шүүгдэгч, түүний өмгөөлөгч, хохирогч, түүний өмгөөлөгч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний төлөөлөгчөөс гаргасан хүсэлтийг хянаж үзэх үүрэгтэй. Шүүгч хүсэлт гаргасан хүмүүсээс тайлбар авч болно.

Хүсэлтийг хэрхэн шийдвэрлэсэн талаар хүсэлт гаргасан хүмүүст мэдэгдэнэ. Хүсэлтийг хэрэгсэхгүй болгосон шийдвэрт гомдол гаргаж болохгүй боловч шүүх хуралдаан дээр хүсэлтээ дахин тавьж болно.»

91) 229 дүгээр зүйл:

«229-р зүйл. Яллагдагчийг шүүхэд шилжүүлэх тухай захирамж

Яллагдагчийг шүүхэд шилжүүлэх тухай шүүгчийн захирамжид хэвийн шүүхэд шилжүүлж байгаа, шүүгдэгчид авсан таслан сэргийлэх арга хэмжээ, түүнчлэн энэ хуулийн 222 дугаар зүйлд заасан асуудлын талаархи шийдвэрийг тусгана.»

92) 230 дугаар зүйл:

«230-р зүйл. Хэргийг түдгэлзүүлэх, харьяаллын дагуу шүүхэд шилжүүлэх

Хэрэв яллагдагчийг шүүхэд шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх үед яллагдагч өргөн зайлсан буюу оршин байгаа галар нь мэдэгдэхгүй байвал шүүгч захирамж гаргаж, яллагдагчийг олох хүртэл хэргийг түдгэлзүүлж, түүнийг эрэн сурвалжлах даалгаврыг цагдаагийн байгууллагад өгнө. Цагдаагийн байгууллага шүүхийн даалгаврыг өөрийн зардалаар заввал гүйцэтгэнэ.

Сэтгэл мэдрэлийн буюу бусад хүнд өвчний улмаас яллагдагч шүүх хуралдаанд оролцох бололцоогүй болох нь шүүхээс томилсон их эмчийн магадлагаагаар нотлогдсон бол яллагдагчийг эдгэртэл уг хэргийг түдгэлзүүлэх тухай шүүгч захирамж гаргана.

Хэрэв уг хэрэг өөр шүүхэд харьяалагдахаар байвал шүүгчийн захирамжаар түүнийг харьяаллын дагуу шилжүүлнэ.»

93) 231-р зүйл:

«231-р зүйл. Хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаах

Дөр дурдсан тохиолдолд хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаахаар шүүгч захирамж гаргана:

1) урьд сонгосон ял дээр өөр ял нэмж сонгох, эсхүл ялыг хүндрүүлэх;

2) уг хэрэгт холбогдуулан өөр этгээдийг эрүүгийн хариуцлагад татах үндэслэл байгаа бөгөөд тэдний материалыг хэргээс тусгаарлаж болохгүй байгаа;

3) хэргийг буруугаар нэгтгэсэн буюу тусгаарласан.

Нэмэлт мөрдөн байцаалт хийлгэхээр хэргийг прокурорт буцаахдаа ямар үндэслэлээр хэргийг буцааж байгаа, юу нэмж тодруулахыг захирамжид тодорхой заах бөгөөд ялагдагчид авсан таслан сэргийлэх арга хэмжээний асуудлыг шийдвэрлэсэн байвал зохино.»

94) 235 дугаар зүйл:

«235-р зүйл. Шүүх хуралдаанд дуудах

Захирамжид заасан хүмүүсийг шүүх хуралдаанд дуудан ирүүлэх, шүүх хуралдаанд бэлтгэх бусад арга хэмжээг шүүх хуралдааны нарийн бичгийн дарга гүйцэтгэнэ.

Шүүхийн зарлан дуудах хуудас хүлээн аваад ирээгүй оролцогчид болон гэрч, шинжээчийг албадан ирүүлэх тухай шүүгчийн захирамжийг цагдаагийн байгууллага гүйцэтгэнэ.»

95) 236 дугаар зүйл:

«236-р зүйл. Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэх хугацаа

Ялагдагчийг шүүхэд илжүүлэх тухай шүүгчийн захирамж гэрсэн өдрөөс эхлэн 10 хоногоос хэтрүүлэхгүйгээр хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэж эхэлбэл зохино.»

96) 237-дугаар зүйл:

«237-р зүйл. Шүүгчийн захирамжид эсэргүүцэл бичих

Хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаасан шүүгчийн захирамжийг хүлээн авсан өдрөөс тав хоногийн дотор прокурор давж заалдах эсэргүүцэл бичих эрхтэй.»

97) 241 дүгээр зүйл:

«241-р зүйл. Шүүх хуралдаан даргалагч

Шүүх хуралдааныг Ерөнхий шүүгч, эсхүл түүний томилсон шүүгч даргалаа.

Даргалагч шүүх хуралдааныг гагцхүү тухайн хэрэгт холбогдолтой асуудлыг хянан шийдвэрлэхэд чиглүүлж, хэргийг бүх талаас нь бүрэн дүүрэн, бодитойгоор судлан шинжилж үнэм байдлыг тогтоохын тулд хуульд заасан бүх арга хэмжээг авна.»

98) 244 дүгээр зүйлийн 3, 4, 5 дахь хэсэг:

«Яллагч дор дурдсан тохиолдолд шүүгдэгчийг яллахаас татгалзаж саналаа бичгээр гаргана:

1) шүүгдэгч гэм буруугүй болох нь нотлогдсон;

2) хэргийн талаар нэмэлт шалгалт хийх шаардлагатай.

Энэ зүйлийн 3 дахь хэсгийн 1-д заасан тохиолдолд шүүх шүүгдэгчийг цагаатгах ба мөн зүйл, хэсгийн 2-т заасан тохиолдолд хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаана.

Төрийн эрх зүйлийг хамгаалах шаардлагатай гэж үзвэл прокурор иргэний нэхэмжлэл гаргах буюу гарсан нэхэмжлэлийг дэмжих эрхтэй.»

99) 247 дугаар зүйл:

«247-р зүйл. Шүүх хуралдаанд прокурор, өмгөөлөгч, иргэдийн төлөөлөгч ирээгүйн холбогдол

Шүүх хуралдаанд прокурор, өмгөөлөгч, иргэдийн төлөөлөгч ирээгүй ивдэл нь шүүх хуралдааныг хойшлуулах үндэслэл болно.

Прокурор, өмгөөлөгч, иргэдийн төлөөлөгч шүүх хуралдаанд оролцох боломжгүй бол тэднийг сольж болно. Өмгөөлөгчийг гагцхүү шүүгдэгчийн зөвшөөрснөөр солино.

Шинээр оролцох прокурор, өмгөөлөгч, иргэдийн төлөөлөгчид хэргийн материалтай танилцах, шүүгдэгчтэй уулзах, шүүх хуралдаанд бэлтгэх хугацаа олгоно.»

100) 254 дүгээр зүйл:

«254-р зүйл. Эрүүгийн хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаах

Шүүх хуралдааны явцад энэ хуулийн 231 дүгээр зүйл, 244 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан байдал илэрвэл шүүх хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаана.

Нэмэлт мөрдөн байцаалт хийлгэхээр хэргийг прокурорт буцаахдаа шүүх ямар үндэслэлээр хэргийг буцааж байгаа, юу нэмж тодруулахыг тогтоолд заах бөгөөд иллагдагчид авсан таслан сэргийлэх арга хэмжээний агуудлыг шийдвэрлэх үүдэнтэй.

Нэмэлт мөрдөн байцаалт өгүүлж дууссаны дараа яллагдагчийг шүүхэд шилжүүлэх асуудлыг шүүгч ердийн журмаар шийдвэрлэнэ.»

101) 225 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

«Шүүх хуралдааны явцад энэ хуулийн 6 дугаар зүйлд дурдсан байдал тогтоогдовол хэргийг хэрэгсэхгүй болгоно.

Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан тохиолдол үүнд хамаарахгүй.»

102) 257 дугаар зүйл:

«257-р зүйл. Шүүх хуралдаанаас тогтоол, захирамж гаргах журам

Шүүх хуралдааны явцад шийдвэрлэж буй бүх асуудлаар шүүх тогтоол, шүүгч захирамж гаргана.

Шүүх хуралдааныг хавалттай явуулах, нэмж мөрдөн байцаалгахаар хэргийг буцаах, хэргийг түдгэлзүүлэх буюу хэрэгсэхгүй болгох, таслан сэргийлэх арга хэмжээ авах, өөрчлөх, хүчингүй болгох, шүүх хуралдаанд оролцогчдын хэн алийг татгалзах, шинжилгээ хийлгэх тухай зөвлөлдөх тасалгаанд шүүх тогтоол, шүүгч захирамж гаргаж, шүүх бүрэлдэхүүн, шүүгч гарын үсэг зурна.

Бусад асуудлыг шийдвэрлэхдээ тогтоол, захирамжийг шүүх өөрийн үзэмжээр дээр дурдсан журмаар, эсхүл шүүгчид байрандаа зөвлөсний дараа шүүх хуралдааны протоколд тэмдэглэх замаар гаргаж болно.

Шүүх хуралдааны үед гаргасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг ушинг сонгоно.»

103) 259 дүгээр зүйл:

«259-р зүйл. Шүүх хуралдааны журам зөрчигчдөд хүлээлгэх хариуцалга

Шүүх хуралдааны үед шүүгдэгч хуралдааны журам зөрчсөн, түүнчлэн хуралдаан даргалагчийн өгсөн шийдвэрт захирагдахгүй бол хуралдаан даргалагч түүнийг хуралдааны танхимаас зайлуулах тухай урьдчилан сануулна. Журам дахин зөрчөөл шүүгдэгчийг шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжаар хуралдааны танхимаас зайлуулж, хэрт хэлэлцэх ажиллагааг түүний байхгүйд үргэлжлүүлнэ. Харин таслан шийдвэрлэх тогтоолыг ушинг сонгохдоо шүүгдэгчийг байлцуулна.

Хэрэг иллагч, өмгөөлөгч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч болон тэдний төлөөлөгч, шинжээч, хэлмэрч шүүх хуралдааны журам зөрчсөн буюу хуралдаан даргалагчийн шийдвэрт захирагдахгүй байвал хуралдаан даргалагч сануулга өгнө. Дээр дурдсан хүмүүсээс хуралдааны журам дахин зөрчөөл тэднийг 200—5000 төгрөгөөр торгоно.

Шүүх хуралдааны танхимд байгаа бусад хүмүүс дээрх байдлыг гаргавал хуралдаан даргалагчийн шийдвэрээр тэд

нийг шүүх хуралдааны танхимаас зайлуулж 200—5000 төг-
рөөгөөр торгоно.»

104) 272 дугаар зүйл:

«272-р зүйл. Шүүхийн байцаалт эхлэх.

Шүүхийн байцаалт яллагч яллах дүгнэлт увшиж сонсго-
хоос эхэлнэ.

Хэрэв хэргийг мөрдөн байцаалт явагдаагүй бол шүүхийн
байцаалт яллагдагчаар татах тухай прокурорын тогтоолыг
ушиж сонсгохоос эхэлнэ.

Хуралдаан даргалагч нь шүүгдэгч нэг бүрээс яллах дүг-
нэлт ойлгогдож байгаа эсэхийг асууж, хэрэв шаардлагатай
байвал шүүгдэгчд яллах дүгнэлтийн утгыг тайлбарлаж өг-
но.»

105) 273 дугаар зүйл:

«273-р зүйл. Ноголох баримт шинжлэх журам

Шүүхийн байцаалтад ноголох баримтыг шинжлэхдээ эх-
лээд яллах, дараа нь цагаатгах болон бусад баримтыг шинж-
лэх дарааллыг баримтална.»

106) 274 дүгээр зүйл:

«274-р зүйл. Шүүгдэгчийг байцаах журам

Хуралдаан даргалагч нь шүүгдэгчээс үйлдсэн хэргийн та-
лаар мэдүүлэг өгөх эсэхийг асууж түүнийг байцаах ажилла-
гааг эхэлнэ. Дараа нь яллагч, өмгөөлөгч, бусад шүүгдэгч,
тэдний өмгөөлөгч, түүнчлэн хохрогч, иргэний нэхэмжлэгч,
иргэний хариуцагч болон тэдний төлөөлөгч хуралдаан дарга-
лагчийн зөвшөөрөлтэйгээр асуурт тавина.

Шүүгч өөрийн үлэмжээр, харин иргэдийн төлөөлөгч, ял-
лагч, шүүгдэгчийн өмгөөлөгч хуралдаан даргалагчийн зөв-
шөөрөлтэйгээр, шүүхийн байцаалтын аль ч үед шүүгдэгчийг
асуух эрхтэй.

Хэргийн үнэнийг тогтооход шаардлагатай онцгой тохиол-
долд шүүгдэгчийг бусад шүүгдэгчийн байхгүйгээр байцаах
явлыг татахуу шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолоор
гүйцэтгэж болно. Тэгэхдээ шүүгдэгчийг шүүх хуралдааны
танхимд орж ирсний дараа түүнийг байхгүйд гаргасан мэдүүл-
эгийн утгыг хуралдаан даргалагчаас танилцуулж өөрийн
нь байхгүйд байцаагдсан шүүгдэгчид асуулт тавих болол-
цоог түүнд олгоно.

Хуралдаан даргалагчийн зөвшөөрөлтэйгээр шүүгдэгч шүү-
хийн байцаалтын ямар ч үед нэмж мэдүүлэг өгч болно.»

107) 275 дугаар зүйл:

«275-р зүйл, Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын үед шүүгдэгчийн гаргасан мэдүүлгийг уншиж сонгох»

Хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн-бодитой шинжлэхийн тулд хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны үед шүүгдэгчийн гаргасан мэдүүлгийг дор дурдсан тохиолдлуудад шүүх хуралдаан дээр уншиж сонгоно:

1) урьд гаргасан мэдүүлэг нь шүүх хуралдаан дээр гаргаж байгаа мэдүүлгээс ноцтой зөрсөн;

2) шүүгдэгч шүүх хуралдаан дээр мэдүүлэг гаргахаас татгалзсан;

3) хэргийг шүүгдэгчийн байхгүйд хэлэлцэж байгаа.

Энэ журам нь шүүгдэгчээс урьд шүүхэд гаргасан мэдүүлгийг уншихад нэг адил хамаарна.»

108) 276 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэг:

«Хуралдаан даргалагч гэрчийг байцаахын өмнө түүний биеийн байцаалт, шүүгдэгч, хохирогчидтой ямар харилцаатай болохыг тодруулж, хэргийн талаар мэдэх бүх зүйлээ үнэн зөв мэдүүлэх үүргийг тайлбарлан мэдүүлэг өгөхөөс татгалзах буюу зайлсхийх, санаатайгаар худал мэдүүлэг гаргавал хүлээлгэх харнуцлагын тухай гэрчид сануулна. Энэ талаар шүүх хуралдааны протоколд гарын үсэг зуруулна.

Хуралдаан даргалагч ямар зургаан нас хүрээгүй гэрчид хэргийн талаар мэдэх зүйлээ үнэн зөв мэдүүлэхийн ач холбогдлыг тайлбарлан өгөх бөгөөд харин мэдүүлэг өгөхөөс татгалзах буюу зайлсхийх, санаатайгаар худал мэдүүлбэл Хүлээлгэх харнуцлагын тухай тэдэнд сануулж болохгүй.»

109) 277 дугаар зүйл:

«277-р зүйл, Гэрчийг байцаах журам»

Гэрчийг тус тусад нь байцаана.

Гэрчид хэргийн талаар мэдэх бүх зүйлээ ярихыг мэдэгднэ. Гэрчид түүнийг шүүх хуралдаанд оролцуулах хүсэлт гаргасан эггээд гэргүүн ээлжинд асуулт тавина.

Дараа нь гэрчээс ялагч, шүүгдэгч болон түүний өмгөөлөгч, түүнчлэн хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний төлөөлөгч хуралдаан даргалагчийн зөвшөөрөл тэйгээр асуулаг тавина. Хэрэгт холбогдолгүй асуулаг тавихыг хуралдаан даргалагч хориглоно.

Шүүгч өөрийн үзэмжээр, харин иргэдийн төлөөлөгч, яллагч, шүүгдэгчийн өмгөөлөгч хуралдаан даргалагчийн зөвшөөрөлтэйгээр шүүхийн байцаалтын аль ч үед гэрчид асуулт тавих эрхтэй.

Шүүх өөрийн санаачилгаар, эсхүл яллагч, шүүгдэгч болон түүний өмгөөлөгч, түүнчлэн бусад оролцогчдын хүсэлтээр гэрчүүдийг нүүрэлдүүлэн байцааж болно.

Байцаагдсан гэрчүүд шүүх хуралдааны танхимд үлдэх бөгөөд шүүхийн байцаалт дуусгал хуралдаан даргалагчийн зөвшөөрөлтэйгээр гадагш явж болохгүй.

Хуралдаан даргалагч нь яллагч, шүүгдэгч, өмгөөлөгч, түүнчлэн хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний харнуцагч, тэдний төлөөлөгчдийн саналыг сонссоны дараа, байцаагдсан гэрчийг шүүхийн байцаалт дуусахаас өмнө шүүх хуралдааны танхимаас гарч явахыг зөвшөөрч болно.»

110) 280 дугаар зүйл:

«280-р зүйл. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын үед гэрчийн гаргасан мэдүүлгийг уншиж сонсгох

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын үед гэрчийн гаргасан мэдүүлэг нь шүүхэд гаргасан мэдүүлгээс нонтой зөрчсөн, түүнчлэн гэрч шүүх хуралдаанд ирээгүй бол хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын үед түүний гаргасан мэдүүлгийг уншиж сонсгож болно.»

111) 283 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

«Асуултыг эхлээд яллагч, шүүгдэгч, түүний өмгөөлөгч, түүнчлэн хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний харнуцагч, тэдний төлөөлөгч хуралдаан даргалагчийн зөвшөөрөлтэйгээр тавина. Шүүгч өөрийн үзэмжээр; харин иргэдийн төлөөлөгч, яллагч, шүүгдэгчийн өмгөөлөгч хуралдаан даргалагчийн зөвшөөрөлтэйгээр шүүхийн байцаалтын аль ч үед шинжээчид асуулт тавих эрхтэй.»

112) 289 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг:

«Шүүхийн байцаалт дууссаны дараагаар шүүмжлэл сонсох асуудаад шилжиж орно. Шүүмжлэл нь яллагч, өмгөөлөгч, хэрэв шүүх хуралдаанд өмгөөлөгч оролцоогүй бол шүүгдэгч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний харнуцагч буюу тэдний төлөөлөгчийн хэлэх үгээс бүрдэнэ.

Шүүмжлэл явуулах хүмүүсийн үг хэлэх дарааллыг тэдний саналаар шүүх тогтооно.»

113) 290¹ дүгээр зүйл:

«290¹-р зүйл, Иргэдийн төлөөлөгч дүгнэлт гаргах

Шүүх хуралдаанд оролцож байгаа иргэдийн төлөөлөгч шүүгдэгч гэм буруутай эсэх талаар бичгээр дүгнэлт гаргана.

Иргэдийн төлөөлөгч шаардлагатай гэж үзвэл дүгнэлтээ зөвлөлдөх тасалгаанд гаргана. Шүүгдэгчийн гэм буруугийн талаар иргэний төлөөлөгчдийн санал нэгдвэл хамтарсан дүгнэлт, зөрвөл тус тусдаа дүгнэлт гаргана.»

114) 291 дүгээр зүйл:

«291-р зүйл, Таслан шийдвэрлэх тогтоол гаргахаар шүүх зөвлөлдөх тасалгаанд орох

Шүүгдэгчийн гэм буруугийн талаар иргэдийн төлөөлөгчдийн дүгнэлтийг сонссоны дараа шүүх таслан шийдвэрлэх тогтоол гаргахаар зөвлөлдөх тасалгаанд орох бөгөөд хуралдаан даргалагч энэ тухай шүүх хуралдааны тавхимд байсан хүмүүст зарлан мэдэгдэнэ.»

115) 292 дугаар зүйл:

«292-р зүйл, Монгол Улсын нэрийн өмнөөс таслан шийдвэрлэх тогтоол гаргах

Шүүх таслан шийдвэрлэх тогтоолыг Монгол Улсын нэрийн өмнөөс гаргана.»

116) 296 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

«Гэм буруутай этгээдийг тэнсэх тухай ажлын газрынх нь хамт олон, олон нийтийн байгууллагаас гаргасан хүсэлтийг харгалзан уг этгээдийг тэнссэн бол шүүх түүнийг засаж хүмүүжүүлэхээр хүсэлт гаргасан байгууллага буюу хамт олонд шилжүүлэн өгч болно.»

117) 299 дүгээр зүйл:

«299-р зүйл, Шүүгчийн тусгай санал

Шүүгч тусгай саналтай байвал түүнийгээ зөвлөлдөх тасалгаанд бичгээр гаргах эрхтэй. Тусгай саналыг таслан шийдвэрлэх тогтоол уншиж сонгоход зарлахгүй бөгөөд хэргийн хэрэгт хавсаргана.»

118) 315 дугаар зүйл:

«315-р зүйл, Торгууль оногдуулах журам

Энэ хуулийн 92, 259, 384 дүгээр зүйлд дурдсан торгуулийг уг эрүүгийн хэргийг харьяалан авч хэлэлцэх шүүх оногдууна.

Хэрэв зөрчлийг шүүх хуралдаан дээр гаргасан бол торгох тухай шийдвэрийг уг хэргийг хэлэлцэж байгаа шүүх тухайн шүүх хуралдаанаас гаргана.

Бусад тохиолдолд торгууль оногдуулах асуудлыг шүүгч торгууль хүлээлгэвэл зохих этгээдийг дуудан ирүүдэж шийдвэрлэнэ. Дуудагдсан этгээд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй явдал хэрэг хэлэлцэхэд сэд болдохгүй.

Шүүгч уг зөрчлийн тухай хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч буюу прокуророос үйлдсэн протокол буюу шүүх хуралдааны протоколоос зөвхөн холбогдох хэсгийг уншиж сонсоно. Дараа нь зөрчил гаргасан этгээдийн үгийг сонсож шийтгэвэр гаргана.»

119) Хорин есдүгээр бүлгийн гарчиг:

«ХОРИН ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

Шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол, түүнчлэн шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид давж заалдах гомдол гаргах»

120) 317 дугаар зүйл:

«317-р зүйл. Таслан шийдвэрлэх тогтоолд давж заалдах гомдол гаргах буюу эсэргүүцэл бичих эрхтэй хүмүүс

Шүүгдэгч, түүний өмгөөлөгч болон хууль ёсны төлөөлөгч, иргэдийн төлөөлөгч, түүнчлэн хохирогч, түүний төлөөлөгч, шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолд давж заалдах журмаар гомдол гаргах, яллагч эсэргүүцэл бичих эрхтэй.

Иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, гэдний төлөөлөгч таслан шийдвэрлэх тогтоолын иргэний нэхэмжлэлтэй холбогдох хэсэгт давж заалдах гомдол гаргах эрхтэй.

Шүүхээр цагаатгагдсан этгээд таслан шийдвэрлэх тогтоолын цагаатгасан шалтгаан үндэслэлд холбогдох хэсэгт давж заалдах гомдол гаргах эрхтэй.»

121) 318 дугаар зүйлийн I дэх хэсэг:

«Таслан шийдвэрлэх тогтоолд давж заалдах журмаар гомдол гаргах буюу эсэргүүцэл бичих:

1) сум болон сум дундын, дүүргийн шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолын талаар зохих аймаг, нийслэлийн шүүхэд;

2) ямаг, нийслэлийн шүүх, Улсын дээд шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолын талаар Улсын дээд шүүхэд.»

122) 322 дугаар зүйл:

«322-р зүйл. Гомдол буюу эсэргүүцэл бичсэний холбогдол

Таслан шийдвэрлэх тогтоол хүчин төгөлдөр болоогүй байхад давж заалдах гомдол буюу эсэргүүцэл бичигдсэн байвал таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэхийг түдгэлзүүлдэг.

Шүүх хэргийг гомдол, эсэргүүцлийн хамт давж заалдах шатны шүүхэд явуулна.»

123) 323 дугаар зүйл:

«323-р зүйл. Анхан шатны шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид гомдол гаргах, эсэргүүцэл бичих

Эрүүгийн хэргийн талаар гарсан анхан шатны шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид энэ хуулийн 317-р зүйлд дурдсан (иргэдийн төлөөлөгчөөс бусад) хүмүүс гомдол гаргаж, прокурор эсэргүүцэл бичиж болно.

Энэ хуулийн 41, 42, 106, 223, 229, 230, 243, 253, 256, 259 (үүнд торгууль оногдуулах тухай шийтгэвэр хамаарагдахгүй), 270, 271, 274, 279, 282-р зүйл, 300-р зүйлийн 1 дэх хэсэг, 361, 391, 391¹-р зүйлд дурдсан тохиолдлуудад гаргасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид давж заалдах гомдол гаргах буюу эсэргүүцэл бичиж болохгүй.

Шүүхийн тогтоол, захирамжид тэдгээрийг гарсан өдрөөс хойш 10 хоногийн дотор гомдол, эсэргүүцэл гаргаж болно. Гомдол, эсэргүүцлийг энэ хуулийн гучдугаар бүлэгт дурдсан журмын дагуу хэлэлцэнэ.»

124) 325 дугаар зүйл:

«325-р зүйл. Давж заалдах шатны шүүхэд эрүүгийн хэргийг хянан хэлэлцэх хугацаа

Давж заалдах гомдол буюу эсэргүүцэлтэй эрүүгийн хэргийг хүлээн авсан өдрөөс эхлэн 30 хоногоос хэтрүүлэхгүйгээр хянан хэлэлцэнэ. Энэ хугацаанд хэргийг хянан хэлэлцэх боломжгүй бол тухайн шүүхийн ерөнхий шүүгчийн захирамжаар хугацааг сунгаж болно.

Хэрэг хянан хэлэлцэх цагийг гурав хоногийн өмнө зарлан мэдэгдэнэ.»

125) 327 дугаар зүйл:

«327-р зүйл. Давж заалдах шатны журмаар эрүүгийн хэрэг хянан хэлэлцэхэд оролцох хүмүүс

Давж заалдах шатны журмаар эрүүгийн хэрэг хянан хэлэлцэх шүүх хуралдаанд прокурор, шийтгэгдсэн буюу цагаатгагдсан этгээд, түүний өмгөөлөгч, хохирогч, түүнчлэн иргэний нэхэмжлэгч, иргэний харуцагч, тэдний төлөөдөгч болон давж заалдах гомдол гаргасан иргэдийн төлөөлөгч оролцох эрхтэй.

Дээр дурдсан хүмүүс давж заалдах шатны шүүх хуралдаанд биечлэн оролцох хүсэлт гаргавал тэдэнд хэрэг хэлэлцэх өдөр, цаг, газрыг мэдэгдэнэ. Давж заалдах шатны шүүх хуралдаанд прокурор оролцож байгаа тохиолдолд шүүгдэгч, эсхүл түүний өмгөөлөгчийг заавал оролцуулна. Бусад оролцогч шүүх хуралдаанд ирээгүй явдал нь хэрэг хэлэлцэхэд саал болохгүй.»

126) 328 дугаар зүйл:

«328-р зүйл. Давж заалдах шатны шүүхэд шинэ материал гаргаж өгөх

Энэ хуулийн 317 дугаар зүйлд дурдсан хүмүүс хэрэг хэлэлцэхийн өмнө буюу хэлэлцэж байгаа үед гомдол буюу эсэргүүцэлд дурдсан зүйлийг нотлох буюу үгүйсгэж, давж заалдах шатны шүүхэд нэмэлт нотлох баримт гаргаж өгөх эрхтэй.»

127) 329 дүгээр зүйлийн 1, 2, 3, 4 дэх хэсэг:

«Хуралдаан даргалагч шүүх хуралдааныг нээж, ямар хэрэг хэлэлцэх тухай зарлана. Шүүх хуралдааны нарийн бичгийн даргаас шүүх хуралдааны ирлийг танилцуулсны дараа хэрэг хэлэлцэх бололцоотой эсэх тухай асуудлыг хуралдаан даргалагч шийдвэрлэж, шүүх бүрэлдэхүүн болон прокурор, шинжээч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, хэлмэрчний нарийг зарлаж, хэрэг хэлэлцэхэд оролцох хүмүүс нь шүүх бүрэлдэхүүн болон дээр дурдсан хүмүүсээс хэн алийг татгалзах эсэхийг асууна.

Хуралдаан даргалагч хэрэг хэлэлцэхэд оролцох хүмүүсээ хүсэлт байгаа эсэхийг асууж, хэрэн хүсэлт гаргасан байвал түүнийг хэрхэн шийдвэрлэсэн тухай тогтоол гаргана.

Хэрэг хэлэлцэх ажиллагаа нь шүүхийн аль нэг шүүгчийн илтгэлээр эхлэх бөгөөд илтгэлд хэргийн агуулга, гомдол болон эсэргүүцлийн үндэслэлийг дурдана. Шүүгч илтгэсний

дараагаар давж заалдагч гомдол, эсэргүүцлээ тайлбарлаж ярина. Дараа нь нэмэлт нотлох баримтыг шинжлэн судалж шүүх хуралдаанд оролцож байгаа хүмүүс тайлбар гаргаж улмаар прокурорын дүгнэлт, шийтгэгдсэн буюу цагаатгагдсан этгээд, тэдний өмгөөлөгчийн нэмэлт тайлбарыг анч магадлал гаргахгаар зөвлөлдөх тасалгаанд орно.»

128) 329^а-р зүйл. Давж заалдах шатны шүүх хуралдааны протокол

Давж заалдах шатны шүүх хуралдааны нарийн бичгийн дарга энэ хуулийн 105 дугаар зүйлд заасан журмыг баримтлан протокол үйлдэнэ. Протоколд засвар оруулах саналыг энэ хуулийн 106 дугаар зүйлд заасан журмаар гаргах буюу хэлэлцэнэ.

Хуралдаан даргалагч шүүх хуралдаанд оролцогчдыг протоколтой танилцах бололцоогоор хангах үүрэгтэй.

Шүүх хуралдааны протоколыг тухайн хэрэгт заавал хавсаргана.»

129) 336 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4, 8 дахь заалт:

«4) сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг өмгөөлүүлэх бололцоогоор хангаагүй;

8) эрүүгийн хэргийг анхан шатны журмаар хамтран шийдвэрлэхэд иргэдийн төлөөлөгч оролцуулаагүй.»

130) 339 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг:

«Урьд нь гэм буруутайд тооцогдож шүүхээр ял шийтгүүлж уг ялаа эдэлж байсан буюу эдэлж дууссан этгээдийн хэрэг нэмэлт мөрдөн байцаалтад буцсан бол уг хэргийг шүүхээр заавал дахин хэлэлцэж эцсийн шийдвэр гаргана. Энэхүү заалт нь шүүх хяналтын журмаар болон шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас нэмэлт мөрдөн байцаалтад буцсан хэргийг шийдвэрлэхэд нэгэн адил хамаарна.»

131) 342 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

«Давж заалдах шатны шүүхийн магадлалд дурдвал зохих зүйлүүд:

1) магадлалыг хэзээ, хаана гаргасан;

2) магадлал гаргасан шүүхийн нэр, шүүх бүрэлдэхүүн, давж заалдах шатны шүүхэд хэрэг хянан хэлэлцэхэд оролцсон бусад хүмүүс;

3) давж заалдах гомдол буюу эсэргүүцэл бичсэн хүн;

4) давж заалдах шатны шүүхээс гомдол буюу эсэргүүцлийн талаар гаргасан шийдвэр.»

132) 345 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

«Давж заалдах шатны шүүхийн магадлалд хяналтын журмаар эсэргүүцэл бичиж болно.»

133) 347 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

«Таслан шийдвэрлэх тогтоол гарсан өдрөөсөн хойш 10 хоног дуусмагц хуулийн хүчин төгөлдөр болно. Таслан шийдвэрлэх тогтоол хүчин төгөлдөр болоогүй байх хугацаанд давж заалдах гомдол буюу эсэргүүцэл бичигдсэн бол уг тогтоол дээр шатны шүүхээс хэргийг яваж хэлэлцсэнээр хуулийн хүчин төгөлдөр болно.»

134) 349 дүгээр зүйл:

«349-р зүйл. Шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол, магадлал, тогтоол, шийдвэр захирамжийг заалал биелүүлэх

Хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол, магадлал, тогтоол, шүүгчийн захирамжийг байгууллага, албан тушаалтан, иргэн заалал биелүүлэх үүрэгтэй.»

135) 352 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

«Хорих, засан хүмүүжүүлэх ажил хийх ялаар шийтгэсэн таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэхийг дор дурдсан үндэслэлийн эль нэг нь байвал хойшлуулж болно:»

136) 352 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

«Онц хүнд гэмт хэрэг үйлдсэн буюу санаатай гэмт хэрэгт удаа дараа шийтгэгдсэн, түүнчлэн онц аюултай гэмт хэрэгт нээр тооцогдсон этгээлийн талаар гарсан таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэх явлыг хойшлуулж болохгүй.»

137) 354 дүгээр зүйл:

«354-р зүйл. Ялаас хугацааны өмнө тэнсэн суллах, ялыг хөнгөн ялаар солих

Эрүүгийн хуулийн 50, 53 дугаар зүйлд дурдсанаар ялаас хугацааны өмнө тэнсэн суллах буюу ялыг хөнгөн ялаар солих тухай асуудлыг хорих ял эдлүүлэх байгууллагын тодорхойлолт, прокурорын дүгнэлтийг үндэслэн хорих ял эдлүүлэх байгууллагын оршин байгаа газрын шүүхийн шүүгч захирамж гаргаж шийдвэрлэнэ.

Тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулахыг хориглох ялаас чөлөөлөх асуудлыг шийтгэгдсэн этгээдийн хүсэлт, түүний ажиллаж байгаа газрын тодорхойлолтыг үндэслэн шүүгч шийдвэрлэнэ.

Ялаас хугацааны өмнө тэнсэн суллах буюу ялыг хөнгөн ялаар солих тухай хүсэлтийг хэрэгсэхгүй болгож шүүгчийн захирамж гарсан өдрөөс хойш зургаан сар болоогүй бол уг асуудлыг шүүх дахин авч хэлэлцэхгүй.

Ялаас хугацааны өмнө тэнсэн суллах буюу ялыг хөнгөн ялаар солих тухай хүсэлтийг шүүгч шийдвэрлэхдээ гэмт хэргийн хүнд, хөнгөн, шийтгэгдсэн этгээдийн хувийн байдал, зан төлөв, дасрал, хүмүүжил зэргийг харгалзан үзнэ.

Ялаас хугацааны өмнө тэнсэн суллах буюу ялыг хөнгөн ялаар солих тухай захирамж гарсан бол уг этгээдийг нэн даруй суулгана.

Ялаас хугацааны өмнө тэнсэн суллах буюу ялыг хөнгөн ялаар солих тухай захирамжид давж заалдах гомдол гаргаж болохгүй бөгөөд харин прокурор эсэргүүцэл бичиж болно.»

138) 355 дугаар зүйл:

«355-р зүйл. Гинданд хорих ялыг хорих ангид эдлүүлэхээр буюу хорих ангид эдлэх ялыг гинданд хорихоор солих

Эрүүгийн хуулийн 22 дугаар зүйлийн 12 дахь хэсэгт зааснаар гинданд хорих ялыг зохих дэглэмийн хорих ангид эдлүүлэхээр буюу хорих ангид эдлэх ялыг гинданд хорихоор солих явдлыг хорих ил эдлүүлэх байгууллагын саналаар, прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүгч захирамж гаргаж шийдвэрлэнэ.

Гинданд хорих ялыг зохих дэглэмийн хорих ангид эдлүүлэхээр солих тухай саналыг хэрэгсэхгүй болгосон тухай захирамж гарсан өдрөөс хойш нэг жил болоогүй бол уг асуудлыг шүүх дахин авч хэлэлцэхгүй.»

139) 356 дугаар зүйл:

«356-р зүйл. Торгох буюу засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг хорих ялаар солих

Торгох буюу засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг хорих ялаар солих явдлыг тухайн төрлийн ялын биелэлтэд хяналт тавьж байгаа байгууллагын санал, прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүгч захирамж гаргаж шийдвэрлэнэ.

Горгох буюу засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг хорих ялаар солих тухай шүүгчийн захирамжид ердийн журмаар давж заалдах гомдол гаргах буюу эсэргүүцэл бичиж болно.»

140) 357 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

«Хорих ял эдэлж байгаа этгээд бие эрхтэндээ санаатайгаар гэмтэл учруулах буюу гэмт хэрэг үйлдэж байхдаа гэмтсэн, түүнчлэн хуурамчаар өмчилсөн бол уг этгээдийн эмнэлэгт байсан хугацааг ял эдэлсэн хугацаанд оруулж тооцохгүй.»

141) 359 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

«Таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах, Эрүүгийн хуулийн 45 дугаар зүйлийн дагуу таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэхгүй болон торгох, засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг өөр ялаар солих, түүнчлэн таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэх үед гарсан ямар нэг тодорхой биш зүйлүүдийг тодруулах асуудлыг уг тогтоол гаргасан шүүхийн шүүгчийн захирамжаар шийдвэрлэнэ.»

142) 360 дугаар зүйлийн 4, 6 дахь хэсэг:

«Ялаас хугацааны өмнө гэсэн суллах буюу ялыг хөнгөн ялаар солих, гинданд хорих ялыг зохих дэглэмийн хорих ангид эдлүүлэхээр солих, зохих дэглэмийн хорих ангид эдлэх ялыг гинданд хорихоос солих тухай асуудлыг шийдвэрлэхэд хорих ял эдлүүлэх байгууллагын төлөөлөгчийг оролцуулах.

Хэрэг хэлэлцэх ажиллагааг шүүгчийн мэдээлээр эхлэх бөгөөд дараа нь шүүх хуралдаанд ирсэн хүмүүсийн санал ба прокурорын дүгнэлтийг сонсож улмаар шүүгч захирамж гаргахаар зөвлөлдөх тасалгаанд орно.»

143) 361 дүгээр зүйл:

«361-р зүйл, Ял шийтгэлгүйд тооцох тухай хүсэлтийг хэлэлцэх

Эрүүгийн хуулийн 54 дүгээр зүйлд дурдсанаар хугацаанаас өмнө ял шийтгэлгүйд тооцох тухай асуудлыг ялаа эдэлж дууссан этгээдийн оршин сууж байгаа газрын сумын болон сум дундын, дүүргийн шүүхийн шүүгч ял эдэлсэн этгээд буюу түүний өмгөөлөгчийн, эсхүл ажиллаж байгаа байгууллагынх нь хүсэлтээр шийдвэрлэнэ.

Шүүхэд ирсэн энэхүү хүсэлтийн тухай прокурорт мэдэгдэнэ. Шүүх хуралдаанд прокурор ирээгүй явдал уг хүсэлтийг хэлэлцэхэд саад болохгүй.

Хүсэлтийг хэлэлцэхэд өмгөөлөгч, холбогдох этгээд, хүсэлт гаргасан байгууллагын төлөөлөгчийг байлцуулж болно. Ял шийтгэлгүйд тооцох тухай хүсэлтийг хэлэлцэх ажлалагчид нь шүүгчийн мэдээллээр эхлэх бөгөөд дараа нь прокурорын дүгнэлт, шүүхэд дуудагдсан хүмүүсийн саналыг сонсоно.

Ял шийтгэлгүйд тооцох хүсэлтийг шүүгч хэрэгсэхгүй болгож захирамж гаргасан тохиолдолд захирамж гарсан өдрөөс хойш нэг жил өнгөрөөгүй бол тэр тухай хүсэлтийг дахин авч хэлэлцэхгүй.»

144) IV хэсгийн гарчиг:

«Давж заалдах шатны шүүхийн магадлалыг хянах.»

145) 362 дугаар зүйл:

«362-р зүйл. Давж заалдах шатны шүүхийн магадлалд эсэргүүцэл бичих журам

Давж заалдах шатны шүүхийн магадлалд Дээд шүүхийн шүүгчид байнгын шийтгэх ажиллагаанд оролцогчдын томдөл буюу өөрийн үзэмжээр, Улсын ерөнхий прокурор шүүх хуралдаанд оролцсон прокурорын саналаар эсэргүүцэл бичиж болно.

Дээд шүүхийн шүүгч, Улсын ерөнхий прокурор нь бичсэн эсэргүүцлээ түүнийг Дээд шүүхийн зөвлөлдөх дуралдааны шийдлээр гараххаас өмнө эгүүлэн авч болно.»

146) 363 дугаар зүйл:

«363-р зүйл. Таслан шийдвэрлэх тогтоол, давж заалдах шатны шүүхийн магадлал биелүүлэхийг түдгэлзүүлэх

Эсэргүүцэл бичигдсэн тэглэн шийдвэрлэх тогтоол, давж заалдах шатны шүүхийн магадлал, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж биелүүлэхийг уг хэргийг хянаж шийдлээр гаргах хүртээ Дээд шүүхийн шүүгч түдгэлзүүлэх эрхтэй.»

147) 366 дугаар зүйл:

«366-р зүйл. Эрүүгийн хэргийг татан авах

Улсын дээд шүүх томдөл, эсэргүүцлийн дагуу хэргийг хянах, шүүхийн практик судлалын тулд Эрүүгийн ямар ч хэргийг доод шатны шүүхээс татан авах эрхтэй.

Улсын ерөнхий прокурор нь шүүх хуралд оролцсон прокурор санал бичсэн хэргийг зохих шатны шүүхээс татан авах эрхтэй. Түүнчлэн Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн

таааар дүгнэлт гаргах, хэрэг бүртгэх мөрдөн байцаалх ажлын байдлыг судалж үзэхийн тулд Улсын ерөнхий прокурор шүү-эжэс эрүүгийн хэрэг татан авч болно.»

148) 367 дугаар зүйл:

<367-р зүйл. Эсэргүүцлийг хянах журам

Эсэргүүцэлтэй хэргийг 21 хоногоос хэтрүүдэхгүйгээр Дээд шүүхийн зөвлөлдөх хуралдаанаар хянан хэлэлцэнэ. Энэ хугацаанд хэргийг зөвлөлдөх хуралдаанд оруулах боломжгүй бол Дээд шүүхийн ерөнхий шүүгч хугацааг сунгаж болно.»

149) 367¹ дүгээр зүйл:

<367¹-р зүйл. Дээд шүүхийн зөвлөлдөх хуралдаанаар хэрэг хэлэлцэх журам

Зөвлөлдөх хуралдаанаар хэргийг Дээд шүүхийн 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хэлэлцэж эсэргүүцлийг үндэслэлтэй гэж үзвэл хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх, үндэслэлгүй гэж үзвэл эсэргүүцлийг хэрэгсэхгүй болгох тогтоол гаргаж түүнд хуралдаанд оролцсон шүүгч нар гарын үсэг зурна.

Улсын дээд шүүхийн шүүгч, Улсын ерөнхий прокурор зөвлөлдөх хуралдааны тогтоолыг э; зохиоогоривчл дахин нэг удаа эсэргүүцэл бичих эрхтэй бөгөөд энэхүү эсэргүүцлийг шүүх оор бүрэлдэхүүнтэйгээр зөвлөлдөх хуралдаанаар хэлэлцэж нэг зүйлийн 1 дэх дэсэгт заасан шийдвэрийн аль нэгийг гаргана.»

150) 368 дугаар зүйл:

<368-р зүйл. Хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан хэлэлцэх журам

Хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай тогтоол гарснаас хойш 15 хоногоос хэтрүүдэхгүйгээр уг хэргийг хянан хэлэлцэнэ.

Хяналтын шатны шүүх хуралдаанд Улсын ерөнхий прокурор оролцох эрхтэй.

Хэргийг зөвлөлдөх хуралдаанд оруулсан шүүгч илтгэнэ. Илтгэгч хэргийн байдал, таслан шийдвэрлэх тогтоол, давж заалдах шатны шүүхийн магадлалын болон эсэргүүцлийн агуулгыг танилцуулна. Дээд шүүхийн шүүгч нар илтгэгчид асуулт тавьж болно. Үүний дараа Улсын ерөнхий прокурор эсэргүүцлээ дэмжиж тайлабар хэлэх эрхтэй.

Дараа нь шүүх бүрэлдэхүүн зөвлөлдөх тасалгаанд орж тогтоол гаргана. Хэргийн талаар гарах тогтоолыг хуралдаанд оролцож байгаа шүүгчдийн олонхийн саналар батлах бөгөөд хэрэв санал тэнцсэн бол эсэргүүцлийг хэрэгсэхгүй болгоно. Дээд шүүхийн шийдвэр эдсийн Сайх боловч Дээд шүүхийн шүүгчдийн гуравны нэгээс доошгүй нь эсэргүүцлийг дахин авч хэлэлцэх санал гаргасан бол хэргийг хяналтын журмаар дахин нэг удаа хэлэлцэж болно. Энэ тохиолдолд эсэргүүцэл, түүнийг дэмжсэн Дээд шүүхийн шүүгчдийн саналыг хуралдаанд оролцсон шүүгчдийн дийлэнх олонхи нь дэмжсэн бол эсэргүүцлийг хүлээн авсан тогтоол гаргана.»

151) 369 дүгээр зүйл:

«369-р зүйл. Хяналтын шатны шүүхийн шийдвэр

Хяналтын шатны шүүх дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана:

1) давж заалдах шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээж эсэргүүцлийг хэрэгсэхгүй болгох;

2) давж заалдах шатны шүүхийн магадлалд өөрчлөлт оруулах;

3) давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгож анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээх буюу өөрчлөлт оруулах;

4) давж заалдах шатны шүүхийн магадлал болон анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож хэргийг хэрэгсэхгүй болгох, эсхүл түүнийг шинэчлэн мөрдөн байцаагдах буюу шүүхээр шинэчлэн хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцаах.»

152) 370 дугаар зүйл:

«370-р зүйл. Давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгох буюу өөрчлөх үндэслэл»

Давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрийг үндэслэлгүйгээр хүчингүй болгосон буюу өөрчилсөн, эсхүл үндэслэлгүйгээр хэвээр үлдээсэн, түүнчлэн давж заалдах шатны шүүхээс хэрэг хянахдаа хууль зөрчсөн нь түүнээс магадлал зөв гаргах явдалд муугаар нөлөөлсөн гэж хяналтын шатны шүүх үзнэл давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгох буюу өөрчилнө.»

153) 371 дүгээр зүйл:

«371-р зүйл. Хяналтын шатны шүүхийн эрх хэмжээ

Шүүх хяналтын журмаар хэргийг хянан хэлэлцэхдээ эр-

гийн бүх ажиллагааг бүрэн хянаж үзэх үүрэгтэй. Хэрэгт хэд хэдэн этгээд шийтгэгдсэн бөгөөд эсэргүүцэл нь шийтгэгдсэн нэг буюу хэсэг этгээдийн талаар бичигдсэн байсан ч шүүх хэргийг бүх шийтгэгдэгчийн талаар хянан хэлэлцэх үүрэгтэй.

Шүүх хэргийг шүүхийн хяналтын журмаар хянан хэлэлцэхдээ шийтгэгдсэн этгээдэд оногдуулсан ялыг хөнгөрүүлэх буюу хөнгөн ялтай хуулийг хэрэглэж болох бөгөөд харин ялыг хүндрүүлэх буюу хүнд ялтай хуулийг хэрэглэх эрхгүй.

Анхан шатны болон давж заалдах шатны шүүхээс шүүгдэгчийг цагаатгасан буюу хэргийг хэрэгсэхгүй болгосон явдал нь буруу болсон, түүнчлэн шийтгэгдсэн этгээдэд оногдуулсан ял нь хөнгөн болсон гэж үзвэл хяналтын шатны шүүх энэ хуулийн 364 дүгээр зүйлд дурдсан нөхцөлийг баримтлан таслан шийдвэрлэх тогтоол буюу давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгож, хэргийг шинэчлэн хэлэлцүүдэхээр зохих анхан шатны шүүхэд буцаана. Хяналтын шатны шүүх хэргийг шинээр хэлэлцүүдэхээр анхан шатны шүүхэд буцаахдаа аль шатнаас эхлэн хэлэлцэхийг заана.

Хэрэн давж заалдах журмаар хэрэг хянан хэлэлцэх үед үндэслэлгүйгээр хэргийг хэрэгсэхгүй болгосон буюу шийтгэгдсэн этгээдийн ялыг хууль бусаар хөнгөрүүлсэн бол хяналтын шатны шүүх давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгож анхан шатны шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолыг хэвээр үлдээх, эсхүд шүүгдэгчийн байдлыг дордуулахгүйгээр тогтоолд өөрчлөлт оруулах эрхтэй.

Хэргийг хяналтын журмаар хянасан шүүхээс өгсөн заалтыг нэмж мөрдөн байцаалт явуулах ба хэргийг шүүхээр дахин хэлэлцэхэд заавал биелүүднэ.

Хяналтын журмаар хэрэг хянан хэлэлцэж байгаа шүүх анхан шатны шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолоор тогтоогдоогүй буюу үгүйсгэгдсэн баримтыг тогтоох буюу түүнийг нөгөөгдсөн гэж үзэх, ямар нэг нотлох баримтыг нөгөөгөөс нь нлүүд тооцох, анхан шатны шүүх эрүүгийн хуулийн ямар заалт хэрэглэх, ямар ял оногдуулах тухай асуудлыг урьдчилан шийдвэрлэх эрхгүй.»

154) 372 дугаар зүйл:

«372-р зүйл. Тогтоолын агуулга

Хэргийг хяналтын журмаар хянаж хэлэлцээд гаргасан Дээд шүүхийн тогтоол энэ хуулийн 342 дугаар зүйлийн шаардлагад нийцсэн байвал зохино.

Тогтоолд шүүх хуралдаан даргалагч, илтгэсэн шүүгч гарын үсэг зурна.

155) 376 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэг:

«Шинэ нөхцөл байдал илэрсэн тухай гомдол, хүсэлтийг прокурорт явуулаа.

Хэрэв прокурор шинээр илэрсэн нөхцөл байдлын талаар хэрэг үүсгэх үндэстгүй гэж үзвэл үндэслэл бүхий тогтоол гаргана. Прокурорын тогтоолыг гомдол, хүсэлт гаргасан хүмүүст мэдэгдэх бөгөөд тэд дээд шатны прокурорт гомдлоо гаргаж болно.»

156) 378 дугаар зүйл:

«378-р зүйл, Шинээр илэрсэн нөхцөл байдлаас хэргийг сэргээх тухай асуудлыг шүүх шийдвэрлэх

Шинээр илэрсэн нөхцөл байдлаас хэргийг сэргээх нь:

1) сум болон сум дундын, дүүргийн шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолтой хэргийг аймаг, нийслэлийн шүүх;

2) аймаг, нийслэлийн болон Улсын дээд шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолтой хэргийг Улсын дээд шүүх.

Давж заалдах болон хяналтын шатны журмаар хэргийг урьд нь хянан хэлэлцсэн явдал шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас дурдсан шатны шүүхүүдээс уг хэргийг дахин хянан хэлэлцэхэд сээд болохгүй.

Шинээр илэрсэн нөхцөл байдлын хамаас хэргийг сэргээх явдлыг шүүх хуралдаанаар энэ хуулийн 329, 366 дугаар зүйлд дурдсан журмыг баримтлан гүйцэтгэнэ.»

157) 384 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

«Ниссанд хүрэхгүй этгээдэд энэ хуулийн 87-р зүйлд заасан таслан сэргийлэх арга хэмжээ авахаас гадна түүний энэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хяналтанд шилжүүлдэг болно.»

158) 396 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт:

«1) энэ хуулийн 196 дугаар зүйлд заасан үндэслэл тогтоогдвол хэргийг хэрэгсэхгүй болгох;»

159) 397 дугаар зүйл:

«397-р зүйл, Шүүх хуралдаанд бэлтгэх ажиллагаа

Шүүх хэргийг хүлээж амагц түүнийг хэлэлцэх өдрийг тогтоосон шүүгчийн захирамж гаргаж тэр тухай прокурор, өмгөөлөгч, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хууль ёсны төлөө-

лөгчид мэдэгдэж, гэрч, хохирогч шаардлагатай бол шинжээчийг дуудна.

Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн өвчний шинж байдлыг харгалзан түүнийг шүүх хуралдаанд оролцуулж болно.»

163) 398 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэг:

«Энэ хуулийн 396 дугаар зүйлд заасан журмын дагуу шүүхэд ирсэн хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй шүүх хуралдаанаар энэ хуулийн хорин тав, хорин зургадугаар бүлэгт дурдсан журмыг баримтлан иргэдийн төлөөлөгч, ялагч, өмгөөлөгчийг заавал оролцуулан хэлэлцэнэ.

Шүүх нь шүүхийн байцаалт дуусмагц иргэдийн төлөөлөгч болон ялагчийн дүгнэлт, өмгөөлөгчийн үгийг сонсоно.»

2 дугаар зүйл. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн «БНМАУ» гэснийг «Монгол Улс, «БНМАУ-ын Гадаад явдлын нам» гэснийг «Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага», «урьдчилсан мөрдөн байцаалт» гэснийг «мөрдөн байцаалт», «шүүхийн шинэчлэсэн байцаалт» гэснийг «шүүхийн байцаалт», «шүүх хурал» гэснийг «шүүх хуралдаан», «шүүхийн гишүүн» гэснийг «шүүгч», «улсын ялагч» гэснийг «ялагч», «ялын төлөөлөгчөө» гэснийг «ялах дүгнэлт», «нагдан сэргийлэх» гэснийг «нагдаагийн», «нэргийн ангийн командлал» гэснийг «нэргийн анги, нэгтгэл, байгууллагын удирдлага», мөн хуулийн 24-р зүйлийн «ардын төлөөлөгч» гэснийг «иргэдийн төлөөлөгч», 87-р зүйлийн 1 дэх хэсгийн «хүмүүс буюу олон нийтийн байгууллагын» гэснийг «хүмүүсийн», мөн зүйлийн 2 дахь хэсэг болон 28, 30, 52 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 82, 87, 90, 96-р зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, 97-р зүйлийн 4 дэх хэсэг, 99-р зүйлийн 1 дэх хэсэг, 105 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 109-р зүйлийн 1, 3 дахь хэсэг, 253, 270, 271, 274, 278, 279-р зүйлийн 2 дахь хэсэг, 284-р зүйлийн 1 дэх хэсэг, 285-р зүйлийн 2 дахь хэсэг, 297-р зүйлийн 2 дахь хэсэг, 300, 364, 389, 391, 392-р зүйлийн «магадлал» гэснийг «тогтоол, захирамж», 399-р зүйлийн 1 дэх хэсэг, 400, 401, 402-р зүйлийн 3 дахь хэсэг, 403-р зүйлийн 1 дэх хэсгийн «магадлал» гэснийг «тогтоол» гэх, 111-р зүйлийн 3 дахь хэсгийн «Сайд нарын Зөвлөл» гэснийг «Улсын Их Хурал», 127-р зүйлийн «хэлтсийн» гэснийг «албаны», 129-р зүйлийн 1, 2 дахь хэсгийн «прокурор» гэснийг «мөрдөн байцаах албаны дарга», 147, 155-р зүйлийн «сум хороодын АДХ-ын гүйцэтгэх захиргаа, орон сууцны төлөөлөгч, орон

сууц—гудамжны хорооны дарга, ажлын газрын захиргаа» гэснийг «баг, хороо, сум, дүүргийн Засаг дарга, байгууллагын захиргаа», 53 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 109 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, 172-р зүйлийн 1 дэх хэсэг, 348-р зүйлийн «магадлал» гэснийг «тогтоол», «тогтоол» гэснийг «захирамж», 199-р зүйлийн 3 дахь хэсгийн «6-р зүйлийн 3 буюу 4-ийг» гэснийг «6-р бүлгийн 2 буюу 3-ыг» гэх, 340-р зүйлийн «6—10» гэснийг «6», 234-р зүйлийн 2 дахь хэсгийн «шүүхийн магадлал буюу шүүгчийн тогтоолын» гэснийг «шүүгчийн захирамжийн», 268-р зүйлийн «БНМАУ-ын эрүүгийн хуулийн 76-р зүйл, 77-р зүйлийн «а», 92-р зүйлийн «а», 93-р зүйл» гэснийг «Монгол Улсын Эрүүгийн хуулийн 98 дугаар зүйлийн нэг дэх хэсэг, 99 дүгээр зүйлийн нэг дэх хэсэг, 117 дугаар зүйлийн нэг дэх хэсэг, 118 дугаар зүйл», 278-р зүйлийн 2 дахь хэсгийн «шүүхийн магадлалаар» гэснийг «түүнийг», 308-р зүйлийн 2 дахь хэсгийн «этгээд» гэснийг «гэмт хэрэгтэн», 324, 343-р зүйлийн 1 дэх хэсгийн «хоёрдугаар» гэснийг «лавж заалдах», 350-р зүйлийн 1 дэх хэсгийн «шүүхийн дарга» гэснийг «Ерөнхий шүүгч», 3 дахь хэсэг, мөн 348-р зүйлийн «магадлал ба тогтоолыг» гэснийг «тогтоол ба шүүгчийн захирамжийг», 353-р зүйлийн 1 дэх хэсгийн «засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн» гэснийг «хорих ял эдлүүлэх», мөн зүйлийн 1, 2, 5, 6 дахь хэсэг болон 97, 358-р зүйлийн «магадлал», гэснийг «захирамж», 359-р зүйлийн 2 дахь хэсгийн «магадлалын» гэснийг «захирамжийн», 3 дахь хэсгийн «засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колонд» гэснийг «зохих дэглэмийн хорих ангид», «орон нутгийн шүүх магадлал» гэснийг «газрын шүүхийн шүүгч захирамж», 371-р зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалтын «хэргийг мөрдөн байцаасан этгээд» гэснийг «хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч», 391¹-р зүйлийг «Ардын депутатын хурлын гүйцэтгэх захиргааны дэргэдэх насанд хүрэнгүй хүмүүсийн хэрэг эрхлэх комисс, цагдан сэргийлэх» гэснийг «шүүхийн болон цагдаагийн», 402-р зүйлийн 1, 2 дахь хэсгийн «шүүх» гэснийг «шүүгч», 403-р зүйлийн «шүүх» гэснийг «шүүгч», «магадлал» гэснийг «захирамж» гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 105-р зүйлийн 1 дэх хэсгийн «шүүх бүрэлдэхүүн», 262-р зүйлийн «прокурор», 266-р зүйлийн «зарлаж», 287-р зүйлийн «бүрэлдэхүүнээрээ», 288-р зүйлийн 1 дэх хэсгийн «дараа», 306-р зүйлийн 3 дахь хэсгийн «бүрэлдэхүүн» гэсний дараа «иргэдийн

төлөөлөгч», 144-р зүйлийн «мөрдөн байцаагч», эсний дараа «прокурор», 334-р зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалтын «тадаар» гэсний дараа «захирамж, тогтоол» гэж тус тус нэмсүгэй;

4 дүгээр зүйл, 47-р зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтаас «буюу олон нийтийн», 87-р зүйлийн 2 дахь хэсэг, 34¹-р зүйлээс «АДХГЗ», 101-р зүйлээс «захиран тушаах», 116-р зүйлийн 1 дэх хэсгээс «шүүгч», 2 дахь хэсгээс «буюу шүүхийн», 117-р зүйлийн 1, 2 дахь хэсгээс «шүүгч», 119-р зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтаас «эхүл шүүхэд шууд» гэсэн болон мөн зүйлийн 3 дахь заалт, 204-р зүйлийн 3 дахь хэсгээс «мөрдөн байцаагчийн зөвшөөрөлтэйгээр», 262-р зүйлээс «олон нийтийн иллагч, олон нийтийн өмгөөлөгч», 266-р зүйлийн 1 дэх хэсгийн сүүлчийн 2 өгүүдбэр, 311-р зүйлийн 1 дэх хэсгээс «ардын төлөөлөгч», 373-р зүйлийн 2 дахь хэсгээс «буюу хоёрдугаар», 377-р зүйлийн 1 дэх хэсгээс «дээд шатны прокуророос дамжуулан», 384-р зүйлээс «хаалттай» гэснийг тус тус хассугай.

5 дугаар зүйл, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 2-р зүйлийн 2 дахь хэсэг, 7-р зүйл (нөхцөл байдал өөрчлөгдөөний улмаас эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох)

8-р зүйл (эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгож, олон нийтийн шүүхэд шилжүүлэх) 8¹-р зүйл (захиргааны харуулага хүлээлгэхээр эрүүгийн хэргийн хэргийг хэрэгсэхгүй болгох), 9-р зүйл (эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгож гэмт этгээдийг даалтанд өгөх), 10-р зүйл (эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгож, насанд хүрээгүй хүмүүсийн хэрэг эрхлэх комисст шилжүүлэх), 11-р зүйл (эрүүгийн хэрэг үүсгэхгүйгээр олон нийтийн арга хэмжээ авахуулахаар материалыг шилжүүлэх), 27-р зүйл (эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд тавих прокурорын хяналт), 31-р зүйлийн 3 дахь хэсэг, 36-р зүйл (БНМАУ-ын Дээд шүүхээс харьяалан таслах хэргүүд) 37-р зүйл (нэргийн шүүхээс харьяалан таслах хэргүүд) 38-р зүйл (дээд шатны шүүх нь доод шатны шүүхийн харьяаллын хэргүүдийг өөртөө авч хэлэлцэх эрхтэй), 40-р зүйлийн 2 дахь хэсэг, 47-р зүйлийн 2 дахь хэсэг, 48-р зүйл (Өмгөөлөгчийг таталзах), 93-р зүйл (олон нийтийн байгууллагын батлан даалт), 104-р зүйл (захиран тушаах хурлын протокол), 123-р зүйлийн 3 дахь хэсэг, 153-р зүйл (яллагдагчийг албан тушаалаас зайлуулах), 204-р зүйлийн 4 дэх хэсэг, 207-р зүйл (ялын төлөлдөгөөнд хавсаргах зүйлүүд), 220-р зүйл (хэргийг шүүхийн захиран тушаах хуралд хэлэлцүүлэхээр оруулах), 224-р зүйл

(шүүхийн захиран тушаалх хурлын бүрэлдэхүүн, прокурор оролцох), 225-р зүйл (шүүхийн захиран тушаалх хурлын жур-
рам), 226-р зүйл (шүүх-эс захиран тушаалх хурлаар гаргах
магадлаалууд), 227-р зүйл (яллагдагчийг захиран тушаалх хур-
лаар шүүхэд шилжүүлэх), 228-р зүйл (хэргийг шүүх хурлаар
хэлэлтэх явдалтай холбогдсон асуудлыг шийдвэрлэх), 232-р
зүйл (хэргийг хэрэгтээхгүй болгох), 240-р зүйл (бэлтгэлээр
оролцох ардын төлөөлөгч), 246-р зүйл (шүүх хурлын явдалла-
гдалд олон нийтийн ялагч, өмгөөлөгчийг оролцуулах), 251-р
зүйл (шинэ хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэх), 252-р зүйл (шинэ
эгтээдийн хувьд эрүүгийн хэрэг үүсгэх), 308-р зүйлийн 5 дахь
хэсэг, 310-р зүйлийн 3 дахь хэсэг, 314-р зүйл (томилотлоор
оролцсон мэргэжлийн өмгөөлөгчийн хэлс), 320-р зүйл (таслаа
шийдвэрлэх тогтоолд томлол гаргах ба эсэргүүцэл бичих
хугацаа), 321-р зүйл (томлол гаргах ба эсэргүүцэл бичих ху-
гцааг сэргээх), 347-р зүйлийн 2 дахь хэсэг, 350-р зүйлийн
4, 5, 6, 7 дахь хэсэг, 350¹-р зүйл (хөдөлмөрт эзэвэл тэтгэн
оруулахаар хорих ял нь тэнсэгдсэн болон хөдөлмөрт эзэвэл
тэтгэн оруулахаар хорих газраас тэнсэн суллагдсан этгээдийг
таслаа шийдвэрлэх тогтоол ёсоор хорих газарт явуулах),
353¹-р зүйл (хөдөлмөрт эзэвэл тэтгэн оруулахаар хорих ял нь
тэнсэгдсэн болон хөдөлмөрт эзэвэл тэтгэн оруулахаар тэнсэн
суллагдсан этгээдийг тазар дутуугийн учир ял эдлэхээс ил-
дөвлөх), 360-р зүйлийн 5 дахь хэсэг, 365-р зүйл (хяналтын
журмаар эсэргүүцэл бичигдсэн хэргийг ямар шүүх хэлэлтэх),
390-р зүйл (шүүх хуралад сүнсэн хүмүүжүүлэх ба олон ний-
тийн байгууллагын төлөөлөгчийг оролцуулах), 392-р зүйлийн
3 дахь хэсэг, 395-р зүйлийн 2 дахь хэсэг, 396-р зүйлийн 3 дахь
хэсэг, VIII хэсэг буюу гучин зургадугаар бүлэг (танхайрсан
хэргийн тэдгээр гүйцэтгэх ажвлагаа)-ийг тус тус хүчингүй
болсонд тооцсугай.

6 дугаар зүйл. Энэ хуулийг 1994 оны 7 дугаар сарын 1-ийн
өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

7 дугаар зүйл. Энэ хуулийг буцаан хэрэгтээхгүй.

МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ

1994 оны 4 дүгээр
сарын 8-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТЫГ
ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАР

1 дүгээр зүйл. Эрүүгийн хуулийн 46 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн «... ил оногдуулахгүйгээр даалтад өгч, ...» гэснийг болон мөн хуулийн 49 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцгооно.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 1994 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Энэ хуулийг буцаан хэрэглэхгүй.

Монгол Улсын Их Хурал
арга.

Н. БАГАБАЦЛИ.

МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ

1994 оны 4 дүгээр
сарын 8-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮГИЙН ХУУЛЬД ЗАРИМ НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл, Эрүүгийн хуулийн 268 дугаар зүйлийн 3 дэх хэсгийн «долоогоос арван таван жил» гэснийг «арван таваас хорин таван жил», 282 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн «хоёр жил хүртэл хугацаагаар ял шийтгэнэ.» гэснийг «нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.» гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл, Энэ хуулийг 1994 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл, Энэ хуулийг буцаан хэрэглэхгүй.

Монгол Улсын Их Хурлын
дэргэ

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

1994 оны 3 дугаар

сарын 18-ны өдөр

Дугаар 22

Улаанбаатар

хот

СТАТИСТИКИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Статистикийн тухай хууль батлагдсантай холбогдуудан дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасугай:

1) Засгийн газрын болон яам, тусгай газрын шийдвэрийг Статистикийн тухай хуульд нийцүүлэх;

2) Статистикийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан тооллого, судалгааг эхлэн явуулах хугацааны талаар судалгаа энэ оны 10 дугаар сард багтаан Улсын Их Хуралд танилцуулах.

3) төрийн байгууллагуудын хооронд тоон мэдээллийн сүлжээ байгуулах ажлыг энэ оны 4 дүгээр улиралд багтаан хийх;

4) олон улсын статистикийн нийтлэг үзүүлэлт, аргачлалд шинэжих хөтөлбөрийг 1995 оны 4 дүгээр улиралд багтаан батлах.

Дарга

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛЫН
ТОГТООЛ

1994 оны 3 дугаар

сарны 21-ний өдөр

Дугаар 23

Улаанбаатар

хот

ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАН БОЛОВСРУУЛАХ,
ЧУУЛГАНААР ХЭЛЭЛЦЭХ ТУХАЙ

1. Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн хуульд өөрчлөлт оруулан боловсруулж Улсын Их Хурлын 1994 оны намрын чуулганаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсүгэй.

2. Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн хуульд өөрчлөлт оруулан боловсруулах Улсын Их Хурлын ажлын хэсгийг албан ёсны бүртгэлтэй улс төрийн намуудын төлөөлөгчдийг оролцуулан байгуулах тухай санал бэлтгэж энэ оны 4 дүгээр сард багтаан Улсын Их Хурлын чуулганд оруулж шийдвэрлүүлэхийг Хурал, захиргааны байнгын хороонд даалгасугай.

3. Улсын Их Хурал дахь ивөнхийг зохион байгуулах болон түүний эрх, үүргийн талаар Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуудсийг төслийг боловсруулж энэ оны хаврын чуулганаар хэлэлцүүлэхийг Хурал, захиргааны байнгын хороонд даалгасугай.

Дарга

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛЫН
ТОГТООЛ

1974 оны 3 дугаар
сарын 29-ний өдөр

Дугаар 24

Улаанбаатар
хот

ЭНЭ АЙЛЧЛАЛЫН ДУНГИЙН ТУХАЙ

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц. Очирбат Бүгд Найрамдах Энэтхэг Улс, Тайландын Вант Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улс, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсад албан ёсны айлчлал хийсэн туулай мэдээллийг сонсоод Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Бүгд Найрамдах Энэтхэг Улс, Тайландын Вант Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улс, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсад Монгол Улсын Ерөнхийлөгч Ц. Очирбатын хийсэн албан ёсны айлчлалын дүнг сайшаасугай.

2. Энэ айлчлалын үеэр хэлэлцэж тохирсон асуудлуудыг шийдвэрлэх талаар хэлбөгдөх арга хэмжээ дич хэрэгжүүлэхийг Засгийн газарт үүрэг болгосугай.

Дарга

Н. БАГДАНДИ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

1994 оны 3 дугаар
сарын 29-ний өдөр

Дугаар 25

Улаанбаатар
хот

ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Хуулийг тайлбарлан сурталчлах ажлыг зохион байгуулахыг Засгийн газар, Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын Ерөнхий прокурорт даалгасугай.

2. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг 1968 оны 1 дүгээр сарын 25-ны өдрөөс хойшхи нэмэлт, өөрчлөлтийг тусган одоогийн мөрдөж байгаа хууль боловсруулах техник, нэр томьёонд нийцүүлэн нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хүчин төгөлдөр болохоос өмнө бүрэн эхээр нь хэвлүүлэхийг Засгийн газарт даалгасугай.

3. Иргэдийн төлөөлөгчдийг сонгох ажлыг 1994 оны 7 дугаар сарын 1-ний дотор зохион байгуулахыг Шүүхийн ерөнхий зөвлөл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд даалгасугай.

Дарга

Н. БАГАБАНДИ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЫН
ТОГТООЛ**

1994 оны 4 дүгээр

Улаанбаатар

сарын 20-ны өдөр

Дугаар 27

хот

**ЗӨВЛӨМЖ, МЭДЭЭЛЭЛТЭЙ ХОЛБОГДУУЛАН
АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ**

Улс орны улс төрийн өнөөгийн байдлын тухай Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл зөв хэлэлцээд гаргасан зөвлөмж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн хэлсэн үг болон Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээллийг сонсоод Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 1994 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн 02 дугаар зөвлөмжийг сайшаасугай.

2. Улс орны нийгэм, эдийн засгийн өнөөгийн байдлын талаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн хэлсэн үгэнд дурдсан асуудлыг судлан үзэж шаардлагатай гэж үзсэн санал, дүгнэлтээ Улсын Их Хурлын 1994 оны хаврын чуулганд хэлэлцүүлэхээр оруулахыг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодод даалгасугай.

3. Өнөөгийн үүсэн бий болсон бодит нөхцөл байдалд улс орныхоо язгуур эрх ашиг, аюулгүй байдлын үүднээс ухаалаг хандаж, улс төрийн өлсгөлөнгөө зогсоохыг түүнд оролцогчдод уриалсугай.

4. Энэ тогтоолыг 1994 оны 4 дүгээр сарын 21-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Дарга

Н. БАГАБАНДИ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЫЛЫН
ТОГТООЛ**

1994 оны 4 дүгээр
сарын 21-ний өдөр

Дугаар 28

Улаанбаатар
хот

**УЛС ТӨРИЙН ЗӨВШИЛЦЛИЙН ДАГУУ АВАХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ**

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 1994 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн 02 дугаар зөвлөмж, МАН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга, МҮАН-ын Тэргүүн, МСДН-ын дарга нарын 1994 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн улс төрийн зөвшилцлийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

1. Дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасгай:

1) Жагсаал, нуглаан хийх журмын тухай хууль, Коррупцийн эсрэг хуулийн төслүүдийг боловсруулан Улсын Их Хурлын 1994 оны хаврын чуулганаар хэлэлцүүлэхээр өргөн барих;

2) Улс орны нийгэм, эдийн засгийн байдалтай холбогдсон асуудлаар Улсын Их Хурлын 1994 оны хаврын чуулганд илтгэл оруулан хэлэлцүүлэх;

3) Улс төрийн дээд албан тушаалтнуудын ёс зүйн хэм хэмжээний тухай хууль, Ард нийтийн санаа асуулгын тухай хуулийн төслүүдийг боловсруулан 1994 онд багтаан Улсын Их Хуралд өргөн барих.

2. Энэ тогтоолын 1-ийн 2 дахь заалтад заасан илтгэлийн хэлэлцүүлгийг улс даяар радио, телевизээр иэвтрүүлэх нь зүйтэй гэж үзсүгэй.

3. Улсын Их Хурлын 1994 оны хаврын чуулганаар Жагсаал, нуглаан хийх журмын тухай хууль, Коррупцийн эсрэг хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчөөс саналчлал өргөн барих Хэвлэл, мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг хэлэлцэхээр тогтоосугай.

4. Энэ тогтоолыг 1994 оны 4 дүгээр сарын 21-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИВЛӨГЧИЙН
ЗАРИГ**

1994 оны 3 дугаар

Дугаар 38

Улаанбаатар

сарын 21-ний өдөр

ХОТ

**ЗАРИМ ШҮҮГЧИЙГ АЛБАН ТУШААЛААС
ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ**

Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн саналыг үндэслэн Цамбын Даш, Агвааны Дулмаа нарыг Завхан аймгийн хэсгийн ардын шүүхийн шүүгчийн албан тушаалаас 1993 оны 7 дугаар сарын 25-наар тасалбар болгон тус тус чөлөөлсүгэй.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИВЛӨГЧИЙН
ЗАРИГ**

1994 оны 4 дугаар

Дугаар 46

Улаанбаатар

сарын 12-ны өдөр

ХОТ

**Г. ЛУВСАНДОРЖИЙГ ТӨРИЙН СОЁРХОЛ
ХҮРТЭЭХ ЗӨВЛӨЛИЙН ОРЛОГЧ ДАРГА, ТУС
ЗӨВЛӨЛИЙН САЛБАРЫН ДАРГААР БАТЛАХ
ТУХАЙ**

Монгол Улсын Төрийн соёрхол хүртээх зөвлөлийн гишүүн, төрийн соёрхолт, архитекторч Г. Лувсандоржийг тус зөвлөлийн орлогч дарга, соёл урлаг, утга зохиол, уран барилгын салбарын даргаар баталсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1994 оны 4 дүгээр

сарны 12-ны өдөр

Дугаар 47

Улаанбаатар

хот

**Ш. СҮРЭНЖАВЫГ ТӨРИЙН СОЁРХОЛ ХҮРТЭЭХ
ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНЭЭР БАТЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын төрийн соёрхолт, яруу найрагч Ш. Сүрэнжавыг Төрийн соёрхолт хүртээх зөвлөлийн гишүүнээр баталсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1994 оны 4 дүгээр

сарны 15-ны өдөр

Дугаар 49

Улаанбаатар

хот

**ЛУВСАНДОРЖИЙН МУНДАГБААТАРЫГ ЭЛЧИН
САЙДЫН ҮҮРЭГТ АЖЛААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ**

Лувсандоржийн Мундагбаатарыг Монгол Улсаас Бүгд Найрамдах Португал Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ

1994 оны 4 дүгээр

сарын 15-ны өдөр

Дугаар 50

Улаанбаатар

хот

ХАСБАЗАРЫН БЭХБАТЫГ ЭЛЧИН
САЙДААР ТОМИЛОХ ТУХАЛ

Хасбазарын Бэхбатыг Монгол Улсаас Бүгд Найрамдах
Португал Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар
томилсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ

1994 оны 2 дугаар

Дугаар 46

Улсын Засгийн

сэргэн 25-ийн өдөр

хот

ХУУЛЬ ЗҮЙН МЭРГЭЖЛИЙН БОЛОВСОН ХҮЧИН
БЭЛТГЭХ, ДАВТАН СУРГАХ, ХУУЛЬ ЗҮЙН
ШИНЖЛЭХ УХААНЫГ ХӨГЖҮҮЛЭХ ЗАРИМ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Хууль зүйн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, дэвтэн сургах тогтолцоог боловсронгуй болгох, хууль зүйн сургалт, эрдэм шинжилгээний дадлын үндэс хэлбэрт сайжруулах шаардлагыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсад хууль зүйн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, дэвтэн сургах, хууль зүйн шинжлэх ухааныг хөгжүүлэх талаар Засгийн газраас Сэримтлах үндсэн чиглэлийг хангалтын ёсоор баталж, түүнийг хэрэгжүүлэх үндэслэл, зохион байгуулалтын арга хэмжээ ажлыг Шинжлэх ухаан, боловсролын нам (Н. ӨЛЗИПХУТАГ)-д даалгасгай.

2. Хууль зүйн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, дэвтэн сургах зохилдлыг жил бүрээр гаргаж, энэ ажлыг үндэслэл зохицуулах үүргийг Хууль зүйн нам (Н. ЛУВСАНЖАВ)-д хариуцуулсгай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Н. ЖАСРАН

Хууль зүйн сайд

Н. ЛУВСАНЖАВ

Шинжлэх ухаан, боловсролын сайд

Н. ӨЛЗИПХУТАГ

МОНГОЛ УЛСАД ХУУЛЬ ЗҮЙН МЭРГЭЖЛИЙН БОЛОВСОН ХҮЧНИЙ БЭЛТГЭХ, ДАВТАН СУРГАХ, ХУУЛЬ ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААНЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТАЛААР ЗАСГИЙН ГАЗРААС БАРИМЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Монгол оронд эрх зүйг төр байгуулах, эрх зүйн тогтолцоог бүрэлдүүлэн төлөвшүүлэх зорилт, хууль зүйн мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх, хууль зүйн шинжлэх ухааныг хөгжүүлэх өнөөгийн дэрэгцээ, шаардлагыг харгалзан:

— тус улсад шинжлэх ухаан, боловсролын салбарыг хөгжүүлэх талаар «Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр»-г дэвшүүлсэн үзэл баримтлал, «Монгол Улсад нийгмийн дэг журам хангах талаар төрөөс явуулах үйл ажиллагааны үндсэн чиглэл»-ийг хэрэгжүүлэх зорилгод нийцүүлэн;

— тус улсын хууль зүйн шинжлэх ухааны хөгжлийн өнөөгийн хүрсэн түвшин, хуульч мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх талаар хуримтлуулсан туршлага, материаллаг бааз, сургууль, багш, эрдэмтдийн орных чадварх, төрийн байгууллагуудын идэвхтэй дэмжлэгт тулгуурлан;

— ойрын жилүүдэд хууль зүйн сургалт, эрдэм шинжилгээний байгууллагын тогтолцоог өөрчлөн шинэчилж, дэлхийн жишгийн хуульч мэргэжилтэн бэлтгэх түвшинд хүрэх чигээд баримтгаж байна.

Монгол Улсад хууль зүйн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх тогтолцоонд хийх өөрчлөлтийн хүрээнд хууль зүйн сургалт, эрдэм шинжилгээний байгууллагын өндөр хөгжилтэй орнуудын хуульчид бэлтгэх жишгт хүргэн тэргүүлэх эрдэмтэн, багш нартай сургалт, эрдэм шинжилгээний орчин үеийн тоног төлөөрөмж, лабораторитой сургалт, шинжлэх ухааны төв болгох, түүнчлэн хууль зүйн гүнзгий суурь боловсролтой, мэргэшлийн ажлыг өндөр түвшинд гүйцэтгэх чадвартай тэргүүлэх ажилтан, судлаачдыг бий болгож эхлэх зорилт тавьж дараахь арга хэмжээг дэс дараатай авч хэрэгжүүлнэ:

1. Хууль зүйн сургалтын чанар, агуулгыг өнөөгийн шаардлага, зорилтод нийцүүлэн өөрчлөх, үүнтэй холбогдуулан сургалтын төдөвлөгөөг уян хатан, чөлөөт хувилбартай хийх за-

маар оюутныг хууль зүйн суурь боловсрол дээр нь тулгуурлан тодорхой чиглэлүүдээр давтан мэргэшэх бололцоог бүрдүүлнэ.

2. Хууль зүйн шинжлэх ухааны чиглэлээр одоо ажиллаж байгаа сургалт, эрдэм шинжилгээний байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг хянан үзэж, хууль зүйн сургалт, эрдэм шинжилгээний ажлын уялдаа холбоог сайжруулах чиглэлээр өөрчлөлт хийнэ.

3. Монгол Улсын үндэсний их сургууль, Шинжлэх ухааны академийн Хууль зүйн сургалт, эрдэм шинжилгээний хүрээлэн, Хууль зүйн яамны Хууль судлалын төвийг нэгтгэн Монгол Улсын үндэсний их сургуулийн бүрэлдэхүүнд ажиллах Хууль зүйн дээд сургууль болгон өөрчилж санхүү, зохион байгуулалтын хувьд бэхжүүлэх арга хэмжээ авна. Хууль зүйн дээд сургууль нь:

— сургалтын шинэ тогтолцоогоор төрийн дээд, төв, орон нутгийн төрийн хийгээд төрийн захиргааны байгууллагсад ажиллах дээд боловсролтой, мэргэшсэн хуульчид, эрдэм шинжилгээний ажилтан бэлтгэх, хуульчдын мэргэжил дээшлүүлэх;

— Монгол Улсын үндэсний их сургуулийн эдийн засгийн хүрээлэн, Олон улсын харилцааны дээд сургуультай хамтарч «хуульч, эдийн засагч», «олон улсын хуульч» хос мэргэжлээр боловсон хүчин бэлтгэх арга хэмжээ авах;

— өөр мэргэжлийн чиглэлээр дээд болон тусгай дунд боловсрол эзэмшсэн хүмүүсийг сургаж хууль зүйн дээд боловсрол олгох;

— хууль зүйн шинжлэх ухааны суурь болон хансарга судалгаа явуулах эрх зүйн онолын тодорхой асуудлаар үзэл баримтлал, тосол боловсруулах, судалгаа явуулах, туршилта хийх, экспертиз, арга зүйн шинжилгээ хийх дэрэг чиг үүрэгтэй хууль зүйн сургалт-судалгааны үндсэн төв болох чиглэл баримтална;

— хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, хорих байгууллагын тогтолцоо, үйл ажиллагааны онцлог, мэргэжлийн боловсрол хүчээр хангах өнөөгийн бодит шаардлагыг харгалзан Цэгдээгийн дээд сургуулийг санхүү, зохион байгуулалтын талаар бэхжүүлэх арга хэмжээ авна.

4. Хуульчдын мэргэжил дээшлүүлэх сургалтыг дараахь хэлбэрээр зохион байгуулна:

а) өндөр зэрэглэлтэй багш, эрдэм шинжилгээний ажилтан, тэргүүлэх мэргэжилтэн бэлтгэх зорилгоор багш, эрдэм шинжилгээний ажилтан, хуулийн байгууллагын ажилтныг дотооддоо болон бусад оронд мэргэжил дээшлүүлэх талаар дэс дараатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ;

б) дээд боловсролтой хуульчдыг магистрантурт сургах бололцоог өргөжүүлнэ.

5. Их, дээд сургуулийн мэргэжлийн багш, эрдэм шинжилгээний ажилтны нөөцтэй болохын тулд дотоодод хуулийн чиглэлээр сурч байгаа гадаад хэлний зохих мэдлэгтэй, эрдэм шинжилгээний ажил хийх чадвартай оюутнуудаас шилж сонгох замаар тодорхой чиглэлээр гадаад, дотоодод бэлтгэх арга хэмжээ авна.

6. Хууль зүйн мэргэжлийн багш, эрдэм шинжилгээний ажилтныг шилж сонгох, тэдний мэргэжлийн түвшинг тогтоох зэрэгцээ, шилжлэлийн тусгай шалгуур бий болгож, түүний дагуу багш нарыг шалгаруулан ажиллуулах чиглэл баримтална.

Дээрх чиглэлийн дагуу өндөр зэрэглэлтэй багш, эрдэм шинжилгээний ажилтнуудыг бэлтгэхийн тулд тэдгээрийн мэргэжлийг дээшлүүлэх, давтан сургах, бусад оронд тодорхой хугацаагаар мэргэжил дээшлүүлэх, цаашилбал магистр, дэд докторын зэрэг хамгаалуулах арга хэмжээг олон улсын төслийн хүрээнд авч хэрэгжүүлнэ.

7. Хууль зүйн боловсролын тогтолцооны өөрчлөлттэй холбогдтуулан дээд боловсрол олгодог сургуулийн багш, мэргэжлийн байгууллагуудын тодорхой албан тушаалд ажиллах хүмүүс нь магистраас дээд зэрэгтэй байх бодлого баримталж хэрэгжүүлнэ.

8. Хууль зүйн шинжлэх ухааны байгууллагуудын эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үндсэн чиглэл, хамтарсан буюу дагнасан үйл ажиллагааны хэлбэрийг тодорхойлно.

9. Хууль зүйн сургалт, эрдэм шинжилгээний байгууллагуудад материаллаг бааз, багш, эрдэм шинжилгээний ажилтан, оюутны гарын авлага, шаардлагатай ном, сурах бичиг, хууль тогтоомжийн мэдээлэл, техник хэрэгсэл дутагдалтай байгааг харгалзан, сургалт-эрдэм шинжилгээний материаллаг баазыг шинээр бий болгож, бие далсан мэдээллийн төвийг байгуулж ажиллуулахад дотоодын болон гадаадын эх үүсвэр, бусад боломжийг ашиглана.

10. Хувийн хэвшлийн үндсэн дээр хууль зүйн сургууль байгуулж ажиллуулах санаачилгыг дэмжинэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ

1994 оны 3 дугаар
сарны 2-ын өдөр

Дугаар 49

Улаанбаатар
хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

«Гадаадын иргэдийн эрх зүйн байдлын тухай» болон «Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цаглачлах тухай» хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Ажиллах хүч гадаад оронд гаргах, гадаад орноос авах журмыг хавсралтын ёсоор баталсугай.

2. Ажиллах хүч гадаад оронд гаргах, гадаад орноос авах гэрээ, хэлэлцээр байгуулахад баримтлах ерөнхий нөхцөлийг энэ 3 дугаар сард багтаан баталж гаргахыг Хүн амын бодлого, зохицуулалтын сайд Э. Гомбожавг даалгасугай.

3. Ажиллах хүч гадаад оронд гаргах, гадаад орноос авах гэрээ, хэлэлцээр байгуулахдаа энэ журам болон ерөнхий нөхцөлийг удирдлага бэлтгэн ажиллахыг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагад даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

П. ЖАСРАЙ

Хүн амын бодлого,
зохицуулалтын сайд

Э. ГОМБОЖАВ

АЖИЛАХ ХҮЧ ГАДААД ОРОНД ГАРГАХ, ГАДААД ОРНООС АВАХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1. Төсөвт байгууллага, аж ахуйн нэгж (цаашид байгууллага гэнэ) хөдөлмөрийн гэрээгээр ажиллах хүч гадаад оронд гаргах, гадаад орноос авч ажиллуулах гэрээ, хэлэлцээр байгуулахдаа энэхүү журмыг баримтална.

2. Ажиллах хүч гадаад оронд гаргах, гадаад орноос авал тухай өйцөхтөд Монгол Улсын иргэн гадаад оронд аж ажиллах, Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаагаа явуулж байгаа гадаадын байгууллагад болон гадаад орноос Монгол Улсад гадаадын иргэн хөдөлмөрийн гэрээ, хэлэлцээрээр ирж ажиллахыг хэлнэ.

3. Байгууллага нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллах хүч гадаад оронд гаргах, гадаад орноос авахдаа хүн амын хөдөлгөөн эрхлэлт, хөрөнгө оруулалтын бүтцийн бодлого зэрэгтэй уялдуулан зохион байгуулна.

4. Ажиллах хүчийг гадаад оронд гаргах, гадаад орноос авал тухай гэрээ, хэлэлцээр байгуулахад баримтлах ерөнхий нөхцөлийг Хүн амын бодлого, хөдөлмөрийн нэм хэлбэлдэх бусад яам, газартай хамтран тогтооно.

Хоёр. Ажиллах хүч гадаад оронд гаргах

1. Байгууллага нь хоёр улсын Засгийн газар хооронд байгуулсан хэлэлцээрийг үндэслэн энэхүү журмын дагуу гадаадын үйлдвэр, аж ахуйн газарт төлөрхөй хугацаагаар ажиллах хүч гаргах, өөрийн ажилчдыг дадлага хийлгэх талаар гэрээ, хэлэлцээр байгуулж болох бөгөөд гэрээ, хэлэлцээрийн хугацаа 3 жилээс илүүгүй байна.

2. Гэрээ, хэлэлцээрийн ерөнхий нөхцөлийн дагуу хэлэлцэн зохиогч хоёр улсын үндэсний хэлээр байгуулах бөгөөд тэдгээр нь Монгол Улсын Хөдөлмөрийн болон бусад хууль тогтоомжтой нийцсэн байвал зохино.

3. Байгууллага нь ажиллах хүч гаргах талаар гадаадын үйлдвэр, аж ахуйн газартай хийх гэрээ, хэлэлцээрийн төслийг тухайн салбарыг харьцахад удирдах дээд байгууллагын

санааны хамт Хүн амын бодлого, хөдөлмөрийн яаманд ирүүлж зөвшөөрөл авна.

4. Гэрээ, хэлэлцээрийн төсөлд зөвшөөрөл авсны дараа ажиллах хүч авч ажиллуулах гадаад орны байгууллагуудтай гэрээ байгуулна.

5. Ажиллах хүч авч ажиллуулах гэрээ байгуулсны дараа гэрээгээр гарч ажиллах хүч нэг бүрт дараахь материалыг бүрдүүлж, гадаад оронд хөдөлмөрийн гэрээгээр ажиллах хүмүүсийн жагсаалт, дор дурдсан бичиг баримтыг бүрдүүлэн Хүн амын бодлого, хөдөлмөрийн яаманд ирүүлж эцсийн шийдвэр гаргуулна. Үүнд:

а) өргөдөл, гэр бүл, асран хамгаалуулагч, нутаг дэвсгэрийн сум, хорооны зөвшөөрөл;

б) иргэний паспорт;

в) хөдөлмөрийн дэвтэр;

г) эрүүл мэндийн магадлагаа.

6. Гадаад оронд ажиллах хүмүүсийг гэр бүлээр нь авахаар хөдөлмөрийн гэрээнд тусгагдсан бол дагалдах ам бүлийн хүмүүст аймаг, нийслэлийн Засаг дарга, хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны даргын захирамжийг үндэслэн гадаад паспорт олгоно.

Энэхүү захирамжийг гаргахдаа гэр бүл нь эсвэл асран дэмжигч нь хөдөлмөрийн гэрээгээр гадаад оронд явж ажиллах болсон тухай Хүн амын бодлого, хөдөлмөрийн яаманд шийдвэр, нэг ам бүлд багтаж амьдардагийг нотолсон тухайн сум, дүүргийн Засаг дарга, хорооны Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны даргын тодорхойлолт, гэр бүлийн баталгаа, цагдаагийн байгууллагын зөвшөөрөл, эрүүл мэндийн магадлагаа зэргийг үндэслэнэ.

7. Хувь хүн гадаад орны үйлдвэр, аж ахуйн газар, нүүс, компанитай гэрээ, хэлцэл байгуулаад тодорхой хугаанаагаар ажиллахаар явж болно.

8. Гадаад орны үйлдвэр, аж ахуйн газар, нүүс, компанитай гэрээ, хэлцэл байгуулсан хувь хүнд энэ журмын 2, 3, 4, 5-д заасан бичиг баримт, зөвшөөрлийг бүрдүүлсний үндсэн дээр Хүн амын бодлого, хөдөлмөрийн яам гадаадад хөдөлмөрийн гэрээгээр гарч ажиллах шийдвэр гаргана.

9. Хүн амын бодлого, хөдөлмөрийн яам гадаад оронд ажиллах хүч гаргах тухай гэрээ, хэлэлцээрийн нэг хувийг тухайн оронд суугаа Монгол Улсын дипломат төлөөлөгчийн буюу консулын газарт хүргүүлнэ.

10. Ажиллах хүч гаргах тухай гэрээ, хэлэлцээрийн биедэлгэд тухайн оронд суугаа Монгол Улсын дипломат төлөөлөгчийн буюу Консулын газар, монгол иргэдийн асуудал хариуцсан төлөөлөгч хивалт тавина.

11. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаагаа ивуулж байгаа гадаадын байгууллага (гадаад орны дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллага болон өөрийн төсвөөр санхүүждэг гадаадын бусад байгууллага) Монгол Улсын иргэн, тус улсад байнга оршин суугаа гадаадын иргэн (шагаач), аль ч улсын харьяалаалгүй хүнийг хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулахдаа Хүн амын бодлого, хөдөлмөрийн яам болон түүний эрх олгосон байгууллагатай хөдөлмөрийн харилцааны асуудлыг тохиролцож байна.

12. Байгууллага нь хөдөлмөрийн гэрээгээр гадаадад ажиллахаар явах иргэдэд тухайн орны хөдөлмөр, нийгэм хангамж, эрүүл мэндийн тогтолцооны тухай болон бусад хууль тогтоомж, цаг агаар, уур амьсгал, газар нутгийн байршил, үндэстний онцлог, зан заншил зэргийг танилцуулах ажлыг зохион байгуулна.

13. Байгууллага нь хугацаанаас өмнө нунлагдсан буюу даамн хугацаа сунгагдсан гэрээ, хэлэлцээрийн талаар Хүн амын бодлого, хөдөлмөрийн яаманд тухай бүр мэдээлж байна.

Гурав. Ажиллах хүч гаднад орноос авах

1. Байгууллага нь Монгол Улсад тухайн оронтой байгуулсан гэрээ, хэлэлцээрийг үндэслэн шинээр үйлдвэр, цех байгуулах, тоног төхөөрөмж угсрах зэрэг мэргэжлийн ондөр үр чадвар шаардах бөгөөд урьд нь манайд мэргэжилтэн бэлтгэгдээгүй ажил мэргэжлээр хамтын үйлдвэр, аж ахуйн газар, байгууллагад ажиллах хүчийг гадаад орноос авч ажиллуулах тухай гэрээ, хэлэлцээрийг гадаадын үйлдвэр, аж ахуйн газар, иргэдтэй байгуулж болно.

2. Байгууллага нь хөдөлмөрийн гэрээгээр гадаад орноос ажиллах хүч авах гэрээ, хэлэлцээр байгуулахын өмнө үүд хүн ирээд ажиллах аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар, хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаа, тухайн асуудал эрхэлсэн яам, газар болон Хүн амын бодлого, хөдөлмөрийн яамны зөвшөөрлийг бичгээр авна. Энэхүү зөвшөөрлийн авсны дараа ажиллах хүч авч ажиллуулах тухай гэрээ, хэлэлцээрийг байгуулна.

3. Байгуулсан гэрээ, хэлэлцээрийн дагуу аж ахуйн нэгж, байгууллага нь гадаад орноос ирэн чухал мэргэжлийн хүнийг ирүүлэх урилга явуулахдаа дараахь бичиг баримтыг бүрдүүлж Хүн амын бодлого, хөдөлмөрийн яамнаас тодорхойлолт авна. Үүнд:

— гадаад орноос ажиллуулах хүнийг урих талаар тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, дэд бүтцийн газар, олон нийтийн удирдах дээд, төв байгууллагын гаргасан шийдвэр (хэрэв бие даасан пүүс, компани бол аймаг, нийслэлийн Засаг дарга, хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны шийдвэр гаргуулсан байна);

- ирж ажиллах хүний мэргэжлийн үнэмлэхийн хууцаар;
- ажиллах аж ахуйн нэгжийн танилцуулга;
- ирж ажиллах хүний товч намтар.

4. Байгууллага нь зөвшөөрөгдсөн гэрээ, хэлэлцээрийн дагуу гадаад орноос Монгол Улсад ажиллахаар ирсэн хүмүүсийг бүртгүүлэхийг хүссэн албан бичиг, паспортыг оршин сууж амьдрах газрын Засаг даргын тодорхойлолтыг Хүн амын бодлого, хөдөлмөрийн яаманд ирүүлж Монгол улсад ажиллах зөвшөөрөл авна.

5. Гадаадын хөрөнгө оруулалттай байгууллагын болон гадаад орны Засгийн газрын бус (олон нийтийн) байгууллага, аж ахуйн нэгж төлөөлөгчийн газраас тус улсад нээж ажиллуулах зөвшөөрөл авахдаа тухайн аж ахуйн нэгж, төлөөлөгчийн газарт ажиллах гадаадын иргэдийн талаар Хүн амын бодлого, хөдөлмөрийн яамтай урьдчилан тохиролцсон байна.

6. Гадаад орноос хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар ирсэн хүмүүс, тэдгээрийн гэр бүлийн гишүүдийг Хүн амын бодлого, хөдөлмөрийн яамнаас өгсөн тодорхойлолтыг үндэстэн цагдаагийн байгууллага бүртгэнэ.

7. Гадаадын иргэд Монгол Улсад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж амьдрах зөвшөөрлийг жилээр өгч хугацаа дуусмагц анх байгуулсан гэрээ, ажиллуулагч байгууллагын хүсэлтийг үндэслэн сунгана.

8. Гэрээ, хэлэлцээрийн дагуу ажиллах гадаадын иргэдэд Монгол Улсын хөдөлмөрийн болон бусад хууль тогтоомжийг танилцуулах үүргийг хүдээн авагч байгууллага хүлээнэ.

9. Байгууллага нь хугацанаас өмнө нуналсан болон сунгалдсан гэрээ, хэлэлцээрийнхээ талаар Хүн амын бодлого, хөдөлмөрийн яаманд тухай бүр мэдээлж байна.

Дөрөв. Бусад зүйл

1. Байгууллага нь гадаад оронд ажиллах хүч гаргасан бөөлөн гадаад орноос ажиллах хүч авсан тухай мэдээг жил бүүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор гаргаж Хүн амын бодлого, хөдөлмөрийн яаманд ирүүлнэ.

2. Монгол Улсаас хөдөлмөрийн гэрээгээр гадаад оронд ажиллаххаар авсан, тэрчлэн тус улсад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаххаар ирсэн иргэдийн талаархи мэдээг Хүн амын бодлого, хөдөлмөрийн яам нэгтгэж Үндэсний хөгжлийн газар болон холбогдох бусад байгууллагад мэдээлж байна.

3. Ажиллах хүчний төлбөр, нийгмийн даатгалын шимтгэл, эрүүл мэндийн даатгал, бусад хуралмжийн хэмжээг ажиллах хүч гадаад оронд гаргах, гадаад орноос авах тухай гэрээ, хэлэлцээрээр тохиролцож тогтооно.

4. Энэхүү журам болон ажиллах хүч гадаад оронд гаргах, гадаад орноос авах асуудлаар байгуулсан гэрээ, хэлэлцээрийн биелэлтэд Хүн амын бодлого, хөдөлмөрийн яам, Цагдаагийн ерөнхий газар, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаа тус тусын чиг үүргийн дагуу хяналт тавина.

5. Байгуулсан гэрээ, хэлэлцээрийн заалт зөрчигдөх буюу хэрэгжилгүй тохиолдолд Хүн амын бодлого, хөдөлмөрийн яам үг гэрээ, хэлэлцээрийг түдгэлзүүдэл, зогсоох хүртэл арга хэмжээ авна.

6. Ажиллах хүч гадаад оронд гаргах, гадаад орноос авах тухай гэрээ, хэлэлцээр нь Монгол Улсын хууль тогтоомжтой зөрчилдсөн буюу түүнд ерөнхий нөхцөл бүрэн тусгагдаагүй болт хууль тогтоомжтой нийцүүлэх шаардлага тавина.

7. Энэхүү журмын дагуур байгуулсан гэрээ, хэлэлцээрээр Монгол иргэдийг гадаад оронд ажиллуулсан, эрх ашгийг нь хохироосон, журам зөрчиж гадаадын иргэн ажиллуулахаар урьсан, ажиллуулсан иргэн, албан тушаалтанд Монгол Улсын захиргааны хариуцаагын тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1994 оны 3 дугаар
сарын 2-ны өдөр

Дугаар 50

Улаанбаатар
хот

ЗАЛУУЧУУД, БИЕНИЙ ТАМИР, СПОРТЫН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Нутаг дэвсгэртээ залуучуудын талаар явуулах бодлогыг хэрэгжүүлэх болон биений тамир, спортын ажлыг удирдан зохион байгуулах үүргийг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар, хот, хорооны Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанд харууцуулж, одоогийн аймаг, хотын залуучууд, спортын хороог татан буулган залуучуудын асуудал хариуцсан орон тоог аймаг, хотын Хүүхдийн төвд шилжүүлэх, аймаг, хотын биений тамир, спортын материаллаг бааз, батлагдсан төсөвт зардал, цалингийн санд багтаан Биений тамир, спортын төв байгуулан ажиллуулахыг аймгийн Засаг дарга, хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны дарга нарт зохиоорсугэй.

2. Эрүүл мэндийн наманд Спортын зөвлөхийн товчоог 5 хүртэл орон тоотойгоор байгуулаж ажиллуулахыг Эрүүл мэндийн сайд (П. НИЯМДАВАА)-д зохиоорсугэй.

Үүнтэй холбогдуулан «Яам, газрын удирдлагын орон тоо, бүтцийг тогтоох, зардлын төсвийн хязгаар, цалингийн санд батлах тухай» Засгийн газрын 1994 оны 24 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан Эрүүл мэндийн яамны 1994 оны сарын цалингийн санд энэ оны 3 дугаар сарын 15-наас 55,0 мянган төгрөгөөр, 7 дугаар сарын 1-нээс 75,0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсүгэй.

3. Залуучууд, биений тамир, спортын төв, орон нутгийн байгууллагын зохион байгуулалтын өөрчлөлттэй холбогдуулан «Нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай» Засгийн газрын 1993 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 65 дугаар тогтоолын 2-ын б-гийн «Нийгэм эдийн засгийн хэлтэс» гэсэн хэсэгт «Залуучуудын тасаг» гэж нэмж тогтоолын 3-ын е-д заасан «Залуучууд, спортын

хороо» гэснийг «Биеийн тамир, спортын хороо» гэж өөрчлөн, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын орон тоог 3-аар нэмэгдүүлсүгэй.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан «Залуучууд, спортын хорооны палингийн сан, удирдлагын орон тоо, харьяа бэйгууллагын жагсаалт батлах тухай» Засгийн газрын 1991 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 96 дугаар тогтоолын 2 дугаар звалтыг хүчингүй болсонд төөцсүгэй.

Монгол Улсын Ерөнхий сайд

П. ЖАСРАЙ

Хүн амын бодлого,
төдөлмөрийн сайд

Э. ГОМБОЖАВ

Эрүүтэ мэндлийн сайд

П. НИЯМДАВАА

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

1924 оны 4 сарын 15 өдөр

Дугаар 31

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХУУЛИЙН 7 ДУГААР ЗҮЙЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ

Монгол улсын иргэний эрүүл мэндийн даатгалын хуулийн 7 дугаар зүйлийн зарим заалтыг нэгдмэлээр ойлгож зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол улсын Дээд шүүхээс **ТОГТООХ** нь:

Нэг. Монгол улсын иргэний эрүүл мэндийн даатгалын хуулийн 7 дугаар зүйлийн зарим заалтыг дор дурдсанаар тайлбарласугай:

1. Монгол улсын иргэний эрүүл мэндийн даатгалын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын «аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан» гэдэгт манай улсын аж ахуйн нэгж байгууллага болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөрийн болон иргэний гэрээ, сонгууль, томилдолтоор байнгын ажил, албан тушаал эрхэлж байгаа Монгол улсын иргэдийг хамааруулан ойлгоно.

Энэ ойлголтод гадаадад ажиллаж байгаа Монгол улсын дипломат байгууллагын дипломат болон техникийн ажилтан, үйлчилгээний ажиллагсад, аж ахуйн нэгж байгууллагын төлөөлөгчдийн газрын монгол ажилтнууд, түүнчлэн монголд ажиллаж буй гадаадын байгууллагад хөдөлмөрийн гэрээгээр байнга ажиллаж байгаа Монгол улсын иргэд хамаарна.

2. Мөн зүйл, хэсгийн 4 дэх заалтын мэргэжлийн сургуульд суралцагч гэж Монгол улсын боловсролын хуулийн 11 дүгээр зүйлд заасан болзол хангасан мөн зүйлийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу улсын бүртгэлд бүртгэгдсэн албан ёсны замлар боловсрол, мэдлэг эзэмшүүлэх, тэдний мэргэжлийг дээшлүүлж, мэргэшлүүлэх болон эрдмийн зэрэг хамгаалуулах сургалт-эрдэм шинжилгээ үйлдвэрлэлийн байгууллагын өдрийн ангид суралцагчдыг ойлгоно. Үүнд:

Гадаадад мэргэжлийн сургуульд суралцаж байгаа Монгол улсын иргэд нэгэн адил хамаарна.

3. Мөн зүйл хэсгийн 5 дахь заалтын «Тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэн гэдэгт» Монгол улсын хүн амын орлогын албан татварын хуулийн 9 дүгээр зүйлд зласснаар албан татварлас чөлөөлөгдөхөөс бусад 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн, 1 дэх заалтын д, б, мөн зүйл хэсгийн 2, 3, 4 дахь заалт, 5 дахь заалтын б-д заасан байнгын шинжтэй орлогогүй, түүнчлэн орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхэлдэггүй Монгол улсын тэтгэврээр аич байгаа иргэнийг ойлгоно. Тэтгэвэрийн иргэн өрхийнлөө хэрэгцээг хангахад зориулсан гахай, шувуу өсгөх, ногоо жимс тариалах зэрэг өрхийн аж ахуйгаасаа аич байгаа бүтээгдэхүүн нь тэтгэврээс өөр мөнгөн орлогод хамаарахгүй.

Хоёр, Гадаадад ажиллаж суралцаж байгаа иргэдийн иргэний эрүүд мэндийн даалгалын асуудлаар Монгол улсын олон улсын гэрээ байгуулагдсан бол уул олон улсын гэрээг баримтална.

Ерөнхий шүүгч

Шүүгч

Д. ДЭМБЭРЭЛЦЭРЭН

А. ДОРЖГОТОВ

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ТОГТООЛ

1994 оны 4 сарын 28 өдөр

Дугаар 36

Улаанбаатар хот

ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛҮҮДИЙН ЭРХИЙН ТУХАЙ
ХУУЛИЙН ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛҮҮДИЙГ
БҮРТГЭХТЭЙ ХОЛБОГДСОН ЗАРИМ ЗҮЙЛ,
ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ

Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуулийн үйлдвэрчний эвлэлүүдийг улсын бүртгэлд бүртгэхтэй холбогдсон зарим зүйл, хэсгийг нэг мөр обягож зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай Монгол улсын хуулийн 3, 4^д дүгээр зүйлийг дор дурдсанаар тайлбарлаеугай.

1. Хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан «Иргэд хөдөлмөрлөх эрхээ хэрэгжүүлэх, түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах зорилгоор» гэдэгт Монгол улсын Хөдөлмөрийн хуулийн 3 дугаар зүйлд заасан хөдөлмөрийн харилцаанд оролцож байгаа буюу оролцож байсан иргэд аливаа зөвшөөрөл авалгүй, гагцхүү өөрсдийн сайн дурын үндсэн дээр имар нэг ялгаваргүйгээр үйлдвэрчний эвлэлд чөлөөтэй эвлэлдэн нэгдсэнийг ойлгоно.

2. Хуулийн 4^д дүгээр зүйлд заасан «Үйлдвэрчний эвлэлийг бүртгэх» гэдэгт Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, Иргэний хуулийн 18 дугаар зүйлд заасан болзол хангасан өөрөөр хэлбэл «тусгайлан эзэмшсэн эд хөрөнгөтэй, өөрийнхөө нэрийн өмнөөс эд хөрөнгийн ба түүнтэй холбогдсон эд хөрөнгийн бус эрх олох, үүрэг бий болгох, шүүхэд нэхэмжлэгч харууцагч байж чадах» шаардлага хангасан үйлдвэрчний эвлэлүүдийг улсын бүртгэлд бүртгэхийг ойлгоно.

3. Хуульд заасан хуулийн этгээдийн шаардлага хангаагүй Үйлдвэрчний эвлэлүүд нь сайн дурын үндсэн дээр нэгдсэн үйлдвэрчний эвлэлүүдийн анхан шатны холбооны бүтэц, зохион байгуулалтын нэгж болон улсын бүртгэлд бүртгүүлж болно. Тухайлбал сумын нутаг дэвсгэрт буюу томоохон аж ахуйн нэгж, байгууллагын салбар, нэгжүүдэд зохион байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байгаа үйлдвэрчний эвлэлүүд нь тухайн сумын буюу аж ахуйн нэгж байгууллагын үйлдвэрчний эвлэлийн холбооны зохион байгуулалтын нэгж болон улсын бүртгэлд бүртгүүлж болно.

4. Үйлдвэрчний эвлэлүүд, түүний дотор бүтэц зохион байгуулалтын нэгжийг нэгтгэн бүртгүүлсэн болон багтсан үйлдвэрчний эвлэлүүд улсын бүртгэлд бүртгүүлсэн үеэс хууль тогтоомжид заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ. Хэрэв үйлдвэрчний эвлэлүүд холбоонд нэгдэн улсын бүртгэлд бүртгүүлсэн бол бүтэц, зохион байгуулалтын нэгж болон бүртгүүлсэн үйлдвэрчний эвлэлүүд хамтран харууцлага хүлээнэ.

5. Мөн хуулийн 4^д дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2-т заасан «Үйлдвэрчний эвлэлийн дүрэм» гэдгийг Үйлдвэрчний эвлэлүүд бүр өөрийн дүрэмтэй байхыг ойлгоно. Хэрэв үйлдвэрчний эвлэлүүд нь өөрийн тусгай дүрэмтэй байх шаардлагагүй бөгөөд нэгдэн орсон холбооны дүрмийг дагаж мөрдөх нь зүйтэй гэж үзсэн бол улсын бүртгэлд бүртгүүлэхдээ энэ тухай

бүх гишүүдийн буюу тэргүүлэгчдийн хурлын шийдвэрийг өргөлдөлд хавсаргана. Энэ тохиолдолд Үйлдвэрчний эвлэлүүдийн нэгдсэн дүрмийг тухайн үйлдвэрчний эвлэлүүдийн дүрэмд тооцох бөгөөд тухайн үйлдвэрчний эвлэлүүд уулз дүрмийг дагаж мөрдөх үүрэг хүлээнэ. Хэрэв үйлдвэрчний эвлэлийг шинээр байгуулахдаа холбооны дүрмийг бүх гишүүдийн болон тэргүүлэгчдийн хуралдаанаар хүлээн зөвшөөрсөн бол энэ зүйлд заасны нэгэн адил дүрэмтэйд тооцно.

6. Хэрэв Үйлдвэрчний эвлэлүүд нь сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдэж, холбооны салбар нэгж болон үйлдвэрчний эвлэлүүдийн холбооны дүрмийг өөрийн дүрэмд тооцон бүртгүүлэхийг зөвшөөрөхгүй бол хууль тогтоомжид заасан болзлыг бүрэн хангасны үндсэн дээр бие даан улсын бүртгэлд бүртгүүлэнэ.

Ерөнхий шүүгч

Шүүгч

Д. ДЭМБЭРЭЛЦЭРЭН

Д. ТУНГАЛАГ

МОНГОЛ УЛСЫН СТАТИСТИКИЙН ТУХАЙ ХУУЛИЙН АГУУЛГА, ОНЦЛОГ

Энэ хууль нь Монгол улсын статистикийн тухай анхны хууль мөн.

Зах зээлийн эдийн засагт шилжинэ байгаа өнөө үед статистикийн мэдээллийн хэрэгцээ ихээхэн өсч, түүнд тавих шаардлага ч нэмэгдэж байна. Үнэн бодит мэдээлэлгүйгээр төр, засаг улс орныхоо эдийн засаг, нийгмийн байдалд эв дүгнэлт өгч үйл ажиллагаагаа зохицуулах, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага ч зах зээлийн хэрэгцээ шаардлагын өнөөгийн байдал, маргаанын төлөнийг төсөөлж үйл ажиллагаагаа явуулахад ихээхэн бэрхшээлтэй тулгарна. Зах зээл хөгжсөн орнууд статистик мэдээллийн үйл ажиллагааны хүрэн дэлх харилцааг хуулиар зохицуулж, мэдээллийн ил тод байдлыг хангах, үнэн эв байлгах талаас нь их анхаардаг.

Манай орны хувьд статистикийн үйл ажиллагааг өнөө хүртэл нам, төрийн хавсарсан болон дангаар гаргасан тогтоол шийдвэрүүдээр зохицуулж ирсэн. Ардчилал шинэчлэл, зах зээлийн эдийн засгийн өнөөгийн шинэ нөхцөлд нийгэм, эдийн засгийн амьдралын бүх хүрээнд гарч байгаа үндсэн харилцаануудыг гагцхүү хуулиар зохицуулах шаардлагын дагуу Монгол Улсын Статистикийн тухай энэхүү анхны хуулийг Монгол улсын Их Хурлаас батлан гаргалаа.

Энэ хууль гарах болсон шаардлага, хуулиар зохицуулах харилцаа.

Улс, доршгооллын өмч задран өмчийн олон хэлбэр буй болж байгаа өнөөгийн шинэ нөхцөлд аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс статистикийн мэдээллийн талаар хүлээх үүрэг хариуцлага тодорхойгүй болж сүүлийн жилд улс орны бүх хэрэглэгчдийг статистик мэдээлэлээр хангах асуудалд ихээхэн хүндрэл учирч байна. Ийм учраас улс орны эдийн засаг нийгмийг хөгжүүлэх бодлогыг боловсруулахад судалгаа шинжилгээний үндэслэл болох статистик мэдээллийг бүрдүүлэх, боловсруулах, түүгээр хэрэглэгчдийг хангах, статистикийн байгууллага болон статистик мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгохтой холбогдон үүсэх харилцааг хуулиар зохицуулах шаардлага гарч байна.

Энэ хуулиар Монгол улсын статистикийн байгууллагын болон статистикийн мэдээллийн нэгдсэн тогтолцоо, үйл ажилла-

гааны зарчим статистикийн байгууллага, түүнчлэн Монгол улсын иргэн, гадаадын иргэн, харьяаладгүй хүн, Монгол Улсын хуулийн этгээд болох аж ахуйн нэгж, байгууллага (статистикийн мэдээлэгч) статистикийн мэдээллийн талаар эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхойлж, эдийн засаг, нийгмийн амьдралын бодит байдлыг статистикийн аргаар судлан төр, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг статистикийн мэдээллээр хангах явцад үүсэх харилцааг зохицуулна.

Статистикийн үйл ажиллагаа нь шинжлэх ухааны үндэслэл бүхий нэгдсэн аргачлал, үнэн зөв хөтлөгдсөн анхдагч бүртгэл дээр тулгуурласан бөгөөд цаг хугацааны шаардлагыг хангасан үнэн бодитой байх зарчим дээр явагдах ёстой гэдгийг хуульчилж өглөө.

Хуулийн хоёрдугаар бүлэгт статистикийн мэдээллийн тогтоцоо, түүний ангиллыг тодорхойлсон нь энэ хүрээний үйл ажиллагаанд гарах харилцааг зохицуулахад чиглэгдсэн шинэ асуудлын нэг мөн.

Албан ёсны болон албан ёсны бус статистикийн мэдээлэл.

Манай улсад эдийн засаг, нийгмийн амьдралын бодит байдлыг судлах үндсэн тулгуур нь албан ёсны статистикийн мэдээллийн систем болохоос гадна энэ хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу иргэд, аж ахуйн нэгж, байгууллага гэрээ, хэлцлийн үндсэн дээр бусад этгээдээс статистикийн мэдээлэл авч судалгаа шинжилгээ хийх хэлбэрээр албан ёсны бус статистикийн үйл ажиллагаа эрхэлж болох тухай анх удаа хуульчилан тогтоож байна.

Албан ёсны статистик мэдээллийг ямар үзүүлэлтээр ямар байгууллага хариуцаж гаргах, улсын хэмжээнд явагдах тооллогыг ямар асуудлаар хэдий хугацаанд явуулж байх зэргийг хуулиар тогтоолоо.

Төв засагас болон статистикийн төв байгууллагаас тогтоосон журмын дагуу гаргах ёстой албан ёсны статистикийн мэдээлэл нь төвлөрсөн болон төвлөрсөн бус хэлбэртэй байх тухай заалаа. Төвлөрсөн мэдээлэлд сум, дүүрэг, баг, хороо, аж ахуйн нэгж, байгууллагаас сум, дүүрэг, аймаг, нийслэлийн статистикийн асуудал эрхэлсэн байгууллагаар дамжин статистикийн төв байгууллагад нэгтгэгддэг мэдээлэл хамаарна.

Төвлөрсөн бус албан ёсны статистикийн мэдээлэлд аймаг, нийслэл, сум, дүүргийн засаг даргаас нутаг дэвсгэрийнхээ

удирдлагын үйл ажиллагаанд хэрэглэхээр статистикийн төв байгууллагаас ямар нэгэн зооноороо авахгүйгээр бие даан доод шатныхаа байгууллагаас авч байгаа мэдээлэл болон нам, тусгай газар, аж ахуйн нэгж байгууллагад улс орны хэмжээгээр хэдэтэйгдэл давхардалгүй, тус тус зүй байх үүдэлээс статистикийн төв байгууллагаас хянуулж зооноорүүлсэн үзүүдэлт, аргачлалаар гаргасан мэдээлэл хамаарагдана. Орон нутгийн удирдлагад статистикийн мэдээллийг нутаг дэвсгэртээ бие даан авч байх эрх олгож байгаа нь тэдний удирдах үйл ажиллагааг нь тухайн нутгийн онцлогоос уртан гларах өөрмөц шаардлагатай мэдээллээр хангах бодомжийг өргөсгөж өгөхөд чиглэгдэж байгаа юм.

Статистикийн мэдээллийн талаарх итгэлтэл.

Статистикийн мэдээлэл үнэн зөв байх асуудал юуны урьд статистикийн анхдагч мэдээлэгчээс статистикийн ажилтан, байгууллагад хэр нгэлтэй байхад шалтгаална. Нөгөө талаас статистикийн байгууллага ч мэдээллийн нууцыг нь хадгалгах зэрэг асуудлаар статистикийн мэдээлэгчдийн итгэл найдварыг алдахгүй байхын төлөө ажиллах үүртай.

Энэ хэрцүүлээг статистикийн мэдээлэгчдийн эрх, үүрэг, статистикийн мэдээллийн нууцыг хадгалахтай холбогдсон асуудлыг авч үзсэн хуулийн зохих зүйл, ажилгаар зохицуулах ёстой.

Хуулийн 8 дугаар зүйлд зааснаар статистикийн мэдээлэгч нь статистикийн мэдээ, тайлан, судалгаа гаргахад шаардагдах анхдагч бүртгэл хөндөх, статистикийн мэдээ, тайлан судалгааг зохих үзүүдэлт аргачлалын дагуу тогтоосон хугацаанд нь үнэн зөв гаргаж өгөх, улсын тооллогод хамрагдах, аж ахуйн нэгж байгууллагын хувьд зохих журмын дагуу регистрийн дугаар авах, албан ёсны статистикийн мэдээллийн өөрийнхөө шүүд харьцах холбогдох дээд байгууллагад зөвлөаараа хүргэх үүрэгтэй. Статистикийн мэдээлэгч нь мэдээ, тайлан, судалгааны үзүүдэлт аргачлалыг боловсронгуй болгох талаар статистикийн байгууллагад санал оруулах, энэ хуульд зааснаас бусад тохиолдолд статистикийн төв байгууллагаас батлаагүй буюу зооноорөөгүй үзүүдэлт, аргачлалаар мэдээ, тайлан, судалгаа гарган өгөхөөс татгалзах, өөрийн мэдээллийн нууцыг задруулахгүй байхыг зохих этгээдээс

шиардах, статистикийн байгууллагаас гаргасан нийтлэг дүн, мэдээлэлтэй танилдах эрхтэй.

Хуулийн 16 дугаар зүйлийн 3-д зааснаар "Боловсруулалт нь албан ёсоор мэдээлэх хэмжээнд хүрээгүй байгаа, мөн үндэсний эрх нийцтэй холбоотой гэж зохих эрх бүхий байгууллагаас нууцлсан эсхүл иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын нууцад хамарлах мэдээллийн нууцыг задруулах, нийгэд мэдээлэхийг хориглоно.

Статистикийн байгууллагын тогтолцоо

Монгол Улсын статистикийн байгууллагыг засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийг түшиглэсэн үндсэн тогтолцоотой байх зарчмыг баримталсан юм.

Хуулийн 10 дугаар зүйлд зааснаар Статистикийн байгууллагын үндсэн тогтолцоо нь статистикийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэх зорийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн засаг даргын Тамгын газрын статистикийн хэлтэс (ажилтан)-ээс бүрдэнэ. Яам, тусгай газар чиг үүргийнхээ дагуу статистикийн үйл ажиллагааг эрхлэнэ.

Статистикийн төв байгууллага, түүний бүрэн эрх, түүнд аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг даргын статистикийн мэдээллийн талаарх бүрэн эрхийг энэхүү хуулийн 11, 13, 14 дүгээр зүйлүүдэд хуульчилан заасан байна.

Статистикийн мэдээлэлд таних хяналт, статистикийн хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

Албан ёсны статистик мэдээллийн хамраат, үнэн зөв, шуурхай байдалд Улсын статистикийн байцаагч хяналт тавина. Энэ хуулийн 12 дугаар зүйлд статистикийн байцаагчийн бүрэн эрхийг хуульчилан тогтоожээ.

Статистикийн тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол зохих журмын дагуу захиргааны хариуцлага хүлээлгэнэ. Улсын статистикийн байцаагчдаас иргэд, албан тушаалтанд ногдуулсан захиргааны нийтлэлийн талаар гарсан гомдлыг шүүхийн журмаар шийдвэрлэнэ.

Статистикийн мэдээллийг хууль бусаар ашиглахыг энэ хуулиар хориглосон.

Энэ хуулийн 16 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт зааснаар холбогдох этгээдээ элэмшиж буй давуу эрхээ хэтрүүлэн ху-

вийн ашиг хөгжөө олох зорилгоор статистикийн мэдээллийг ашиглахыг болон хэрэглэгчээ; албан ёсны статистикийн мэдээлэл, судалгааны дүнг дур мэдэн өөрчлөх, эсвэрлахыг хориглосон болно.

Статистикийн тухай энэхүү хууль нь манай улсын статистикийн мэдээллийн үйл ажиллагааны хүрээнд дэх бүх харилцааг зохицуулахад чиглэгдсэн 5 бүлэг 17 зүйлтэй.

Улсын их Хурлын гишүүн Р. ЦАГААНХҮҮ

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ:

Ерөнхий зөвлөгч **Н. Ринчиндорж**
Нэрийн бичгийн дарга **Сам. Жаргалсайхан**
Гийжүүд **Т. Балсансүрэн**
Ч. Баянуу

Техник редактор **Т. Сарантула**
Уншиж хянасан **Сам. Жаргалсайхан**
Б. Янжинпалам

Үйлдвэрт шилжүүлсэн 1994 оны 5-р сарын
7-нд Өрвэлэнд 1994 оны 5-р сарын 7-нд. Хэв-
лэвэтэд 1994 оны 5-р сарын 27-нд. Хянагчийн
хуудас 6.5. Хэвлэсэн тоо 4370 ширхэг.

Засгийн газрын хэвлэх үйлдвэр